



БИЗНЕС ДЭХ ХҮНИЙ ЭРХИЙГ МЭДРЭМЖТЭЙ МЭДЭЭЛЭХ НЬ ГАРЫН АВЛАГА



Улаанбаатар хот
2025 он

ЕВРОПЫН ХОЛБООНЫ САНХҮҮЖИЛТТЭЙ НҮБ-ЫН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН
ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ “ӨӨРЧЛӨЛТИЙН ЭЛЧ ТӨЛӨӨЛӨГЧИД: ХАРИУЦЛАГАТАЙ БИЗНЕСИЙН
ТӨЛӨӨХ ЗАЛУУС БА ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ” ТӨСӨЛ

“БИЗНЕС ДЭХ ХҮНИЙ ЭРХИЙГ МЭДРЭМЖТЭЙ МЭДЭЭЛЬЕ”

ГАРЫН АВЛАГА

Зохиогчийн эрх © НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр 2025

Энэхүү гарын авлагыг “Өөрчлөлтийн элч төлөөлөгчид: Хариуцлагатай бизнесийн төлөөх залуус ба хэвлэл мэдээлэл” төслийн хүрээнд Хэвлэл Мэдээллийн Зөвлөл ТББ боловсруулав. Гарын авлага дахь фото зураг, постеруудыг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн төслийн мэдээллийн сангаас болон интернэт дэх нээлттэй эх сурвалжаас ашиглав.

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн тухай

НҮБХХ нь ядуурал, тэгш бус байдал болон уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй шударга бус байдлыг эцэслэх зорилго бүхий Нэгдсэн Үндэстний Байгууллагын тэргүүлэх агентлаг юм. Дэлхийн 170 орны түншлэгчид болон мэргэжилтнүүдийн өргөн цар хүрээт хамтын ажиллагааны дүнд эх дэлхий, хүн бүрийн төлөө хөгжлийн урт хугацааны, цогц шийдлийг бий болгоход улс үндэстнүүдийг дэмжин ажилладаг. Дэлгэрэнгүйг <https://www.undp.org> хаягаар авна уу.

Ерөнхий мэдэгдэл

Гарын авлагын агуулга зөвхөн зохиогчдын үзэл бодлыг илэрхийлж байгаа бөгөөд Европын Холбоо болон НҮБХХ эсвэл хамтран хэвлүүлэгч байгууллагын албан ёсны бодлого, байр суурийг илэрхийлээгүй. Энэхүү гарын авлагад ашигласан мэдээллийн үнэн зөв эсэх, тухайн материалыг ашигласны улмаас гарах үр дагаварт Европын Холбоо, НҮБХХ болон хамтран хэвлүүлэгч байгууллага хариуцлага хүлээхгүй болно. Энэхүү баримт бичигт тодорхой нутаг дэвсгэр, газарзүйн бүсийг нэрлэхдээ «улс» гэсэн нэр томъёог ашигласан нь ямарваа нэгэн газар нутгийн эрх зүйн болон бусад статусын талаарх үзэл бодол, утга агуулгыг илэрхийлээгүй болно.

Гарын авлагад дурдсан тодорхой компаниудыг НҮБХХ-ээс бусад ижил төстэй, дурдагдаагүй компаниудаас илүүд үзэж, дэмжиж байна гэсэн утга агуулаагүй болно. НҮБХХ-ийн бүс вэбсайтад нийтлэх эсвэл бусад хэвлэлд дурдах нь НҮБХХ-өөс дэмжиж байгаа, эсвэл тухайн эх сурвалжид агуулагдсан мэдээллийн үнэн зөв байдал, илэрхийлсэн үзэл бодлыг баталгаажуулж байна гэсэн утга агуулаагүй болно. Энэ гарын авлагад багтсан мэдээлэл нь хууль зүйн зөвлөгөө өгөх зорилготой биш бөгөөд зөвхөн ерөнхий мэдээлэл олгох зориулалттай.

ӨМНӨХ ҮГ

Энэхүү гарын авлагыг Европын Холбооны санхүүжилтээр, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр (НҮБХХ)-ийн хэрэгжүүлж буй “Өөрчлөлтийн элч төлөөлөгчид: Хариуцлагатай бизнесийн төлөөх залуус ба хэвлэл мэдээлэл” төслийн хүрээнд Хэвлэл Мэдээллийн Зөвлөл (ХМЗ) боловсруулан танилцуулж байна.

2000 оноос хойш, тэр дундаа сүүлийн арваад жилийн хугацаанд хөрөнгө оруулагчид, иргэд болон Засгийн газрын зүгээс бизнесийн салбарт тавьдаг шаардлага, хүлээлт ихээхэн өөрчлөгдөж, “хариуцлагатай бизнес”-ийн тухай яриа хэлэлцүүлэг олон улсын түвшинд эрчимтэй өрнөх болов. Бизнесийн байгууллагууд ашиг төвтэй уламжлалт арга барилаас илүүтэй байгаль орчин болон нийгэмд үзүүлэх нөлөөлөл зэрэг санхүүгийн бус хүчин зүйлсийг үйл ажиллагаандаа харгалзан үздэг боллоо. НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс 2011 онд баталсан “Бизнес дэх хүний эрхийн удирдах зарчмууд”-д заасны дагуу бизнесийн байгууллагууд өртгийн сүлжээ болон ханган нийлүүлэгчдийнхээ үйл ажиллагаанаас үүдэх хүний эрх болон байгаль орчинд үзүүлэх аливаа бодит болон болзошгүй сөрөг нөлөө, зөрчил гарахаас урьдчилан сэргийлж, бууруулж, арилгаж хариуцлагатай ажиллах шаардлагатай болж байна.

Монгол Улсын хувьд хариуцлагатай бизнесийг түгээн дэлгэрүүлж, Тогтвортой Хөгжлийн Зорилгуудыг хэрэгжүүлэх үүрэг амлалтаа дахин бататгаж 2023-2027 он хүртэл хэрэгжүүлэх “Бизнес дэх хүний эрх” үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөг Засгийн Газрын 231 дүгээр тоот тогтоолоор баталсан байдаг. НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр нь хүний эрхийг хамгаалах үйл ажиллагааныхаа хүрээнд улс орнууд болон компаниудыг “Бизнес дэх хүний эрхийн удирдах зарчмууд”-ыг хэрэгжүүлэхэд тууштай дэмжлэг үзүүлсээр ирсэн. “Бизнес дэх Хүний эрх” (B+HR) хөтөлбөрийг анх 2016 онд Азийн улс орнуудад хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд түүнээс хойш НҮБХХ нь сургалт, зөвлөлдөх уулзалт, бүс нутгийн жилийн чуулган зэрэг олон талт арга хэмжээг зохион байгуулж, бизнесийн үйл ажиллагаанаас хүний эрх, байгаль орчинд үзүүлж буй нөлөөг анхаарах, хариуцлагатай бизнесийн ойлголт, дадлыг түгээн дэлгэрүүлэх чиглэлд манлайлан ажиллаж байна.

Сэтгүүл зүйн хэвлэл мэдээллийн салбарынхан аливаа сэдвийг сонгохдоо тухайн мэдээлэл нь хүмүүсийн амьдралд, тухайлбал үйлдвэр, ажлын байр, дэлгүүр, уурхай, газар тариалан зэрэгт ажиллагсдын бодит нөхцөлд хэрхэн нөлөөлж болохыг анхаарч үзэх нь чухал юм. Хэвлэл мэдээлэл нь үйлдвэрлэлийн ослын буруутай этгээдүүдийг хариуцлага хүлээлгэхэд эсвэл ослоос амьд үлдсэн ажилтнуудад


нөхөн төлбөр олгох асуудлыг анхаарлын төвд авчирч, ирээдүйд илүү шударга, илүү аюулгүй хөдөлмөрийн орчин бүрдүүлэхэд бодит хувь нэмэр оруулж чадна. Ийм төрлийн мэдээлэл олон нийтийн хүртээл болж байж бодит өөрчлөлт авчрах боломжтой бөгөөд үүнд хэвлэл мэдээллийн салбарын оролцоо чухал үүрэгтэй.

Хэвлэл мэдээлэл нь хариуцлагагүй, хүний эрх зөрчсөн болон байгаль орчинд хор нөлөөтэй бизнесийн үйл ажиллагааг шүүмжлэхийн зэрэгцээ ёс зүйтэй, хариуцлагатай, ил тод, хүний эрхийг хүндэтгэж, байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллөө бууруулахыг зорьж байгаа бизнесийн сайн туршлагыг олон нийтэд таниулахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Гэвч сүүлийн үед зарим редакц сошиал хуудсаараа “шууд дамжуулалт” нэрийн дор үйл явдлыг шуурхай дамжуулж буй ч үүний цаана мэргэжлийн нягтлан шалгах ур чадвар дутагдах, ёс зүйн наад захын хэм хэмжээ алдагдахад хүрч байна. Тухайлбал, эрэн сурвалжилга хэмээн албан байгууллага руу зөвшөөрөлгүй дайрч орох, эх сурвалждаа хүндэтгэлгүй хандах, үр дагавар хүртэгсдийн өнцгөөс нэг талын үзэл бодлоор албан байгууллага, хувь хүнийг буруутгах, нягталж шалгасан баталгаатай баримтгүйгээр бизнесийн нэр хүнд, итгэл үнэмшилд нөлөөлөх зэрэг алдаа дутагдал ажиглагдсаар байна.

Иймээс хэвлэл мэдээллийн байгууллагууд, сэтгүүлчид бизнесийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээлэл бэлтгэн түгээхдээ мэргэжлийн болон ёс зүйн хэм хэмжээгээ чанд даган мөрдөх, хэвшмэл ойлголтуудаа засах, нийтлэл нэвтрүүлэгтээ хүний эрхийг хүндлэх, мэдрэмжтэй мэдээлэхэд суралцах шаардлага тулгарч буй юм. Бизнес дэх хүний эрхийг хүндэтгэж, байгаль орчинд ээлтэй, мэргэжлийн ёс зүйн болон жендэрийн мэдрэмжтэй мэдээлж сурвалжлахад энэхүү гарын авлага сэтгүүлч, редакторууд, сэтгүүл зүй, мэдээлэл харилцаа болон нийгмийн шинжлэх ухааныг судалж буй оюутан залууст тус болно хэмээн итгэж байна.

Уг гарын авлагыг НҮБХХ-өөс гаргасан [Reporting Business and Human Rights: A Handbook for Journalists, Communicators and Campaigners](#) (2021) дээр тулгуурлаж бэлтгэсэн бөгөөд зарим хэсгийг нь шууд орчуулж, холбогдох Монгол жишээ кэйсийг шигтгэн оруулсан болно.

ХМЗ-ийн Гүйцэтгэх захирал



Г.Гүнжидмаа

АГУУЛГА

БҮЛЭГ 1. ХАРИУЦЛАГАТАЙ БИЗНЕСИЙН СУУРЬ ЗАРЧИМ: ХҮНИЙ ЭРХ

1.1	БИЗНЕС ДЭХ ХҮНИЙ ЭРХ: ХАМГААЛАХ, ХҮНДЭТГЭХ, СЭРГЭЭХ	7
1.2	БИЗНЕС ДЭХ ХҮНИЙ ЭРХ: ҮЙЛДВЭРЛЭЛЭЭС ҮНЭТ ЗАРЧМУУД ХҮРТЭЛ	7
1.3	ХАРИУЦЛАГАГҮЙ БИЗНЕС: ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨРЧЛҮҮД	8
1.4	АШИГ БА ЭРХИЙН ЗӨРЧИЛ: ХҮНИЙ ЭРХЭД УЧРАХ ЭРСДЭЛ	9
1.5	БИЗНЕС ДЭХ ХҮНИЙ ЭРХ: ТОЙРОГ ЭДИЙН ЗАСАГ	11
1.6	БИЗНЕС ДЭХ ХҮНИЙ ЭРХ: ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ	12
1.7	БИЗНЕС ДЭХ ХҮНИЙ ЭРХ: ЖЕНДЭР	13
1.8	БИЗНЕС ДЭХ ХҮНИЙ ЭРХ: ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ	14

БҮЛЭГ 2. БИЗНЕС ДЭХ ХҮНИЙ ЭРХИЙН АСУУДЛААР БҮТЭЭЛ ТУУРВИХ, СУРВАЛЖЛАХ ПРАКТИК ЗӨВЛӨМЖ

2.1	БИЗНЕС ДЭХ ХҮНИЙ ЭРХ (В+НН) -ИЙН ЁС ЗҮЙН ДҮРМҮҮДЭЭ ТОХИРОХ	19
2.2	ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БҮТЭЭЛ БА КАМПАНИТ АЖЛЫН ҮР НӨЛӨӨГ САЙЖРУУЛАХ	21
2.3	БИЗНЕС ДЭХ ХҮНИЙ ЭРХ (В+НН) -ИЙН “ХАДААС” НИЙТЛЭЛ БИЧИХ НЬ	23
2.4	БИЧИХ УР ЧАДВАРАА ХӨГЖҮҮЛЭХ НЬ	24
2.5	БИЧВЭРИЙГ НЯГТЛАХ ЖАГСААЛТ	24
2.6	АЮУЛГҮЙ БАЙДЛАА ШАЛГАХ ЖАГСААЛТ	26
2.7	ЭХ СУРВАЛЖИЙН СҮЛЖЭЭГЭЭ ӨРГӨТГӨХ 10 ЗӨВЛӨМЖ	28

3. АШИГЛАСАН БОЛОН НЭМЭЛТЭЭР СУДАЛЖ БОЛОХ ЭХ СУРВАЛЖУУД

ХАВСРАЛТ 1. БИЗНЕС ДЭХ ХҮНИЙ ЭРХИЙН ЧИГЛЭЛЭЭР БИЧИЖ НИЙТЛЭХЭД БАРИМТЛАХ УДИРДАМЖИЙН ЗАГВАР ЖИШЭЭНҮҮД	30
ХАВСРАЛТ 2. БИЗНЕС ДЭХ ХҮНИЙ ЭРХИЙН СЭДЭВТ ХАМААРАХ НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР	37
ХАВСРАЛТ 3. БИЗНЕС ДЭХ ХҮНИЙ ЭРХИЙН ХҮРЭЭНД НИЙТЛЭГДСЭН ЭРЭН СУРВАЛЖЛАХ СЭТГҮҮЛ ЗҮЙН БҮТЭЭЛИЙН ЖИШЭЭ	54

БҮЛЭГ

1

ХАРИУЦЛАГАТАЙ БИЗНЕСИЙН СУУРЬ ЗАРЧИМ БА ХҮНИЙ ЭРХ

- БИЗНЕС ДЭХ ХҮНИЙ ЭРХ:
"ХАМГААЛАХ, ХҮНДЭТГЭХ, СЭРГЭЭХ"
- БИЗНЕС ДЭХ ХҮНИЙ ЭРХ:
ҮЙЛДВЭРЛЭЛЭЭС ҮНЭТ ЗАРЧМУУД
ХҮРТЭЛ
- ХАРИУЦЛАГАГҮЙ БИЗНЕС: ХҮНИЙ
ЭРХИЙН ЗӨРЧЛҮҮД
- АШИГ БА ЭРХИЙН ЗӨРЧИЛ: ХҮНИЙ
ЭРХЭД УЧРАХ ЭРСДЭЛ
- БИЗНЕС ДЭХ ХҮНИЙ ЭРХ: ТОЙРОГ
ЭДИЙН ЗАСАГ
- БИЗНЕС ДЭХ ХҮНИЙ ЭРХ: ХӨДӨЛМӨР
ЭРХЛЭЛТ
- БИЗНЕС ДЭХ ХҮНИЙ ЭРХ: ЖЕНДЭР
- БИЗНЕС ДЭХ ХҮНИЙ ЭРХ: ХЭВЛЭЛ
МЭДЭЭЛЭЛ

ХАРИУЦЛАГАТАЙ БИЗНЕСИЙН СУУРЬ ЗАРЧИМ: ХҮНИЙ ЭРХ

“ Human Rights rely upon our ability to empathize with strangers.

Эх сурвалж: *Inventing Human Rights: A History, Lynn Hunt*

Линн Хант бол хүний эрхийн түүхэн ойлголтыг гүнзгийрүүлэн шинэчилсэн нэрт түүхч хүн. Тэрээр роман, захидал, утга зохиолын бүтээлүүд дэх сэтгэл зүйн холбоо харилцаануудыг судалж, хүмүүс хэрхэн бусдыг танихгүй атлаа өөрийн адил эрхтэй хүн гэж энэрч, төсөөлж, ойлгож, өгүүлж эхэлсэн талаар онцолсон байдаг. Хүний эрх хэмээх ойлголт нь тогтсон үнэн, байгалийн зүй тогтол бус харин соёл иргэншлийн үр дүнд бий болж, хөгжсөн ололт дэвшил гэдгийг Линн Хант тйалбарласан. Өнөөдөр бид түүний ачаар хүний эрхийн талаар өөр хоорондоо ярилцаж, амьдралдаа хэрэглэж, цаашид хөгжихөд нь үүрэг оролцоотой байна.

БИЗНЕС ДЭХ ХҮНИЙ ЭРХ: “ХАМГААЛАХ, ХҮНДЭТГЭХ, СЭРГЭЭХ”

Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ) Бизнес дэх Хүний эрхийг «Хамгаалах, Хүндэтгэх, Сэргээх» (Protect, Respect and Remedy) гэсэн гурван суурь зарчмаар илэрхийлдэг болоод 14 жил болж байна. Энэ хүрээнд улс орнуудын Засгийн газрууд бизнесийн байгууллагуудаас хүний эрхийн магадлан шинжилгээ хийх, ил тод тайлан гаргахыг шаарддаг болсон. Нөгөө талаас, хөрөнгийн бирж, санхүүгийн байгууллагууд компаниудыг хүний эрхийн эрсдлийг илүү нээлттэй тайлагнах шаардлага тавьж, санхүүжилт олгох шалгуур болгож байна. Нууц оффшор данстай, ажилчдадаа хүрэлцэхүйц цалин өгдөггүй, үйл ажиллагаа нь байгаль орчинд хор хохирол учруулдаг компаниудад төр засгаас татаас өгөх, татварын хөнгөлөлт үзүүлэх, гамшгийн үед татвар төлөгчдийн мөнгөөр дэмжих нь зохистой эсэх асуудлыг хөндөж, энэ чиглэлээр үнэлгээ хийлгэсэн байхыг шаарддаг болов.

Цар тахлаас хойш бизнес эрхлэгчид санхүүгийн ашиг орлогоос илүүтэйгээр эх дэлхий, улс орондоо оруулж болох хувь нэмэр, шийдвэрлэж болохуйц зөрчлүүдээ арилгахыг эрмэлздэг болсон. Тиймээс ч бизнесийн үйл ажиллагаандаа хүний эрхийн магадлан шинжилгээ хийж, чадавхижуулах сургалтаар дамжуулан аливаа зөрчил, хүний эрхийн эрсдлээ арилгаж, сайжруулахад нь НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс төр засаг, бизнесийн байгууллагуудад дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.



БИЗНЕС ДЭХ ХҮНИЙ ЭРХ: ҮЙЛДВЭРЛЭЛЭЭС ҮНЭТ ЗАРЧМУУД ХҮРТЭЛ

Бизнес дэх Хүний эрхийг хангахад үсрэнгүй өөрчлөлт гарахад нөлөөлсөн дараах түүхэн нөхцөл байдал, үйл явдлууд үйлдвэрлэлээс үнэт зарчимд хүрэх замыг нээсэн юм.



ХАРИУЦЛАГАГҮЙ БИЗНЕС: ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨРЧЛҮҮД

Хариуцлагагүй бизнесээс улбаатай хүний эрхийн зөрчил дэлхийн өнцөг булан бүрт байсаар байгаатай эвлэрч дуугүй өнгөрч болохгүй.

Бизнес дэх хүний эрхийн түгээмэл зөрчлийг тивээр харуулбал:

- **Африк:** Уул уурхай, газрын маргаан, зэвсэгт бүлэглэлүүдийг санхүүжүүлэх зөрчлүүд
- **Ази:** Оёдлын болон технологийн салбарт хөдөлмөрийн мөлжлөг, албадан хөдөлмөрийн зөрчлүүд
- **Латин Америк:** Байгаль орчныг сүйтгэх хүний эрхийн хамгаалагчид руу халдах зөрчлүүд
- **Ойрх Дорнод:** Цагаач ажилчдын хөдөлмөрийн мөлжлөг, үйлдвэрчний эвлэл байгуулах орчин, боломж хязгаарлагдал байдаг зөрчлүүд
- **Европ ба Хойд Америк:** Татвараас зугтах, нийлүүлэлтийн сүлжээгээр дамжсан зөрчлүүд байсаар байна.

Бизнес дэх хүний эрхийн зөрчил аль тивд хамгийн түгээмэл гардаг вэ?

Африк	Ази
	
Европ	Ойрхи Дорнод
	

Бизнес дэх хүний эрхийн түгээмэл зөрчлийг салбараар харуулбал:

- **Хувцас дизайн, оёдол үйлдвэрлэл:** Цалингийн хэмжээ хангалтгүй, аюултай ажлын орчин, хүүхдийн хөдөлмөр, албадан хөдөлмөр эрхлэлт Өмнөд ба Зүүн өмнөд Ази (Бангладеш, Энэтхэг, Камбож)-д түгээмэл байна. Жишээ нь, 2013 оны Рана Плазагийн нуралт ажлын байрны аюултай орчныг ил болгосон.



- **Хөдөө аж ахуй ба хүнсний үйлдвэрлэл:** Газрыг нь булаах, цагаачдын хөдөлмөрийг мөлжих, химийн хорт бодист өртөх тохиолдлууд бий. Далдуу модны тос, какао, кофены тариалалт, үйлдвэрлэлд хүүхдийн хөдөлмөрийн мөлжлөг, нутгийн иргэдийн эзэмшиж ашиглаж ирсэн газрыг нь булаах зэрэг зөрчил гарсаар байна.



- **Уул уурхай, олборлох үйлдвэрлэл (газрын тос, ашигт малтмал):** Албадан хөдөлмөр, байгаль орчныг сүйтгэж доройтуулах, нутгийн иргэдийг нүүлгэх, зэвсэгт бүлэглэлүүдийг санхүүжүүлэх зэргээр хүний эрхийг зөрчдөг. Кобальт, алт олборлоход хүүхдүүдийг ажиллуулж, зэвсэглэсэн бүлэглэлүүдийг санхүүжүүлж байна.



- **Барилга, дэд бүтэц:** Цагаач ажилчдыг мөлжих, ажлын аюултай нөхцөл, хэт халууны улмаас нас барах тохиолдол гардаг. Катар болсон хөлбөмбөгийн ДАШТ-ий барилга угсралтын ажил ихээхэн шүүмжлэл хүлээсэн түүх бий.



- **Цахилгаан хэрэгсэл ба технологийн салбар:** Өндөр ачаалалтай хэт удаан ажиллах, аюултай орчин, албадан хөдөлмөр эрхлэлт нийтлэг. Ялангуяа, Хятад, Тайвань дахь ухаалаг утас, нарны хавтан, хагас дамжуулагч үйлдвэрлэл нь хүний эрхийн зөрчилтэй холбогддог. Мөн чинээлэг компаниуд тухтай ажиллахад зориулсан хэт таатай орчин зориуд бүрдүүлснээр ажилтнууд гадаа гаралгүй, өдөр шөнөгүй ажиллах явдал ч байна.



- **Загасчлал ба далайн гаралтай бүтээгдэхүүний салбар:** Албадан хөдөлмөр, хүний наймаа, бие махбодын хүчирхийлэл дагуулдаг. Загас агнуурын завин дээр орчин үеийн боолын хөдөлмөр бий хэмээн шүүмжилдэг.



- **Жижиг дунд үйлдвэрлэл:** Жижиг, дунд үйлдвэрлэгчид өсөж тэлэхэд нь хэрхэн дэмжих тухай сэдэв нийгэмд давамгайлж байна. Гэвч энэ нь нэг талаар уг салбар дахь хүний эрхийн зөрчлүүдийг бүдгэрүүлж, хэвшмэл ойлголт руу оруулах нь бий. Дэлхийн нийт бизнес эрхлэгчдийн **90%-ийг** жижиг, дунд үйлдвэрлэл эзэлдэг. Тэгэхээр бизнесийн салбарын хүний эрхийн зөрчлүүдийг зөвхөн томоохон компаниуд гаргадаггүй учир том, жижиг гэж ялгалгүй шүүмжлэлт сэтгэлгээгээр асуудалд хандах нь хүний эрхийг хамгаалахад тустай. **Тухайлбал:** Компанийн нийгмийн хариуцлага нь бизнес ба хүний эрхээс ямар ялгаатай вэ? Дээрх хоёр ойлголт нь хариуцлагатай, нийгэмд ээлтэй, ашиг тустай бодлогыг дэмждэг боловч өөр хоорондоо тодорхой зааг ялгаатай.
- **Компанийн нийгмийн хариуцлага** нь үнэ цэн бүтээх, олон нийтийн харилцааг түлхүү анхаардаг. Нийгмийн хариуцлага нь ихэвчлэн хандивын шинжтэй байдаг.
- **Бизнес дэх хүний эрх** нь эрхээ зөрчүүлсэн хувь хүн, иргэдийн олон улсын гэрээнд заасан хүний эрхийг өмгөөлж, сэргээж, шударга ёсыг төлөвшүүлэхэд илүүтэй анхаардаг.



- Дэлхийн нийт бизнес эрхлэгчдийн жижиг, дунд үйлдвэрлэгчдийн эзлэх хэмжээ

АШИГ БА ЭРХИЙН ЗӨРЧИЛ: ХҮНИЙ ЭРХЭД УЧРАХ ЭРСДЭЛ

Бизнесийн үйл ажиллагаанаас үүдэн хүний эрхэд учирч болох аливаа сөрөг нөлөө, эрсдлийн талаар хэвлэл мэдээллийн байгууллагууд, сэтгүүлч, уран бүтээлчид мэдлэг, мэдээлэлтэй байж гэмээнэ энэ талаарх олон нийтийн ойлголт, мэдлэг сайжирна. Ийм төрлийн мэдээллийг хэвлэл мэдээлэл олон нийтэд нээлттэй, хүртээмжтэй түгээснээр хэрэглэгчид дэмждэг, хэрэглэдэг бүтээгдэхүүн, үйлчилгээ, брэндүүдээсээ хариуцлага нэхэж, илүү шударга, хүний эрхэд хүндэтгэлтэй бизнесийн тогтолцоог шаардаж чадна. Олон нийт хүний эрхийг зөрчиж буй бизнесийн аливаа үйлдлийг буруушаах, ёс зүй, шударга байдлыг нэхэх хандлага ч идэвхждэг.

Монголд хүний эрхийг бизнесийн байгууллагуудаас шаардсан зарим жишээ:

Эрүүл хоол хүнсээр хангагдах эрх

2024 оны гуравдугаар сард Эмээлт түүхий эдийн захад өмхий мах худалдаалагдаж байна гэсэн мэдээллээс улбаалан нийслэлчүүд эрүүл ахуйн шаардлага хангасан мах хэрэглэж чадаж байна уу гэсэн шүүмжлэлийг өрнүүлсэн. Нийслэлд худалдаалдаг махны эрүүл ахуй, чанарын асуудлаар олон нийт идэвхтэй байр сууриа илэрхийлсэнээр хууль, хяналтын байгууллагууд дүрэм, журмын хэрэгжилтийн биелэлтийг эргэн хянаж шалгаж эхлэв. Энэ үеэр eduug.mn цахим сайт иргэдээс махны эрүүл ахуйн талаар асуулга авахад, 80% нь худалдан авч буй махан бүтээгдэхүүний чанарт эргэлздэг гэжээ. Ханган нийлүүлэлтийн сүлжээнд хүний эрхийн асуудал янз бүрээр зөрчигддөг. Үүний тод жишээ нь Эмээлт дэх өмхийрсөн махны жишээ юм. Эрүүл хүнс хэрэглэх эрхээ иргэд шаардах, үзэл бодол, байр сууриа хүчтэй илэрхийлэх замаар өөрчлөлтийг авчирч болдог.

Хөдөлмөрлөх эрх

"Хишиг-Арвин индустриал" ХХК-ийн ажилтан А ажлын байран дээрээ лифтний хонгилд унаж амиа алдсан харамсалтай тохиолдол гарсан. Гэтэл түүний ослын шалтгааныг их хэмжээний согтолтоос үүдэн хөдөлмөрийн аюулгүй байдлын алдаа гаргасан хэмээн эрх бүхий байгууллагаас дүгнэжээ. Харин түүний эхнэр Б.Болороо гурван жилийн туршид "согтуурлаас бус хөдөлмөрийн аюулгүй байдал алдагдсан" хэмээн тууштай тэмцсэний үр дүнд эрх бүхий байгууллагын дүгнэлт "худал" байсныг баталж, харамсалтайгаар амиа алдсан нөхрийнхөө нэр төрийг сэргээлгэсэн. Компанийн холбогдох удирдлагууд ажлын цагийг хэтрүүлсэн, ажлаас гадуурх хамааралгүй үүрэг өгсөн зэрэг зөрчлүүдээ хүлээн зөвшөөрч, уучлал гуйж, ар гэрийнхэнтэй нь тохиролцооноор уг асуудал шийдвэрлэгдсэн юм.

Хүрээлэн буй орчинд үзүүлэх хор хохирол, орон нутгийн иргэдэд үзүүлэх нөлөө

Байгаль орчны доройтол нь хүмүүсийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг ноцтой зөрчдөг. Монголд уул уурхайн компаниудаас хүний эрх, байгаль орчны нөхөн сэргээлтийг шахааж шаардах нь түгээмэл ажиглагддаг. Жишээ нь: Баянхонгор аймгийн Жаргалант сумын нутагт 2015-2016 онд үйл ажиллагаа явуулсан нэр бүхий компани ашигласан талбайдаа ямар ч нөхөн сэргээлт хийлгүй орхиж явсаны улмаас тус сумын иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх зөрчигдсөн. Түүнчлэн нутгийн иргэдийн ундны усаа хангадаг нууруудад шаварлаг ихсэж татарч эхэлжээ.

Энэ хэргийн талаар 2022 оны 8 дугаар сарын 11-нд нутгийн иргэд нэгдэж, хэвлэлийн бага хурал хийж олон нийтийн болон эрх бүхий байгууллагуудын анхааралд хүргэн эрхийнхээ төлөө тэмцсэн.

Ялгаварлан гадуурхалт ба тэгш бус байдал

Монголд жендэрийн хэвшмэл ойлголт түгээмэл бөгөөд ялангуяа жижиг дунд үйлдвэрлэлийн ажлын байранд хүний эрхийн наад захын зөрчил, жендэрийн мэдрэмжгүй байдал элбэг тохиолддог. Нэн ялангуяа оюутан залуучууд цагийн ажил эрхлэхдээ жижиг дунд үйлдвэрүүдэд ихэвчлэн ажилладаг бөгөөд тэнд хөдөлмөрийн хөлсөө шударгаар үнэлүүлэхгүй байхаас гадна хүйсийн, насны хувьд ялгаварлан гадуурхалтад өртөх, ажил мэргэжлийн үр чадварын улмаас ажлын байрны дорд үзэгдэх, сэтгэл санааны дарамтад орох, ажлын байрны бэлгийн дарамтад өртөх зэрэг эрсдэл өндөр байдаг. Жишээ нь: нэгэн бизнес эрхлэгч ажлын байрны ярилцлага авахдаа эмэгтэй ажил горилогчдоосоо хүүхэд төлөвлөж буй эсэхийг асууж, баталгаажуулж амлалт авч байсан нь нөхөн үржихүйн эрх ба жендэрийн эрх тэгш байдлыг хүндэтгээгүй зөрчил мөн.

БИЗНЕС ДЭХ ХҮНИЙ ЭРХ: ТОЙРОГ ЭДИЙН ЗАСАГ

Кэйт Крэсийн “Хог хаягдал бол дизайны алдаа” хэмээх эшлэл нь асуудлын үндэс суурь ямар чухал болохыг илэрхийлсэн маш хүчтэй мессэж юм. Үүнийг “тойрог эдийн засаг” гэх ойлголтын хүрээнд авч үзвэл, тогтвортой байдал нь хогийн цэгээс биш, харин загвар төлөвлөлтийн шатнаас эхэлдэг гэсэн санааг илэрхийлж байна. Дахин боловсруулалтыг багасгахад чиглэсэн аливаа санаачилга, бодлого, хандлагад түлхэц болж, хэрэв илүү ухаалгаар загварчилж, төлөвлөж чадвал хог хаягдлыг уг үндсээр нь бууруулах боломжтой. 2024 оны байдлаар дэлхий даяар хот суурин газрын хог хаягдлын 20 шахам хувийг л дахин боловсруулж байгаа бол Монгол Улсад 10 хувьтай байна.

“Ногоон” сурталчилгаанд (greenwashing) хууртахгүй байх, аливаа реклам сурталчилгаа, уриалгын цаад зорилго санааг ойлгодог байх, ялгаж салгах чадвартай байх нь иргэдийн мэдээллийн боловсролтой хамааралтай. Хүмүүс байгаль орчиндоо ээлтэй байх хүслийн улмаас дахин боловсруулсан бүтээгдэхүүн худалдаж авах хүсэлтэй байдгийг брэнд үйлдвэрлэгчид мэддэг учраас сурталчилгаандаа «эко» өнгө төрх, байгальд ээлтэй дүрс, үг хэллэг түлхүү ашигладаг. Жишээ нь, “Байгальд ээлтэй”, “100% байгалийн” гэх мэт.

Гэвч эдгээр бүтээгдэхүүн, үйлчилгээний маш бага хувь л энэ ойлголтод дүйж чаддаг нь харамсалтай. Ийм төрлийн мэдээлэл сурталчилгаанд үргэлж хянуур хандаж, мэдээллийг нягтлан шалгах, асууж тодруулах зэргээр шүүмжлэлт сэтгэлгээгээр хандах нь брэнд үйлдвэрлэгчдийг хүний эрхэд ээлтэй ханддаг байхад шахалт болно.

Гэтэл мэргэжилтнүүд худалдан авалтаа багасгаж, илүү удаан эдэлж, эвдэрсэн зүйлийг засаж, сэлбэж, амьдрах хугацааг уртасгах нь эко, шинэ зүйл худалдан авахаас илүү хувь нэмэртэй гэж үздэг. Тойрог эдийн засгийн төгс жишээ бол “Stella McCartney” цүнх юм. Тус цүнхний үйлдвэрлэл сайн жишиг болж магадгүй.



Гэхдээ бодит өөрчлөлт гаргахын тулд ёс зүйтэй загварын ертөнц гэдэг ойлголт нь тансаг хэрэглээ биш, харин энгийн, нийтлэг хэвшилд тулгуурлах хэрэгтэй. Одоогоор хямд үнэтэй хувцасны бизнесүүд нь эрүүл мэндийн шаардлага хангаагүй орчинтой, ажилтнуудаа бүх нийтийн баяраар амраадаггүй, олон цагаар ажиллуулах атлаа хэт доогуур цалинтай гээд хөдөлмөрийн мөлжлөгийн зөрчил гаргасаар байна.

Энэхүү цүнхийг цөөн хэдэн чинээлэг хүмүүс худалдаж аваад нөлөөлөл гарахгүй ч бусад брэндэд үлгэр дууриал, мөс хагалагч болсон. Өдгөө бидний сайн мэдэх Zara, Adidas, H&M брэнд 2030 он гэхэд 100 хувь дахин боловсруулсан материалыг хаягдалгүйгээр үйлдвэрлэлдээ ашиглахаар зорьж байна.



БИЗНЕС ДЭХ ХҮНИЙ ЭРХ: ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Ажил хэрхэн өөрчлөгдөж байна вэ?

[Бизнес дэх хүний эрхийн хэрэгжилтийг сайжруулах нь: Оролцоог хангасан хөдөлмөр эрхлэлт](#)

Хөдөлмөр эрхлэлт гэх ойлголт, ажлын орчин хэрхэн хувьсан өөрчлөгдөж байна вэ? Дэлхийн эдийн засгийн форумын үеэр эрдэмтэн судлаачид 2027 он гэхэд 83 сая ажлын байр автоматжуулалтын улмаас устаж, шинээр 69 сая ажлын байр бий болно хэмээн мэдэгдлээ. Үүнд, үйлдвэрлэл, захиргааны ажлын байрууд болон хэрэглэгчтэй харилцдаг үйлчилгээний ажил үүргүүд ихээхэн өртөх аж. Аппликейшнд суурилсан ажлын шинэ байрууд нь чөлөөт контент бүтээгч, хүргэлтийн болон зайнаас харилцах ажилтнууд, виртуал туслахуудын эрэлтийг нэмэгдүүлж, тогтвортой ажлын байруудыг цөөлж байна.

Цагаар, түр гэрээгээр ажиллагсдын тоо 2010 онд **15%** байсан бол өнөөдрийн байдлаар нийт ажиллах хүчний **36%**, 2030 он гэхэд **50%** -ийг эзлэх төлөвтэй байгааг Дэлхийн эдийн засгийн форумаар онцоллоо.

Монголд ажил олгогчид ба гэрээт ажилтнууд хоорондоо нийгмийн даатгалын шимтгэл төлөхгүй байхаар тохирох хандлага нэмэгдэж буй ч нөгөө талдаа ирээдүйд эдлэх тэтгэврийн даатгалын системийг сулруулж буйгаа залуу үе умартаж үл болно.

Ч.Очиррэнчин
МХУХ-ны ЕНБД

Хөндөгдөх эрх:
Ажил, мэргэжлээ болон ажлын байраа чөлөөтэй сонгох эрх

Өнөөдөр улсын хэмжээнд хөдөлмөр эрхэлж буй харааны бэрхшээлтэй иргэдийн 98 хувь нь массажист. Бидний хувьд хөдөлмөрлөх эрхээ эдэлнэ гэдэг сэтгэл зүй, нийгэмшихүй, эдийн засгийн эрх чөлөө гээд тэр хүнийг бүхэлд нь нөхөн сэргээх суурь болдог тул бусад бүх эрхээс хамгийн үнэ цэнтэй эрх юм. Төсөлд хамрагдсанаар харааны бэрхшээлтэй иргэдийг шинэ төрлийн ажлын байранд буюу үйлчилгээний байгууллагын дуудлагын төв, call center-т ажиллах боломжийг нээж, тэнд ажиллах хүмүүсийг сургаснаар нийслэлд болон орон нутагт 10 хараагүй иргэнийг ажлын байртай болгосон ба цаашид хөдөлмөрийн биржээрээ дамжуулан улам олон ажлын байр бий болгох урам зоригтой болсон.

Мөн төслийн хүрээнд "Хараагүй болон сул хараатай ажилтныг ажлын байранд тохирох хэрэглэгдэхүүнээр хэрхэн хангах вэ?" гарын авлагыг боловсруулж нийслэл, 21 аймгийн ажил олгогч нарт түгээсэн.

Түүнчлэн ажил олгогч цалингаа өгөхгүй бултах, цагийн үнэлгээг хэт доогуур үнэлэх зэрэг сэтгэл ханамжгүй байдлыг үүсгэдэг бол ажилтан ажлаа дураараа хаяж явах, ажлын хариуцлага хүлээхгүй байх зэргээр харилцан бие биенээ хохироох асуудал гарсаар байна.

Түр ажлын байрны сөрөг үр дагавар

1. Ажлаа алдах - Автоматжуулалт, платформын ажлууд уламжлалт ажлыг орлож байна. Жишээ нь, такси үйлчилгээ.

2. Тогтворгүй байдал - Нэг ажлын байранд ирж, явах хүмүүсийн урсгал эрчимжиж, үр чадвар султай ажилтнуудыг сургахад цаг, мөнгө их зарцуулна. Ажилтнуудын хувьд орлогын тогтворгүй байдал нэмэгдэж, орлого буурах, хадгаламж үүсэхгүй байх, ажил олгогчоос өгдөг тэтгэвэр, эрүүл мэндийн үзлэг, амралтын мөнгө, хөгжүүлэлт, цалингийн зээл, бонус гэх мэт байнгын ажилтны урамшуулалд хамрагдаж чадахгүйд хүрдэг. Бизнес эрхлэгчид ажлын орчинг таатай болгох, хүний эрхийн мэдрэмжтэй хандахад чиглүүлэх шаардлага улам бүр буурах бодит эрсдэл бий.

3. Эвлэлдэн нэгдэх, хамгаалуулах эрх хязгаарлагдана - Түр гэрээт, эсвэл гэрээгүй аман тохиролцооны ажилтнууд эвлэлдэх боломж бага, холбогдох байгууллагуудаар хамгаалуулах, эрхээ сэргээлгэх боломж улам бүр хумигддаг.

Түр ажлын байрны эерэг үр дүн

Шинэ ажил - Аппликейшнд суурилсан платформууд илүү олон хүнд шинэ ажил олгож байна. Хүссэн үедээ, хаанаас ч ажиллах боломжийг илүүд үздэг хүмүүст боломж бүрдэж, гар дээр олгогдох цалингаас илүү тохиролцох үндэслэл хөдөлмөрийн харилцаанд давамгайлдаг. Ажилд орох, гарах үйл явц илүү хялбар болж байна.

Үр чадвартай ажил руу шилжиж байна - Уламжлалт ажлууд дижитал үр чадвар шаарддаг шинэ хэлбэрт шилжиж байна.

БИЗНЕС ДЭХ ХҮНИЙ ЭРХ: ЖЕНДЭР

Бизнес дэх хүний эрхийн асуудал хэвлэл мэдээллийн анхаарлын төвд зайлшгүй байх ёстой. Энэ нь шударга ёсны асуудал бөгөөд зөвхөн судалгаа, тоо баримтаар мэдээлэх бус бодит туршлага, түүх, хэрэглэгчдийн дуу хоолойгоор дамжуулан шийдвэр гаргагч, олон нийтийн анхааралд хүргэх нь чухал. Хэвлэл мэдээлэл эрх нь зөрчигдсөн иргэдийг асуудлын золиос биш, харин шийдлийн нэг хэсэг гэдгийг харуулах нь чухал.

Бизнесийн орчинд өдөр тутам тулгарч буй жендэрийн хандлагын жишээ

“Эмэгтэй хүн ажилд авмааргүй байна, төрөөд явчихдаг”. “Эрчүүд хамаагүй дээр байдаг” хэмээн ажлын ярилцлагын үеэрээ хэлж, охид, эмэгтэйчүүдийг хүйсээр ялгаварласан, үр чадвар дутмаг хэмээн урьдчилан дүгнэж бага цалингаар тохирсон гэх нэгэн кофе шопын бизнес эрхлэгчийн асуудал 2025 оны 4 дүгээр сард олон нийтийн шүүмжлэлд өртсөн.

Иймэрхүү асуудлыг ил тод ярьж хэлэлцэж байх нь жендэрийн энэ мэт хэвшмэл хандлагыг засаж залруулахад тустай. Жишээ нь, жендэрт суурилсан хүчирхийлэл (ЖСХ) нь нам гүм, чимээгүй байдалд л хүчээ авдаг. Харин нээлттэй байх нь хүний эрхийг хамгаалж, хариуцлага хүлээлгэх, хохирогчдод хамгаалалт, тусламж үзүүлэх эхлэл болдог. Сэтгүүл зүйн бүтээлээр дамжуулан өөрчлөлтийн боломжийг **бусдад** харуулдаг. Үүний тулд дараах асуултад хариулт эрэлхийлэх нь чухал.

Эмэгтэйчүүд зохистой цалин авч эхэлбэл юу өөрчлөгддөг вэ?



Эмэгтэйчүүд удирдах түвшинд ажиллахад байгууллагын ажлын үр дүн яаж сайжирдаг вэ? Хүртээмжтэй боловсрол, тэгш боломжуудын үр дүнд ямар нийгэм бий болдог вэ? Ихэнх тохиолдолд дэлхий даяар өндөр хөгжилтэй орнуудад ч сэтгүүлчид зөвхөн удирдах түвшний хүмүүс (төрийн өндөр албан тушаалтан, гүйцэтгэх захирал гэх мэт)-ийг ярилцлагад урьдаг бөгөөд эдгээр түвшинд эмэгтэйчүүдийн төлөөлөл дутмаг байдаг. Гэтэл эмэгтэйчүүдийг ярилцлагад урьсан ч ихэвчлэн нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн сэдвээр л асуусан байдаг.

“Хэвлэл Мэдээллийн Зөвлөл” ТББ нь НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн төслийн дэмжлэгтэйгээр **“Мэдрэмжтэй мэдээлье”** нэгдлийг байгуулж хэвлэл мэдээллийн агуулга дахь жендэрийн тэгш бус байдал, хэвшмэл ойлголтыг халах зорилгоор зорилтот хөтөлбөрийг гурван жил хэрэгжүүлсэн. 2021 онд Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс хийсэн судалгаагаар хэвлэл мэдээллийн 10 эх сурвалжид 1 эмэгтэй эх сурвалж байсан бол 2024 онд хийсэн судалгаагаар энэ үзүүлэлт гурав дахин нэмэгдэж гурван эх сурвалжийн нэг нь эмэгтэй болсон дэвшил гарчээ.

Түүнчлэн жендэрийн эрх тэгш байдлыг манлайлагч хэвлэл мэдээллийн хэрэгслүүд тухайлбал, GoGo.mn сайт “Тэнцвэр” санаачилгыг хэрэгжүүлж, эх сурвалжуудын 20% нь л эмэгтэй байсныг зургаан сарын хугацаанд 38% -д хүргэж чадсан зэрэг сайн туршлагыг дурдаж болно.

Түүнчлэн хувийн хэвшил, бизнесийн байгууллагууд ч жендэрийн хэвшмэл ойлголтыг халах, нийгмийн харилцаанд эрх тэгш байхын чухлыг ойлгуулах кампанит ажлуудыг зохион байгуулдаг жишиг тогтож эхлээд байна.

Эрчүүдийн гэх тодотголтой ажлуудыг эмэгтэйчүүд сонгон амжилттай ажиллаж буй түүхүүдийг хуваалцаж буй Юнител группын **#herstory** нийгмийн кампанит ажлыг дурьдаж болно.

Олон улсын #MeToo хөдөлгөөн нь 2017 онд дэлхий даяар олон сая эмэгтэйчүүд (зарим эрчүүд ч мөн адил) ажлын байрны бэлгийн дарамт, хүчирхийлэл, жендэрт суурилсан хүчирхийллийн талаар дуугарч, өөрсдийн туршлагаа хуваалцах боломжийг нээсэн. Алдартнууд өөрсдийн туршлагыг нийтэд ил болгосноор энэхүү хөдөлгөөн дэлхийг хамарч эхэлсэн. Энэ нь эрх мэдлийн тэнцвэргүй байдал хэрхэн хүчирхийлэгчдийг хамгаалж, хохирогчдыг чимээгүй байлгаж байгааг илчилсэн бодит түүх юм.

Пулитцерийн шагналт (**Jodi Kantor, The New York Times, Ronan Farrow, The New Yorker**) хоёр сэтгүүлч эрэн сурвалжлах сэтгүүл зүйн үйл ажиллагаа явуулж байх үед нь кино продюсер Harvey Weinstein нь **“lack Cube”** хэмээх хувийн тагнуулын компанийг хөлсөлж, сэтгүүлчид болон гомдол гаргасан эмэгтэйчүүдийг тагнаж мөрдөн олж авсан мэдээллээрээ эх сурвалжуудыг айлган сүрдүүлсэн. Дээрх эрэн сурвалжлах бүтээл **#me2** кампанит ажлыг хүч авхуулж, одоо ч хохирогчид ба хүчирхийлэгчид ар араасаа гарч ирэн үргэлжилж байна.

GoGo.mn олон ургалч байр суурийг хүргэх “ТЭНЦВЭР” санаачилгыг эхлүүлж байна.



Мэдээ ▾

GoGo булан ▾

• Үзэх ▾

Хэв маяг ▾

English

GoGo.mn олон ургалч байр суурийг хүргэх “ТЭНЦВЭР” санаачилгыг эхлүүлж байна



Б.Нямдарь

Нийгэм

🕒 2022-07-22

👍 346



Дэлхийн хүн амын тэн хагасыг бүрдүүлдэг эмэгтэйчүүдийн дуу хоолойг хэвлэл мэдээллээр маш бага хүргэдгийг Та мэдэх үү?

Олон улсын хэвлэл мэдээллийн мониторингийн (Global Media Monitoring Project (GMMP)) үр дүнгээс үзэхэд хэвлэл мэдээллээр гарч байгаа дөрвөн хүн тутмын нэг нь л эмэгтэй байна. Мөн эмэгтэйчүүдийг ихэвчлэн ээжийн үүргээр дүрсэлдэг бөгөөд улс төр, эдийн засаг зэрэг салбарт мэргэжлийн байр суурийг нь хүргэх тохиолдол хангалтгүй байгаа юм. Байдал энэ чигээр үргэлжилбэл мэдээний агуулгаас жендэрийн тэгш байдлыг харахын тулд дор хаяж 67 жил хүлээх хэрэгтэйг судлаачид анхааруулдаг.

БИЗНЕС ДЭХ ХҮНИЙ ЭРХ: ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ

Бараг бүх сэтгүүлч ажил мэргэжлийнхээ туршид **Бизнес дэх хүний эрхийн талаар** ямар нэгэн бүтээл туурвисан байдаг. Учир нь энэ бол **нэг салбарт буюу зөвхөн улс төр эсвэл эдийн засагт ч биш**, бүх хүнд **нөлөөлдөг** сэдэв. Зарим сэтгүүлч хүний эрхээр дагнан ажилладаг бол зарим нь өөрийн мэргэшсэн сэдэвтэй уялдуулан бүтээлч байдлаар энэ асуудлыг тусгаж чаддаг. **Нийгмийн шударга ёс, хүний нэр төр, аюулгүй байдал, тэгш боломж, хамгаалалт** зэрэг үнэт зүйлсийг таниулах үүднээс сэтгүүлч бүр хүний эрхийн төлөө дуугардаг.

Хувцас загварыг сурвалжилж буй сэтгүүлчид хямд ажиллах хүч бүхий үйлдвэрийн ажилчдын хөдөлмөрийн нөхцөлийг судалж хөндөх нь нийтлэг ажиглагддаг. Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, энэ салбарын хаягдал гэх мэтээр хөндөх сэдвээ илүү өргөжүүлж болно.

Цэнгээнт танин мэдэхүйн чиглэлээр бүтээл туурвидаг сэтгүүлчид олны танил алдартнуудын оролцоотой хүний эрх, жендэрийн асуудлыг хөндөх боломжтой. Учир нь НҮБ, ТББ-ууд, брэндүүд олны танил хүмүүсийг ашиглан олон нийтийн анхаарлыг татахыг зорьдог.

Спортын сэтгүүлчид тэмцээн уралдаантай холбоотойгоор жишээ нь цэнгэлдэх хүрээлэн барьсан цагаач ажилчдын хөдөлмөр, спортын хувцас үйлдвэрлэгчдийн ажлын орчны аюулгүй байдлын асуудлыг сурвалжилж болно. 2020 онд Засгийн газрын мэдээ сонин спортын салбарын бэлгийн дарамт, жендэрт суурилсан хүчирхийллийн асуудлыг хөндөж байв.

Эдийн засгийн сэтгүүлчид уламжлал ёсоор компаниудын ашиг, хөрөнгийн зах зээл дээрх байршлыг хардаг ч өнөө үед компанийн нийгмийн хариуцлага, хүний эрхийн зөрчил нь хувьцааны ханшид шууд нөлөөлдөг тухай мэдээлж байна.

Эрэн сурвалжлах сэтгүүлчдийн хувьд нийтийн эрх ашгийн төлөөх, бодит баримтад тулгуурласан, далд асуудлыг ил болгон **хүний эрхийн зөрчлийг илчлэх, хохирогчдын дуу хоолойг хүргэх, эрх мэдэлтэй этгээдэд хариуцлага тооцох, бодлогын өөрчлөлтөд хүргэх** хүртэл нөлөө үзүүлэх чухал арга хэрэгсэл болдог.

ХҮНИЙ ЭРХИЙН НИЙТЛЭЛҮҮД ЯМАР БАЙДАГ ВЭ?

Tea's dark secrets	“Чай” бол Энэтхэгийн үнэмлэхүй бэлгэдэл ба зовлонгийн амт бөгөөд Британ, Иран, Турк, Арман, Араб, Шри Ланк, Япон зэрэг олон үндэсний соёлын амт үнэр нь юм. Гэвч цайны түүх бол колоничлол, компанийн хүний эрхийн зөрчлийн анхны жишээнүүд билээ. Англи эр хятадаас хулгайгаар авчирсан цайны тариалан, үйлдвэрлэлийн сүүдэр өдгөө ч хадгалагдаж, амралгүй, эрүүл ахуй хангаагүй, эрүүл мэндийн тусламж авах боломжгүй тааруу орчинд амьдрах ажиллах гэх мэт хүний эрхийн ноцтой зөрчлүүдтэй үргэлжилж байна. Энэтхэг болон Фижи, Уганда зэрэг алс холоос ажилчдыг нууцаар авчрах ба тэдний нэлээд олонх нь замдаа амиа алддаг.
--------------------	--

Broken Angel	Түүний нэрийг Angel гэдэг. Тэрбээр Архангай аймгаас Сингапурт ирээд хэд хонож буй. Хэтэрхий туранхай учраас тэр юмуу, даашинзных нь суга хэлхэгнэж, сул дээгүүрээ хаясан хүрэм нь эрэгтэй хүнийх шиг л мөр нь томдож, ташаа давжээ. Одоохондоо цалингүй байгаа учир өөрийн гэсэн хувцас байхгүй олдсоноо өмссөн нь энэ. Хацар нь жаахан хөхөрч, духаа шалбалсан учрыг асуутал өчигдөр орой зочинд архи хундагалж хамт уусаар нэлээд согтоод 00 орохдоо хальтраад суултуур мөргөж унасан аж. Уг шөнийн клубт зочин уух зүйлс авах тоолонд хамт сууж, аягалж, өгч буй охидууд үнийн эрэмбээр оноо цуглуулж дараа нь цалингаа авдаг. Өөрсдөө зочинтойгоо тохиролцбол нэг шөнийг хамт өнгөрүүлдэг. Тэднийг зуучилж авчирсан эгч “Эд нар намайг өөрсдөө л олоод ирдэг. Би ерөөсөө хайж олоод хүчээр энд авчраагүй” гэх. Тэрбээр Монголд бас хэдэн массаж болон шөнийн клуб ажиллуулдаг. “xxx” клубт монгол охид авчирч ажиллуулах нь түүний нэрийдсэнээр бол экспортын бизнес.
----------------------------	--

Дээрх нийтлэлийг бичихдээ сэтгүүлч **Энэтхэгийн** цайны тариалангийн талбайд ажилладаг цагаач ажилтнуудаас ярилцлага авсан нь гол эх сурвалж болсон бөгөөд олон нийтийн анхаарлыг ихэд татсан. Харин Монгол нийтлэлийн хувьд оролцон ажиглах аргыг түлхүү хэрэглэсэн бөгөөд гадны оронд хөдөлмөр эрхэлж буй хүнээр дамжуулан бусад ижил төстэй нөхцөлд байгаа цагаач ажилтнуудын ажлын нийтлэг нөхцөл байдлыг сурвалжилж гаргасан байна.

Бизнес дэх хүний эрхэд үзүүлж болох эерэг ба сөрөг нөлөөллийн тухай [UNDP Mongolia Youtube суваг](#) дээрх [“Хариуцлагатай бизнес гэж юу вэ?”](#) контентийг үзэж мэдээлэл авах боломжтой.

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс хэрэгжүүлж буй “Бизнес ба хүний эрх” төслүүдийн хүрээнд гаргасан [“Хүний эрхийн магадлан шинжилгээний талаарх Монголын бизнес эрхлэгчдийн дуу хоолой”](#) болон **“B+HR Academy: Showcasing Commitments and Impacts by Private Sector”** нэртэй контентуудад дараах компаниуд үр дүн, сайн туршлагаа танилцуулжээ.

- Траст Трэйд ХХК
- Сноу Филдс ХХК
- Марис Трейд ХХК
- Дижитал Концепт ХХК
- Ноосон Зангилаа Дундын Хоршоо
- Нөмөр ББСБ
- Увс Хүнс ХК
- Макс Өргөө ХХК



- Номин Хоумстайл ХХК
- Бэби Камель Кашмер ХХК
- Рийч Фүүд Саплай ХХК

- Моншибасаки ХХК
- Санкотек Монголиа ХХК
- Эвридэй Ферм ХХК



Ж.Ариунзул
"Траст Трейд ХХК"
Хүний нөөцийн албаны дарга

Төслийн нэр:
Европын холбооны санхүүгийн дэмжлэгтэй, НҮБХХ-ийн "Бизнес ба хүний эрх" төслийн хүрээнд Монголын Хүнсэдийн нэгдсэн холбоо, Траст ХХК-аас хэрэгжүүлсэн "Хүний эрхийн магадлан шинжилгээ хийх" төсөл

Хүний эрхийн магадлан шинжилгээ гээд анх сүрдмээр сонсогдож байсан ч ярьж, тайлбарлаж байгаа хэлбэр нь л өөр болохоос, бид ажилтнаа тогтоох, үйл ажиллагаагаа сайжруулахын тулд байнга хийх ёстой, хийдэг ажлууд байсан.

TRUST TRADE



Ж.Батмөнх
"Сайн туршлага" ТББ-ын тэргүүн

Хөндөгдөх эрх:
Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх

Арьс, ширний үйлдвэрийн нөлөөллийн бүсэд амьдарч буй оршин суугчдын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх хамгийн ихээр зөрчигддөг ба төслийн үр дүнд хүний эрхийн зөрчлийг хэн даамжруулж, хаана гацааж, саад болж байгааг олж тогтоосон.

Бизнесийн үйл ажиллагаанаас үүдэлтэй хүний эрхийн зөрчлийг илрүүлэх, арилгах тал дээр мэргэжлийн холбоод, төрийн байгууллагуудын оролцоо нэн чухал байна.

СМН ТҮРШЛАГА



Ш.Ариунаа
МЭХДХ-НБ Тэргүүн

Хөндөгдөх эрх:
Хөдөлмөрлөх эрх, Ажлын байрны дарамт, Ажлын байрны бэлгэйн дарамтаас ангид байх эрх

Барилгын салбарт бизнес эрхлэгчид хүний эрхийн болон хөдөлмөрийн аюулгүй байдал, хөдөлмөрлөх эрхийн зөрчил үүсгэж байгаагаа ихэнх тохиолдолд мэддэг боловч үйл ажиллагаандаа Хүний эрхийн магадлан шинжилгээ хийх хүсэлгүй байна

Барилгын салбарт хүний эрхийг хангах ажлыг хөрөнгө оруулагч, захиалагч байгууллагын түвшинд анхаарч, шаардахгүй бол энд хүний эрхийн зөрчил арилахгүй.

МОНГОЛЫН ЭМЭГТЭЙН ХӨДӨЛМӨРЛӨХ ДЭМЖЛЭХ ХОЛБОО
MONGOLIAN WOMEN'S EMPLOYMENT SUPPORT ASSOCIATION



Хөндөгдөх эрх
Гүйцэтгэсэн ажил хөдөлмөртөө нийцсэн цалин хөлс авах, Ажлын байрны дарамтаас ангид байх эрх

Зочлох үйлчилгээний салбарт хийсэн Хүний эрхийн магадлан шинжилгээгээр энэ салбарын ажилтнуудын, ялангуяа. охид, эмэгтэйчүүдийн эрхийн асуудал салбар дунд хаягдсан сэдэв болохыг тогтоосон.

Хүний эрх, нийгэм, хууль, эдийн засаг, социологи гээд салбар салбарын мэргэжилтнүүд хамтарч байгаль орчин, хүний эрхийг хамгаалах асуудлыг хамтдаа шийдвэрлэж сурах хэрэгтэй байна.

ЦЕЛСЭЛЭЛЭН ХӨДӨЛМӨРЛӨХ ХОЛБОО
ЦЕЛСЭЛЭЛЭН ХӨДӨЛМӨРЛӨХ ХОЛБОО

- **Зургийн тайлбар.** Европын Холбооны санхүүжилтээр НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс хэрэгжүүлсэн "Бизнес ба хүний эрх" төсөлд оролцсон байгууллагуудын төлөөлөл ба төслийн зарим үр дүнгээс сургалтаар хуваалцав.

НИЙТЛЭЛ

Бизнес дэх хүний эрхийн чиглэлээр түүхэнд тэмдэглэгдэж олон улсад түгсэн сэтгүүл зүйн нэгэн бүтээлийг Чарльз Отоман уншихыг зөвлөж байна. Тэрбээр цагаачлал, албадан хөдөлмөр болон шударгаар ажилд авах асуудлыг сэтгүүлчид хэрхэн сурвалжилж байгааг судладаг чөлөөт сэтгүүлч юм. Мөн тэрээр НҮБ-аас сэтгүүлчдэд зориулан гаргадаг гарын авлагуудыг бэлтгэхэд зөвлөн тусладаг.



- Чарльз Отоман сэтгүүл зүйн шилдэг бүтээлүүдийг шалгаруулдаг шүүгчдийн бүрэлдэхүүнд багтдаг бөгөөд “Associated Press” агентлагийн Тайландын загас агнуурын салбар дахь боолчлолын талаар хийсэн.

Пуллитцерийн шагналт эрэн сурвалжлах бүтээлийг аль ч орны сэтгүүлч байсан заавал уншиж судлах нь ямар ч сургалтаас илүү бодит хичээл болно” гэж зөвлөж байна. Энэхүү сурвалжилгын үр дүнд АНУ-д аливаа бүтээгдэхүүнийг импортлохдоо үйлдвэрлэх явц нь зохистой хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд тулгуурласан гэдгийг нотлохыг шаарддаг болсон. Үгүй бол хил давуулахыг хуулиар хориглож, томоохон “Walmart” ба “Costco” дэлгүүрүүд ханган нийлүүлэгчдэдээ тавих хүний эрхийн шаардлагуудыг өндөрсгөж, улмаар хөндлөнгийн хяналт шалгалтыг нэвтрүүлсэн юм.

“Та боолуудын зовлонгоор хооллож байна” эрэн сурвалжлах бүтээлийн мөрөөр Индонез, Тайланд улсад албан бус хөдөлмөр эрхлэлтийг илрүүлэх ажиллагаанууд өрнөж дэлхий даяар хүний эрхийг хүндэтгэсэн хөдөлмөр эрхлэлтийн талаар хөдөлгөөн өрнүүлсэн. Иймд уг бүтээл нь хүний эрхийг хамгаалж, зөрчигдсөн эрхийг сэргээсэн түүхэн ач холбогдолтой бүтээл хэмээн нэрлэгддэг.

Дэлхийн нийлүүлэлтийн сүлжээнд хамгийн ихээр доромжлогдож, эрхээ зөрчүүлдэг хүмүүс бол цагаач ажилчид байдаг гэдгийг Чарльз онцолсон. Тэрээр бизнесийн үйл ажиллагаан дахь олон урхаг асуудлын үндэс нь компанийн буруутай үйл ажиллагаа гэхээс илүүтэй ажилтнуудын хамтын дуу хоолойгоо нэгтгэх эрх, эрх чөлөө хумигдмал байдагтай холбоотой. Сэтгүүлчид ийм асуудалд нухацтай хандаж хэрэглэгчдийг **бизнес эрхлэгчдийн эсрэг “бойкот” хийх, бизнесийг нь татан унагаахаас урьтаж ажилчдад эрх ашгийнхаа төлөө эвлэлдэн нэгдэж эрхээ хамгаалах урам зориг өгөх, эрхийнхээ төлөө тэмцэх арга барилд суралцахад** туслах нь зүйтэй. Ингэснээр урт хугацаандаа хөдөлмөрийн орчин тогтвортой сайжирч, хүний эрхийг дээдэлсэн бизнесийн орчин бүрдэхэд сэтгүүл зүй тус дэм үзүүлж чадна.

БҮЛЭГ

2

БИЗНЕС ДЭХ ХҮНИЙ ЭРХИЙН АСУУДЛААР БҮТЭЭЛ ТУУРВИХ, СУРВАЛЖЛАХ ПРАКТИК ЗӨВЛӨМЖ

- ▶ БИЗНЕС ДЭХ ХҮНИЙ ЭРХ (B+HR) -ИЙН ТАЛААР НИЙТЛЭХ ЁС ЗҮЙН ДҮРЭМ ТОХИРОХ
- ▶ ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БҮТЭЭЛ БА КАМПАНИТ АЖЛЫН ҮР НӨЛӨӨГ САЙЖРУУЛАХ
- ▶ БИЗНЕС ДЭХ ХҮНИЙ ЭРХ (B+HR) -ИЙН “ХАДААС” НИЙТЛЭЛ БИЧИХ НЬ
- ▶ БИЧИХ УР ЧАДВАРАА ХӨГЖҮҮЛЭХ НЬ
- ▶ БИЧВЭРИЙГ НЯГТЛАХ ЖАГСААЛТ
- ▶ АЮУЛГҮЙ БАЙДЛАА ШАЛГАХ ЖАГСААЛТ
- ▶ ЭХ СУРВАЛЖИЙН СҮЛЖЭЭГЭЭ ӨРГӨТГӨХ 10 ЗӨВЛӨМЖ

БИЗНЕС ДЭХ ХҮНИЙ ЭРХ (B+HR) -ИЙН ТАЛААР НИЙТЛЭХ ЁС ЗҮЙН ДҮРЭМ ТОХИРОХ

Редакцын бодлого, гарын авлагатай болох

Бизнес дэх хүний эрхийн талаар бичиж нийтлэх нь сэтгүүлчдийн хувьд байнга бичээд байдаг сэдэв биш тул тайлбарлах үг хэллэг, ойлголт мэдлэгээ жигдлэх тал дээр маргаантай зүйл олон байдаг. Зарим хүмүүс “уур амьсгалын өөрчлөлт” гэдгээс илүүтэйгээр “уур амьсгалын онц байдал” гэх нь бодит нөхцөл байдлыг илүү сайн илэрхийлдэг гэж үздэг. Мөн “хүчирхийллийн хохирогч” гэхээсээ илүү “хүчирхийлэл даван туулсан хүн” гэж хэлэх нь хүндлэлтэй, ёс зүйтэй хандлага юм.

Товчлолыг тайлбарлах ёстой юу?

Энэ нь танай уншигчдаас хамаарна. Гэхдээ **ихэнх тохиолдолд тайлбарлах нь зүйтэй**. Зарим редакц эхлэхдээ бүтнээр нь, дараа нь товчилсон хэлбэрээр үргэлжлүүлэхийг зөвлөдөг. Жишээ нь; UN Guiding Principles on Business and Human Rights гэдэг үгийг цаашид UNGPs гэж товчилж болно. Гэвч энэ нь уншигчдад ойлгомжгүй, уншихад таагүй болгодог.

Редакц дотроо бичлэгийн хэв маягаа хэлэлцэж санал нэгдсэний дараа “удирдамж” зэрэг редакцын бодлогын баримт бичигтээ тусгаж сайжруулж явах нь сэтгүүлчид болон уншигчдад тодорхой байдлыг бүрдүүлдэг. Жишээ нь: “Ерөнхий Сайд” гэх үү, “Ерөнхий сайд” гэж бичиж үү гэдгийг удирдамждаа тусгаж өгсөнөөр сэтгүүлч бүр нэгэн жигд бичлэгтээ ашиглах болно. Тиймээс томоохон редакцуудын бичих загваруудаас санаа аван хоорондоо дүрмээ тогтоорой. Үүнд жишээ болгон “Бизнес дэх Хүний эрхийн чиглэлээр бичиж нийтлэхэд баримтлах удирдамжийн загвар жишээнүүд”-ийг хавсаргав.

Хүний эрхийн мэдрэмжтэй, ёс зүйн дүрмүүдээ боловсруулахдаа олон улсын болон дотоодын туршлагыг судлан хэл зүйн болон мэргэжлийн хүмүүстэй зөвлөлдөж хийгээрэй.

Бизнес дэх хүний эрхийн сэдвээр ажиллахад анхаарах ёс зүйн зарчмуудаа тохирч редакцын удирдамждаа тусгаарай!

Хохирогчид бодит түүхээ хуваалцаж, сэтгүүл зүйн бүтээлийн гол болон туслах дүр болж буй бол үүнээс үүдэн учирч болох аливаа аюул, эрсдлүүдийг бүрэн ойлгож мэдэхэд нь сэтгүүлч туслах ёстой. Үүний тулд эх сурвалжид бүтээлийн явцад болон бүтээл олон нийтэд хүрсэний дараа ямар эрсдэл үүсэж болзошгүй урьдчилан тайлбарлаж зөвшөөрлийг авах нь зүйтэй.

Гол дүр **мэдлэгтэйгээр зөвшөөрөх** нь сэтгүүл зүйн бүтээлийг эхлүүлэх үндсэн зарчим юм. Тухайн хүн эрсдлийг бүрэн ойлгож, дарамт шахалтгүйгээр зөвшөөрсөн байх ёстой. **Хүүхдийн хувьд эцэг эх, асран хамгаалагчийн зөвшөөрөл зайлшгүй шаардлагатай**. Сэтгүүлчийн үүрэг бол тэдний дуу хоолойг хамгаалж, аюулгүй байдлыг хангах явдал. Зарим тохиолдолд нэр, царайг нууцалж, түүхийг үнэнээр хүргэх нь хамгийн зөв шийдэл байж болно.

“Бизнес дэх Хүний эрх”-ийн сэдвээр сурвалжилга хийхэд тулгардаг хамгийн эмзэг бөгөөд хөндүүр сэдэв бол ядууралд нэрвэгдсэн иргэдтэй харилцаж тэдний тухай түүхийг өгүүлэх, тэдний зовлонг бусадтай хуваалцах байдаг. Ядуурал бол бизнес дэх хүний эрхийн зөрчилтэй зарим талаар холбогддог. Сэтгүүлчид ийм төрлийн мэдээ, сурвалжилга бэлтгэхдээ өр өвдөх, сэтгэл эмзэглэх зэргээсээ болоод эх сурвалж болсон хүүхэд, эсвэл хөгшдөд “гар цайлгах мөнгө” өгөх тохиолдол гардаг. Гэвч олон редакц эх сурвалждаа **“мөнгө төлөхийн**

эсрэг” бодлого баримталдаг. Ийм тохиолдолд сэтгүүлчид редакцын ёс зүйн дүрмээ дагаж мөрдөхийг зөвлөж байна.

Ярилцлага авах үед дараах зүйлсийг анхаараарай!

Сэтгэл зүйн гүн шарх тээж яваа хүмүүстэй ярилцлага хийх үед тэдний шархыг дахин сэдрээхгүй байх, эдгэрэлд нь сөргөөр нөлөөлөх зүйл нэмчих вий гэж болгоомжлох нь сэтгүүлчээс хүний эрхийн өндөр мэдрэмжээс гадна хүн чанар, хүнлэг байдлыг шаарддаг. Жишээлбэл, хүчирхийлэл, гэмт хэрэг, осол аваарын зураг, видео дүрсийг үзүүлэхийн өмнө анхааруулга өгөх эсвэл сарниулах зэргээр хөгшид, хүүхдийн сэтгэл зүйн байдлыг заавал харгалзан үзэж хамгаалах хэрэгтэй.

Үнэгүй нийтлээд өгөөч гэвэл Та болон танай редакц алийг нь нийтлэх вэ?

Компаниудын хүний эрхийн сайн жишгийг мэдээ болгон нийтлэх замаар эерэг өөрчлөлтийн төлөөх уралдааныг идэвхжүүлэхэд хэвлэл мэдээлэл дэмжлэг үзүүл болно. Гэхдээ энэ бизнесийн ард хүний эрхийн байдал үнэхээр сайжирсан уу, эсвэл дүр эсгэлт үү гэдгийг хөндлөнгийн шинжээчдийн тусламжтайгаар нягтлан шалгаад дэмжих эсэхээ шийдэх эрх нь сэтгүүлчид бий.

Худал мэдээг таних, автахгүй байх

Өдөр тутмын үйл ажиллагаа ид өрнөж байхад редакц руу утас цохих, и-мэйл, мессэж илгээх зэргээр олон янзын мэдээлэл ирэх нь ердийн үзэгдэл. Гэвч эдгээр мэдээлэл, зураг, дүрс бичлэгийн цаана ямар зорилго байгаа, энд нийтийн эрх ашгийн асуудал хөндөгдөж байна уу, үүнийг сэдэв болгоод цааш нягтлан шалгаад сэтгүүл зүйн бүтээл болгох нь зөв үү зэрэг олон асуулт тулгарна. Худал мэдээлэл үү, бодит мэдээлэл үү гэдгийг цаг алдалгүй ялгаж таних мэдлэг, ур чадвар сэтгүүлч хүнд зайлшгүй хэрэгтэй. Иймд мэдээллийг нягтлан шалгах техникийн болон технологийн мэдлэг, ур чадвараа байнга хөгжүүлж байгаарай.

Мэдээллийг нягтлахад дараах асуултууд чухал.

Үүнийг хэн явуулсан бэ?

Хэрэв зураг авсан хүн өөрөө явуулаагүй бол дараах асуултуудад үргэлжүүлэн хариулаарай.

“Тэр хаанаас авсан бэ?”

“Яагаад хуваалцаж байна вэ?”

“Энэ зураг үнэхээр мэдэгдэж буй зүйлийг дүрсэлж байна уу?” гэдгийг нягтлах шаардлагатай. Зарим нь тодорхой зорилготой явуулдаг. Улс төрийн өрсөлдөгчөө гутаах, эсвэл хуурамч мэдээг зориуд тараах, тодорхой улс орнуудын эрх ашигт оролцох зорилгоор гутаан буруутгах, шинжлэх ухааны үндэслэлгүй мэдээллээр анхаарал татаж, хандалтаа нэмэгдүүлэх гээд олон санаархал бий. Зарим нь зүгээр л зохиомол дуулиан дэгдээж таашаал авах сэдэлтэй байдаг бол зарим нь өөрийг нь үл тоомсорлосон нэр хүндтэй хүмүүст хонзогнож худал мэдээ үүсгэдэг тохиолдол ч бий.

Буруу ойлгогдохоор алдаатай мэдээлэл (Misinformaon)

Үнэн биш мэдээлэл боловч санаандгүй, гэм хоргүй байдлаар түгээгдсэн

Хуурамч мэдээлэл (Disinformaon)

Зориуд худал мэдээлэл зохиож, хүнд хор хохирол учруулахаар тараасан

Гуйвуулсан (ташаа) мэдээлэл (Malinformaon)

Үнэн үйл явдал боловч нөхцлөөс нь салгаж, гуйвуулан ашигладаг. Жишээ нь, зураг үнэн боловч зохиомол тайлбараар гуйвуулах гэх мэт.

Сэтгүүлч хүн эргэлзэх, шалгах зуршилтай байх ёстой. Гэхдээ бүх зүйлд үл итгэх хандлага руу хэт хазайж болохгүй.

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БҮТЭЭЛ БА КАМПАНИТ АЖЛЫН ҮР НӨЛӨӨГ САЙЖРУУЛАХ

Сайн мэдээгээр эхлэх үү, муу мэдээгээр эхлэх үү?» гэдэг сонгодог асуулт нь сонголтын бүтэц (choice architecture)-ийн нэг хэлбэр юм.

- Мэдээлэл нь юу байхаас үл шалтгаалан сонсогчид хяналт, эрх мэдлийн мэдрэмж төрүүлэх замаар анхаарлыг холдуулж, бодит буултыг төөрөгдүүлдэг.
- Сэтгэлзүйн хувьд бэлтгэж, муу мэдээг хөнгөлж, анхаарал сарнилтаас сэргийлдэг.
- Хүний туйлын зорилго бол аз жаргалтай амьдрах учраас муу мэдээнээс эхэлвэл урам өгсөн төгсгөл рүү очно гэж итгэдэг.



Nudge Theory буюу зөөлөн түлхэлтийн онолын тусламжтай сонголтыг хязгаарлахгүйгээр, шийдвэр гаргах эрх мэдлийг хувь хүнд өгснөөр, хүн алийг нь ч түрүүлж сонссон бай, шийдвэртээ сэтгэл ханах, муу мэдээ байсан ч хөнгөн хүлээж авах, холбогдох шийдвэртээ эзэн болох магадлал өндөр. Асуулт асуусан хүн асуултынхаа хариуг бүрэн сонсдог шиг.

Хүмүүсийн зан үйлийн хэвшлийг бага багаар, хялбар аргаар өөрчлөх нь шууд зааж тушаахаас илүү үр дүнтэй байж болно гэсэн сэтгэл зүйн онол бий. Жишээ нь, шээх газарт онох бай байрлуулснаар ариун цэврийн өрөөг цэвэр байлгахад үлэмж нөлөөлдөг шиг. Үүнийг бид нийтлэл, сурвалжилгаа илүү нөлөө өндөртэй форматад оруулах, үг хэллэг, эх сурвалж сонгох, хүмүүстэй ярилцахад гэх мэтээр ашиглаж болно. Мөн нийгмийн сайн сайхны төлөө хэдий ч олигтой анхаарал татаж чаддаггүй ХҮНИЙ ЭРХ гэх мэт сэдвийн хүрээнд кампанит ажлуудыг удирдаж үр нөлөөнд хүрэхэд ашиглах боломжтой.

Жишээ нь; **#MeToo хөдөлгөөн** 2006 онд АНУ-ын нийгмийн идэвхтэн Тарана Берк санаачилсан бөгөөд хүчирхийллийн золиос болсон хүмүүсийг нэгтгэн дэмжих зорилготой өрнөсөн. 2017 онд дэлхий даяар түгэж, олон хүн өөрийн түүхийг хуваалцсан ба одоо ч үр дүн нь үргэлжилсээр байгаа. Тэгвэл энэ хүрээнд ямар "Nudge Theory" аргууд хэрэглэгдсэнийг задалж үзье.

- 1. Олзоос илүү гарз - Loss Aversion Frame** (☑ хүчтэй хэрэглэсэн) Чимээгүй байдлаас болж хэчнээн амьдрал, ажил мэргэжил, ирээдүйн боломж алдагдаж, үгүй болсон бол?
- 2. Үнэ цэн бүхий боломж – Potenal Value Frame** (☑ хүчтэй хэрэглэсэн) Хэрэв бид хохирогчдыг дэмжиж, дарамтыг эцэслэвэл нийгэмд маань ямар болж өөрчлөгдөх вэ?

3. **Эсрэгцүүлэх – Contrast Frame** (☑хүчтэй хэрэглэсэн) Тухайн үед энгийн үзэгдэл мэтээр ойлгогдон дуугаа хориулсан хохирогч бүхэн дуугарах эрхээ өнөөдрөөс эдэлж эхэллээ.
4. **Хар толбо - Blemish Frame** (☑сайн хэрэглэсэн) “Төгс хохирогч” гэсэн ойлголтыг эвдэж, “толбо бүхий” хохирогч ч шударга ёсыг тогтоох, үндсэн эрхээ эдлэх эрхтэй гэдгийг ойлгуулахад түлхэц болсон. Жишээ нь, биеэ үнэлэгч, ял эдэлж байсан, бэлгийн дарамт учруулагчтай үерхдэг байсан г.м
5. **Алдагдсан боломж - Opportunity Cost Frame** – Хохирогчийг түлэх тоолондоо, нийгмийг сайжруулах боломжоо алдаж байна
6. **Ужгирсан алдагдал - Sunk Cost Frame** Та олон жил чимээгүй байсан ч үүрд дуугүй байх шаардлагагүй.
7. **Туршлагын цар хүрээ – Experience Frame** Хувь хүмүүсийн түүх, дурсамжаар дамжуулан өгүүлэмжийг бүрдүүлдэг арга.
8. **Хөтөлгөө — Anchoring Frame** Соёлын болон сэтгэл хөдлөлийн анкорууд ашиглагдсан. Жишээ нь, “Гурван эмэгтэй тутмын нэг нь амьдралдаа доромжлолд өртдөг” гэх мэт.
9. **Хязгаарлагдмал сонголт – Less is More / Fewer Options Frame** #MeToo хаштаг нь энгийн, ойлгомжтой, товч жишээ нь



БИЗНЕС ДЭХ ХҮНИЙ ЭРХИЙН СЭДВЭЭР “ХАДААС” НИЙТЛЭЛ БИЧИХ НЬ

“Бизнес дэх Хүний эрх” гэдэг үгээр хүмүүс гүүгл (google) хайлт бараг хийдэггүй. Тэд ихэвчлэн олны танил алдартнууд, хувцас загвар, видео тоглоом зэрэг алжаал тайлах, зугаацуулах сэдвийг сонирхож тийм мэдээ мэдээлэлд хөтлөгддөг. Гэтэл сэтгүүлчид хэрэглэгчдийнхээ сонирхолд хөтлөгдөөд хүмүүст таалагдаж хандалт авах сэдэв, эх сурвалжийг сонгох нь нийтлэг. Жишээ нь: олны танил, алдартай хүмүүсийг нэвтрүүлэг, нийтлэлдээ оролцуулж тухайн сэдвийг олон нийтэд хүргэхийг зорьдогтой ижил. Өөр нэг ойролцоо жишээ, НҮБ сайн санааны элчээрээ Padma Lakshmi-г сонгосон шиг.

Хэрэв та редактор бол өөр өнцгөөс сэтгэж чаддаг хүнийг сонгож ажиллуул, мөн нэвтрүүлэгтээ ч арай өөр зочдыг урьж оролцуулаад үзээрэй. Жишээ болгоход, Их Британийн “Blood, Sweat and T-shirts” нэртэй нэвтрүүлэгт мэргэжлийн сэтгүүлч биш зөвхөн загварын хорхойтон залуусыг оролцуулж, тэднийг Энэтхэгийн хувцасны үйлдвэрт ажиллуулсан. Үр дүнд нь энэ сэдвийг хэзээ ч сонирхохгүй байсан залуусын анхаарлыг татаж, тэдний мэдэхгүй “Бизнес дэх Хүний эрх” сэдвийг тэдэнд ойлгуулж чадсан юм. Эрсдэл гаргаж бүтээлчээр сэтгэж чадвал үзэгчдийг инээлгэж, уяртал нь санаа сэдэл өгч нөлөөллийг бодитоор үзүүлж чадна.

БҮТЭЭЛЧ ӨГҮҮЛЭМЖ

Бизнес дэх хүний эрхийн тухай түүхийг олон нийтэд хүргэхийн тулд бүтээлч өгүүлэмж ашигла. Нэг хүний түүхээр дагнах, олон хүний түүхээр хүч нэмэх зэргээр бодит байдлыг өгүүлсэн түүх бүтээ.

ХҮЧТЭЙ ТОО, ЭШЛЭЛ АШИГЛА

Сэтгэлд хоногшсон нэг тоон баримт, зураг эсвэл хүчтэй эшлэл мянган үгнээс илүү нөлөөтэй байдгийг сэтгүүл зүйн олон бүтээлээс харж болно.

НЭР ХҮНДИЙГ АШИГЛА

Хүний эрхийг хамгаалах чиглэлд алдартнуудаар дамжуулан сонирхол татах нь шалгарсан арга хэдий ч хэнийг сонгохоо зорилтот уншигчдын мэдээлэлд үндэслэх нь чухал. Залуучуудад нөлөөлөгч чухал бол ахмадад баримт чухал гм.

ЗОРИЛТОТ УНШИГЧДАА САЙН ТАНЬ

Боловсролтой, өдөр тутам мэдээлэл авдаг, мэдрэмжтэй уншигчдад хэт энгийн, хөнгөн хандах нь тэднийг залхаана. Харин хэт техникийн үг хэллэг ашиглаж, нуршуу, хавсарсан нийлмэл өгүүлбэрээр бичих нь зарим уншигчдаа алдахад хүргэнэ. Хэрэв та чөлөөт сэтгүүлч бол аль хэвлэл мэдээлэлд хандаж нийтлэлээ өгөхөө шийдээрэй. Таны зорилтот уншигч тэнд байгаа юу?

ХҮРГЭХ СУВАГ БА ХЭЛБЭР

Подкаст, ТВ-ийн шууд ярилцлага, цахим талбарын мэдээ, хэвлэмэл сэтгүүл зүйн онцлох ярилцлага, сурвалжилга гэх мэт сэтгүүл зүйн бүтээлийн төрөл зүйл, хэлбэрээ редакцынхантай ярилцаж шийдээрэй. Гол нь таны бүтээлийн зорилтот хэрэглэгчид хаана байна, тэд ямар хэлбэрээр мэдээлэл хүлээж авч байна гэдгийг урьдчилан тандан мэдсэнээр таны бүтээл олон хүн хүрэх боломжтой.

БИЧИХ УР ЧАДВАРАА ХӨГЖҮҮЛЭХ НЬ

Товч тодорхой гарчиг өгөх /3-4 үгтэй гарчиг тохиромжтой/. Ерөнхий нэршлээр, мөн учир битүүлэг гарчиг өгөхөөс зайлсхий.

Тоотой ажилла, хялбаршуул. Уншигчдад яг үнэндээ 32.524 гэдэг тоо огт хэрэггүй. Харин 32.5 эсвэл 1/3 эсвэл бүүр гурван хүн тутмын нэг нь гэвэл ойлгомжтой санагдана. 500 сая гэхийн оронд хагас тэрбум байж болно.

Нэг л үндсэн санааг тууштай товч тодорхой өгөх

Нэг өгүүлбэрт орох үгийн тоо 14-өөс илүүгүй байвал ойлгомжтой байдаг. Урт, богино өгүүлбэрээр сөөлжлүүл.

Төвөгтэй үг хэллэг нь тайлан уншиж байхад тааралддаг. Сэтгүүлчийн ажил бол үүнийг хүмүүст энгийн бөгөөд ойлгох хэлээр хялбаршуулж тайлбарлах. Ойлгомжгүй урт өгүүлбэр, төөрөгдүүлэм товчилсон үг, бизнес, санхүүгийн хүнд нэр томъёог тайлбарлаж, ойлгомжтой болгох нь сэтгүүлчийн чухал ур чадвар.

Жишээ, баримт, бодит үйл явдал, түүхэн харьцуулалт зэргийг нуршилгүйгээр оновчтой ашигла. Бичлэгийн хувьд сонирхолтой жишээ, түүхийг өгүүлэх нь уншигчдыг татдаг. Хэт их текстийг нэлэнхүйд нь өгөхөөс зайлсхийж санаа бүрийг тусгаарлаж, мөр хоорондын зай авч агаартай байлга. Мөн техникийн ойлгоход төвөгтэй мэдээллийг эхэнд нь өгвөл нийтлэлийг цааш уншихгүй гэдгийг анхаараарай.

Үндсэн санаанаас хазайхгүй өөр сэдэв ба дэд сэдэв рүү хальтрахгүй байх. 50 үгтэй 5 өөр санаатай урт нуршуу өгүүлбэрүүдээс зайлсхийгээрэй.

Уншигчид ямар хамааралтай вэ гэдгийг бодон бодон бич. Хүмүүс өөрт нь хамааралтай зүйлд л анхаарлаа хандуулж, оролцдог, түүний төлөө зүтгэдэг гэдгийг байнга санаарай.

Хэлэхээс илүү үзүүл. Жишээ нь, салхитай өдөр гэхээс илүү малгай авч шидсэн салхитай өдөр. Боломжтой бол үнэртүүл.

Ирээдүйг хэлж өг. Өнгөрснийг бид мэднэ. Тухайн сэдэвт ирээдүйг харсан өнцөг байвал тэр хэсэгт төвлөрч, үүний дараа юу болохыг хэлж өг. Ингэснээр уншигчид асуудлыг анхаарлаасаа холдуулахгүй байх, шийдлийг оновчтой хэрэгжүүлэх, бизнесээ төлөвлөх зэргээр тэдний олон шийдвэрт сэтгүүл зүйн бүтээлээрээ дамжуулан тусалж чадна.

БИЧВЭРИЙГ НЯГТЛАХ ЖАГСААЛТ

Гарчиг

- Гарчиг унших хүсэл төрүүлэхүйц байх
- Хүчтэй, идэвхтэй үйл үг агуулсан байх

Эхний хэдэн догол мөр (Лийд)

- “Хэн, юу, хаана, хэзээ, яагаад, хэрхэн?” гэсэн асуултуудыг хамарсан
- 30-аас доош үгтэй эхлэл өгүүлбэрт гол түлхүүр үгсийг ашигласан
- Мэдээллийн эх сурвалж, баримт хаанаас гарч ирснийг тайлбарласан
- Өргөн хүрээнд “Яагаад энэ чухал вэ?” гэсэн асуултад хариулсан
- “Би үүнийг яагаад бичиж байна вэ?” гэсэн шалгуурыг давсан
- Уншигчдад хамаатай, сонирхолтой байдлаар хүргэсэн
- Эхлэл хэсгийг дараа дараагийн баримтууд баталж дэмжсэн

Үндсэн хэсэг (их бие)

- “Урвуу пирамид” бүтэцтэйгээр, хамгийн чухал мэдээллээс эхэлж логик дарааллаар баримтуудыг хүргэсэн
- Энгийн, ойлгомжтой хэлээр бичсэн
- Ирээдүйд юу болох талаар мэдээлэл өгсөн
- Мэргэжлийн, ойлгомжгүй үг хэллэгийг тайлбарласан
- Өмнөх түүхийг бага хэмжээгээр дурдаж, оновчтой байршилд, зохих хэмжээгээр хослуулсан
- Ярилцлагуудаас үнэ цэнтэй эшлэл, дүр зураг, өнгө төрхүүд бүхий дүрслэл багтаасан
- Баримтыг “өгүүлж” бус, “үзүүлж” өгсөн (show, don’t tell зарчим)

Та эдгээр нийтлэг алдаануудыг гаргасан уу? (Шалгах жагсаалт)

- Мэдээний эхэнд сул гарчиг, лид ашигласан
- Ямар 10 түлхүүр #keywords үгийг ашиглахыг бодолцож үзээгүй
- Ач холбогдлыг хамгийн дээр байршуулж бичээгүй
- Түүхийг хэт өнгөрсөнд төвлөрүүлсэн
- Эхлэл хэсэгт уншигчийг хэт их нэмэлт мэдээллээр залхаасан
- Мэргэжлийн хэллэг хэрэглэсэн ч, тайлбарлаагүй, хялбаршуулаагүй
- Олон янзын асуудал руу хальтирч, үндсэн сэдэвтээ сайн захирагдаагүй
- Баримт андуурсан, нэг 0 илүү бичсэн, хэт их тоо ашигласан

Бичвэрээ улам чамбайруулах (Шалгах жагсаалт)

- Бүх баримтыг нягтлан шалгах. Үнэн зөв байдал МАШ чухал. Худал мэдээлэл орсон эсэх;
- Найдвартай эх сурвалж санал болгох. Эх сурвалжийн үнэнч байдлыг шалгах. Нэр нууцлах тохиолдолд ч эшлэлтэй байх;
- Баримт бүрийг батлах нэмэлт эх сурвалж олох; интернэтээс олсон мэдээллийг давхар нягтлах;
- Мэдээлэл хаанаас ирснийг тодорхой тайлбарлах;
- Мэдээлэлд мөнгө төлөхөөс зайлсхийх. Эх сурвалж баримтыг хэтрүүлж ярих магадлалтай;
- Баримтад тулгуурласан логик дүгнэлт гаргах, түүнийг батлах;

Дэмжсэн ба эсрэг байр сууриудыг зэрэгцүүл. Нотлох баримтаас гадна үгүйсгэсэн баримтыг ч мөн ашиглах;

- Үзэл бодлын ялгаваргүй, нэг талыг бариагүй, шударга байгаагаа харуулах;
- Энгийн иргэдийн үзэл бодлуудыг мөн төлөөлөх;
- Талуудад хүндэтгэлтэй хандаж, ёс зүйтэй байх;
- Энэхүү нийтлэлийг гаргаснаар ямар нэг хохирол, аюул учрахаас сэргийлсэн байх;
- Тухайн асуудлыг хуульчтай хэлэлцэж, асуудлын нөлөөллийн цар хүрээг үнэлэх;

АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ШАЛГАХ ЖАГСААЛТ

✓ 1. Төлөвлө, бэлд, урьдчилан сэргийл

Та тухайн орчны эрсдлийг сэдвээ гүнзгийрүүлэн судалж байгаа шигээ нягталж шалгаж үзсэн үү? Бусад сэтгүүлчээс тухайн нөхцөл байдлын талаар лавлаж асуусан уу? Эрсдлийн үнэлгээ хийсэн үү?

✓ 2. Аяллын төлөвлөгөөгөө давхар нягтал

Сэтгүүлчид ихэвчлэн өндөр эрсдэлтэй газарт амь насаа алдаж, хулгайлагддаг. Жилд нэг сая гаруй хүн зам тээврийн ослоор нас бардаг. Машинаа шалгасан уу? Суудлын бүсээ зүүсэн үү? Жолооч тань согтуу биш гэдэгт итгэлтэй байна уу? Ялангуяа шөнө явах замын аюулгүй байдлын талаар орон нутгийн мэдээллийг авсан уу? гэдэгтэй яг ижил сэтгүүлчид ч өөрийн ажиллах талбар, аяллын маршрутаа заавал нягтлан шалга.

✓ 3. Дижитал аюулгүй байдлаа ханга

Таны авч яваа зүйл дотор өөрийг тань болон эх сурвалжаа эрсдэлд оруулах ямар нэгэн мэдээлэл байгаа юм биш биз? Зарим хүн “burner phone” буюу хэрэглээд хаяж болох гар утас авч явдаг. Мөн баригдах магадлалтай үед өгөгдлөө устгах, төхөөрөмжөө цэвэрлэх нь нийтлэг авдаг арга хэмжээ юм.

✓ 4. Хувцсаа зөв сонго

Хачин санагдаж болох ч жагсаал цуглааны үеэр зөв гутал өмсөх нь залуу сэтгүүлчдэд чухал зөвлөгөө болдог. Даалгаварт тань тохирсон, анзаарагдахгүй, эвтэйхэн хувцас сонгосон уу?

✓ 5. Нөхцөл байдлыг урьдчилан үнэл

Жагсаал бол мэдээллийн чухал эх сурвалж хэдий ч жагсагчид ч, хууль сахиулагчид ч сэтгүүлчдийг “БАЙ” гэж харах магадлал өндөр. Бүх нийтийн үймээн, самуун болох газрыг урьдчилан таамагласан уу? Гарах замаа тодорхойлсон уу? Ослын газар та очих нь аюулгүй эсэхийг урьдчилан шалгасан үү?

✓ 6. Үнэмлэхээ авч яваарай

Ихэнх тохиолдолд өөрийгөө сэтгүүлч гэдгээ тодорхой байлгах нь чухал. Жишээлбэл, гэмт хэргийн газар очсон үедээ үзүүлэх бичиг баримт байна уу? Харин далд сурвалжилга хийх бол редакц онц бэлэн байдалд шилждэг. Хэрэв сэтгүүлч баригдвал өндөр эрсдэл дагуулах учир урьдчилан сэргийлэх болон нөхцөл байдалд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөгөө бэлэн байлгаарай.

✓ 7. Эрүүл мэндээ анхаар

Аялалд явахад биеийн байдал тань хэвийн үү? Ус, хүнс, эм тан авч явсан уу? Анхны тусламжийн иж бүрдэл багласан уу? Сэтгэл зүйн дарамт, нөлөөллийн талаар урьдчилан бодсон үү?

✓ 8. Бусадтай хамтар


Зурганд анхаарч байхад Та орчноо бүрэн анзаарч чадалгүй аюулд орох, бэртэх гэмтэх магадлалтай. Хэрэв та ганцаараа биш бол өөр сэтгүүлчидтэй хамтарч, бие биенээ дэмжих боломж бий юу?

✓ 9. Байршлаа хуваалц

Та хэзээ эргэж ирэхээ хэн нэгэнд хэлсэн үү? Хэрэв баривчлагдах, алга болох эрсдэл гарвал таныг хайж эхлэхэд цаг алдахгүй.

✓ 10. Ямар ч нийтлэл таны амь наснаас үнэтэй биш.

Заримдаа та зүгээр л ухарч, тухайн нөхцөл байдлаас холдож аюулгүй байдлаа хамгаалах ёстой.



ЭХ СУРВАЛЖИЙН СҮЛЖЭЭГЭЭ ӨРГӨТГӨХ 10 ЗӨВЛӨМЖ

Сэтгүүлч итгэл төрүүлдэг, хандахад амар, харилцахад саадгүй хүн байх ёстой. Ингэснээр мэдээлэл задруулах боломжтой (whistleblower) эх сурвалжууд өөрийнх нь нэрийг нууцлана гэдэгт итгэлтэйгээр ирж Тантай түүхээ хуваалцах болно.

Мөн тухайн сэдвээр ажилладаг төрийн бус байгууллага, иргэний нийгмийн идэвхтнүүд цаг үеийн анхаарал татахуйц тайлан гаргасан бол та хамгийн түрүүнд хуваалцдаг хүмүүсийнх нь нэг байх хэрэгтэй. Ингэснээр та шинэ мэдээлэл, чухал эх сурвалжуудын сүлжээнд байж чадна.

Бизнес дэх хүний эрхийн сэдвээр бүтээл хийхээр төлөвлөсөн бол хамгийн түрүүнд, бас тогтмол уулзах эх сурвалж тань иргэний нийгмийнхэн, төрийн бус байгууллагууд байх болно. Тэд энэ хүний эрхийг хамгаалагчид, өдөр бүр чих тавин сонсож хараа тавин ажиглаж байдаг хүмүүс. Гэхдээ бусад эх сурвалжуудын нэгэн ижил хэт дотно харилцаа үүсгэхээс сэргийлээрэй. Хэт найзархаг, дотно харилцаа нь сэтгүүлчийн төвийг сахих байр сууринд сөргөөр нөлөөлж, асуудлыг бүдгэрүүлдэг.

1. Уулзаж танилц - нүүр тулан уулз

Таныг илүү сайн мэдэх тусам мэдээлэл өгөх магадлал нэмэгддэг.

2. Зөвхөн анхаарал татсан мэдээ гарсан үед бус, нам жим үед ч холбоотой бай

Тогтмол холбоо итгэлцлийг бий болгодог. Итгэлцэл үүссэн үед танд л ханддаг найдвартай эх сурвалж болно.

3. Эелдэг, тааламжтай харьц

Мэдээллийн эх сурвалжаа хувийн үзэл бодлоор шүүмжлэх, уурлах, ялангуяа хоолойны өнгө, үгийн сонголтоо хурц, ширүүн болгохоос зайлсхий. Эх сурвалж бол таны бүтээлийн цөм байх болно.

4. Сэдвийн талаар өөрийн мэдэж буйг хуваалц

Сэдвээ мэддэг хүнтэй ярилцаж байна гэж бодвол хүмүүс мэдээлэл өгөхөд илүү бэлэн, нээлттэй болдог.

5. Тэвчээртэй хүлээ

Харилцаа, итгэлцэл цаг хугацаа шаарддаг.

6. Ярилцлагын нөхцлийг урьдчилан тохир

Нэр дурдагдах эсэх, албан ёсны эх сурвалж байх эсэх, мэдээлэл өгөх хүрээний ярилцлага уу, эш татагдах уу гэх зэргээр оролцоог нь тодорхой болгоорой. Мөн мэдээллийг ямар нөхцөлд ашиглаж, эх сурвалжийг хэрхэн тодорхойлохоо тайлбарла.

7. Бусад сэтгүүлчид хэнтэй ярьж байгааг мэд

Тэдний эх сурвалж таны ч эх сурвалж болох боломжтой.

8. Сонин, мэргэжлийн сэтгүүл, вэбсайтаас хайлт хий

Шинэ сэдэв, шинэ эх сурвалж, мэдээний орон зайг байнга эрэлхийл, тогтмол шинэ мэдээ, шинэ өнцөг санааг хайж бай.

10. Хэвлэлийн хурал, уулзалтад оролц

Нэрийн хуудас цуглуул. Заавал мэдээ бичих албагүй. Харилцаа эхлүүлэх зорилготой байхад дараагийн алхамууд гараад л ирнэ.

АШИГЛАСАН БОЛОН НЭМЭЛТЭЭР СУДАЛЖ БОЛОХ ЭХ СУРВАЛЖУУД

1. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Бизнес дэх хүний эрхийн асуудлаар сурвалжлах нь: Сэтгүүлчид, мэдээлэл харилцааны ажилтнуудад зориулсан гарын авлага - [Reporting Business and Human Rights: A Handbook for Journalists, Communicators and Campaigners - United Nations Development Programme](#)
2. НҮБ-ын Бизнес ба Хүний эрхийн удирдах зарчмууд - [НҮБ-ын Бизнес ба Хүний Эрхийн Удирдах Зарчмууд | United Nations Development Programme](#)
3. НҮБ-ын Бизнес ба Хүний эрхийн удирдах зарчмуудын жендэрийн удирдамж - [Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмуудын жендэрийн удирдамж | United Nations Development Programme](#)
4. Бизнесийн үйл ажиллагаанд хүний эрхийг хамгаалах, хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх үйл ажиллагааны төлөвлөгөө (2023-2027), Засгийн Газрын 231 дүгээр тогтоолын хавсралт - [ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ \(бизнесийн үйл ажиллагаанд хүний эрхийг хамгаалах, хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх\)](#)
5. Хүний хувийн мэдээллийг хамгаалах нь: Аж ахуйн нэгж, байгууллагуудад зориулсан гарын авлага - [Хүний хувийн мэдээллийг хангах нь: Аж ахуйн нэгж, байгууллагуудад зориулсан гарын авлага | United Nations Development Programme](#)
6. Бизнесийн үйл ажиллагааны хүний эрхэд үзүүлэх нөлөөлөл - Суурь судалгааны тайлан - [Бизнесийн үйл ажиллагааны хүний эрхэд үзүүлэх нөлөөлөл суурь судалгааны тайлан 2022 | United Nations Development Programme](#)
7. Сургалтын гарын авлага: Хүний эрхийн магадлан шинжилгээ - [Хүний эрхийн магадлан шинжилгээ сургалтын гарын авлага | United Nations Development Programme](#)
8. Speak Up, Speak Out: A Toolkit for Reporting on Human Rights Issues ([Internews SpeakUpSpeakOut_Full.pdf](#))
9. Resources on Human Rights - Global Investigative Journalism Network ([Resources on Human Rights – Global Investigative Journalism Network](#))
10. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлүүд [Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс](#)
11. Жендэрийн мэдрэмж, ёс зүйтэй сэтгүүл зүй, Редакцуудад зориулсан удирдамж, Хэвлэл Мэдээллийн Зөвлөл ТББ, УБ хот, 2021 он
12. Улс төрийн мэдээллийн агуулгад жендэрийн тэгш байдлыг хангах нь, Редакцуудад зориулсан удирдамж, Хэвлэл Мэдээллийн Зөвлөл ТББ, УБ хот, 2022 он
13. Сонгуулийг мэдрэмжтэй сурвалжлах нь, Редакцуудад зориулсан удирдамж, Хэвлэл Мэдээллийн Зөвлөл ТББ, УБ хот, 2024 он

Хавсралт 1:

БИЗНЕС ДЭХ ХҮНИЙ ЭРХИЙН ЧИГЛЭЛЭЭР БИЧИЖ НИЙТЛЭХЭД БАРИМТЛАХ УДИРДАМЖИЙН ЗАГВАР ЖИШЭЭНҮҮД

Нэг. The Economist Style Guide – Сэтгүүлийн бичлэгийн хэв маягийн удирдамж

Ерөнхий агуулга:

“The Economist Style Guide” нь тодорхой, товч боловч уран яруу бичих зарчмуудаар алдаршсан. Энэ нь тус сэтгүүлийн нэр хүнд, хошигнолын ухаалаг хэрэглээг илтгэдэг бөгөөд бизнес, улс төр, олон улсын сэдэвт зориулсан бичлэгийн дүрэм, зөвлөмжийг агуулдаг.

Гол зарчмууд:

- Тодорхой ба товч бичих
- Урт өгүүлбэрээс илүү богино өгүүлбэр, үгсийг сонгож хэрэглэх
- Техникийн үг хэллэг, албаны хэт төвөгтэй хэлбэрээс зайлсхийх
- Идэвхтэй төлөв байдлаар бичих (“Засгийн газар татварыг нэмэгдүүлэв” гэх нь “Татвар нэмэгдсэн” гэхээс илүү үр дүнтэй)

1. Нарийн нямбай, үнэн зөв байдал

- Хоёрдмол утгагүй, ойлгомжтой үгс сонгох
- Тоо баримт, огноо, эшлэл бүрийг шалгах

2. Дүрэм ба хэрэглээ

- Үйлт нэр, тэмдэг нэр хэтрүүлэн хэрэглэхээс зайлсхийх
- Британийн англи хэлний үсгийн дүрмийг дагах (Жнь: «labour», «centre»)
- Нийлмэл нэр үгс дээр ганц тооны үйл үг хэрэглэх (“багаараа ялав”), харин гишүүдэд анхаарлаа хандуулж буй үед олон тооны үйл үг ашиглах (баг дотор хоорондоо маргалдацгааж байна)

3. Цэг тэмдэг

- Цэг таслалыг цөөн хэрэглэ, гэхдээ ойлгомжтой байдлыг ханга
- Анхааруулах тэмдгийг (!) зөвхөн эшлэлд хэрэглэ
- Шууд эшлэлд “**давхар**” **хашилт**, эшлэл доторх эшлэлд ‘нэг’ хашилт хэрэглэ

4. Тоон мэдээлэл

- 1–9 хүртэл тоог үгээр, 10 ба түүнээс дээш тоог цифрээр бичих
- “5,000,000” биш “5m” гэж бичих
- “хувь” биш % тэмдэг ашиглах

5. Нэрс, цол, том үсэг

- Эхэлж бичихдээ бүтэн нэрээр, цаашид зөвхөн овог (Жнь: "Emmanuel Macron", дараа нь "Mr Macron")
- Том үсгийн хэрэглээг багасгах
- "Mr", "Ms" эсвэл цол хэргэмийг 'Ерөнхийлөгч Макрон' албан ёсны бичвэрт хэрэглэнэ

6. Гадаад үг хэллэг

- Хэрвээ түгээмэл ойлгогддог бол ашигла, үгүй бол орчуул

7. Хошигнол ба ухаалаг хэрэглээ

- Хошигнолыг болгоомжтой хэрэглэ—хэт хүчлээгүй, санааг дэмжихүйц нийцтэй, ухаалаг байлгах
- Давтагдмал зүйр үг, хэт их хэрэглэгдсэн хэлц үгнээс зайлсхийх

Хоёр. The New York Times Style Guide – Сонины бичлэгийн хэв маягийн удирдамж

Ерөнхий агуулга:

NYT-ийн бичлэгийн хэв маяг нь албан ёсны, ойлгомжтой, төвийг сахисан шинжтэй. Нягт нямбай, баримтуудад хүчтэй тулсан, үр дүнд хүрэх хүртэл тууштай сурвалжилдаг байдал нь энэхүү хэв маягийн үндэс юм.

Гол зарчмууд:

1. Ойлгомжтой, төвийг сахисан байр суурьтай бичих

- Гол санаа руу шууд чиглэсэн, тодорхой энгийн бичих
- Үзэл бодол, шаардлагагүй тэмдэг нэр, хэт нэг талыг барихаас зайлсхий
- Сэтгэл хөдөлгөх гэсэн, тал зассан, хэт тодотгосон үгсийг ашиглахгүй байх

2. Дүрэм, өгүүлбэрийн бүтцийг дагах

- Америкийн англи хэлний дүрмийг дагах
- Өгүүлбэрээ идэвхтэй төлвөөр бичих
- Богино, ойлгомжтой өгүүлбэр хэрэглэж болох ч гүнзгий мэдэх хүслийг гүйцээ

3. Цэг тэмдэг

- Oxford comma хэрэглэдэггүй (ж. "red, white and blue")
- Цэгийн дараа ганц зай
- Em dash (—) хооронд зай тавихгүй хэрэглэнэ. Гишүүн— өнгөрсөн жил сонгогдсон— хэлэхдээ
- Анхааруулах тэмдэг (!) бараг л хэрэглэдэггүй

4. Нэрс ба цол хэргэм

- Эхний удаа бүтэн нэр, дараа нь зөвхөн овог хэрэглэнэ (ж «President Joe Biden» but «Joe Biden, the president, said...)
- "Mr.", "Ms." гэх зэрэг хүндэтгэлийн цол хэрэглэдэггүй
- "Dr." гэдэг цолыг зөвхөн эмчид хэрэглэнэ. PhD хүмүүст хамаарахгүй

5. Тоон мэдээлэл

- 1–9 хүртэл тоог үгээр, 10-аас дээш тоог цифрээр
- Нас, хувь зэрэгт үргэлж цифр хэрэглэнэ (ж. «5 percent»)
- Олон тэгтэй тоонд «million», «billion» байдлаар бичнэ (\$2 million гэх мэт)

6. Том үсэг ба налуу бичих

- Хэрэгцээгүй бол том үсгээс зайлсхий
- Кино, ном, сонин сэтгүүлийн нэрийг хашилтанд, налуу биш бичнэ «*To Kill a Mockingbird*»
- Вэбсайтыг жижиг үсгээр (ж. nytimes.com)

7. Огноо ба цаг

- Огноо: Monday, March 11, 2024
- Цаг: 10:30 a.m., 5 p.m. (AM, PM биш)
- "st", "nd" гэх зэрэг дэс тооны төгсгөл нэмдэггүй (March 1 биш March 1st)

8. Товчлол, нэр томъёо

- Эхэлж бичихдээ бүтнээр нь бичиж, хаалтанд товчилсон хувилбарыг оруулна Federal Bureau of Investigation (F.B.I.).
- Нийтэд танигдсан товчлолыг (NASA, NATO) шууд хэрэглэж болно

9. Гадаад хэл дээрх үг хэллэг

- Хэрвээ нийтэд түгээмэл биш бол налуу бичгээр тэмдэглэх
- Гадаад хэл дээрх эшлэлийг орчуулах

10. Тэгш, мэдрэмжтэй хэллэг

- Хүйс заасаан хэвшмэл үгсийг хүйсийн ялгаварлалгүй үгээр орлуулах (ж. Fireman гэхийн оронд firefighter = гал сөнөөгч)
- Арьс өнгө, хөгжлийн бэрхшээлтэй холбоотой хоцрогдсон, мэдрэмжгүй үгсийг сонгохгүй байх; Өнгөт арьстан, тахир дутуу, сохор, тэргэнцэртэй хүн, сэтгэцийн өвчтэй г.м
- Хүний өөрийнх нь хүсэлтийн дагуу нэр, хүйсийг оруулах

Гурав. Хүний эрхийн талаар бичихэд баримтлах бичлэгийн хэв маягийн удирдамж

Зорилго:

Мэдрэмжтэй, үнэн зөв, хүний нэр төрийг хүндэтгэсэн мэдээлэл дамжуулах зорилготой. Хэвшмэл ойлголт, ялгаварлан гадуурхалтаас зайлсхийж, хүн төвтэй бичихийг зорьдог.

1. Amnesty International – Хэвлэл мэдээллийн зөвлөмж

- “Хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэж бичих (“тахир дутуу” гэдэг нэршлээс зайлсхийх)
- Орон гэргүйчүүд гэхийн оронд “Гэр оронгүй хүмүүс” гэх зэрэг хүн төвтэй нэршил хэрэглэх
- “Хохирогч” биш “амьд үлдсэн хүн” гэх нэршил хэрэглэвэл зохино

2. Human Rights Watch – Тайлан бичих зөвлөмж

- Хууль зүйн нэр томъёог зөв хэрэглэх (“тамлал” гэх мэт)
- “Албадан хөдөлмөр” гэх тодорхой нэр томъёог хэрэглэж, сайн дурын бус ажил гэх мэтээр зөөлрүүлэн хөнгөлж бичихгүй байх
- Хүний нэр, хүйс, өөрийн танилцуулгыг хүндэтгэх
- Түүхэн, улс төрийн нөхцөлийг багтааж бичих

3. Нэгдсэн Үндэстний Байгууллага – Редакцын гарын авлага

- Хүйс заасан үгээс зайлсхийж, төвийг сахисан нэр томъёо хэрэглэх (Жнь: Chairman биш chairperson)
- Барууны нэр томъёог бусад соёлд хүчээр тулгахгүй байх
- Хүчээр бол “Дүрвэгч”, өөрийн хүслээр бол “Цагаач” гэх мэт хуулийн ялгаатай ангиллыг ялгаж бичих

Дөрөв. Associated Press Stylebook – Хүний эрх, жендэрийн хэвшмэл ойлголтоос сэргийлэх бичлэгийн хэв маягий удирдамж

- LGBTQ+ бэлгийн чиг хандлагын нэр томъёог зөв, хүндэтгэлтэйгээр хэрэглэх
- Арьс өнгө, угсаа гарал зэргийг зөвхөн хамаатай үед л дурьд
- “Хар тамхинд донтогч” биш, “хар тамхины хамааралтай хүн” гэх нэршил хэрэглэх
- Шүүхээр нотлогдоогүй тохиолдолд гэмт хэрэгтэн гэж бичихгүй байх, ийм санаа ч цухалзуулахгүй байх

Тав. Ethical Journalism Network (EJN) – Ёс зүйн хэм хэмжээг мөрдөх удирдамж

- Сенсац хөөсөн нэр төр сэвтүүлэх мэдрэмжгүй хүндлэлгүй зураг ашиглахгүй байх
- **Хүчирхийлэлд өртсөн хохирогчтой харьцахдаа сэтгэлзүйг нь онцгойлон анхаарч харилцах**
- Хэвшмэл ойлголтоос зайлсхий: Исламууд, хар арьстнууд гэх мэт ерөнхийлж нэг төрлийн байдлаар дүрслэхээс зайлсхийх
- Дуу хоолойн тэнцвэр: Цөөнхийн дуу хоолойг багтаах

Зургаа. Хэвлэл Мэдээллийн Зөвлөл ТББ-аас баталсан “Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим”

Хэвлэл Мэдээллийн Зөвлөл ТББ-ын Ёс зүйн хороодын 2015 оны 04 дүгээр сарын 14-ны өдрийн нэгдсэн хуралдааны нэгдүгээр тогтоолын хавсралт

Монгол улсын Үндсэн хуульд заасан үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрхийг хамгаалан бататгаж, Монголын сэтгүүл зүйн хэм хэмжээ нь хүний эрх, хэвлэлийн эрх чөлөөний олон улсын хэм хэмжээг сахин мөрдөж буйг энэхүү ёс зүйн зарчмаар илэрхийлж байна.

Ёс зүйн зарчим/бүлэг	Ёс зүйн зарчмууд
1. Олон түмэнд үнэнд нийцсэн мэдээлэл хүргэх, хүнлэг ёс, хүн чанарыг эрхэмлэх нь сэтгүүл зүйн эрхэм дээд үнэт зүйл мөн. Мэдээллийг нягтлах нь сэтгүүл зүйн нягт, нямбай үйл ажиллагааны үндсэн зарчим болно.	1.1 Мэдээлэл нь үнэнд нийцсэн эсэхийг баталгаажуулж, санамсаргүй алдаа гаргахаас зайлсхийнэ. 1.2 Эх сурвалжийн баталгаатай эсэхийг нягталж, тодорхой дурдахыг эрмэлзэнэ. 1.3 Бүтээлийн гарчиг, зураг, дүрс, дуу, график, эшлэл зэрэг нь агуулгыг буруугаар ойлгуулах, хэт хялбарчлах, мэдээллийг нөхцөл байдлаас салгаж мушгин гүйвүүлэх ёсгүйг үргэлж санаж, ийм зөрчил гаргахгүйн төлөө ажиллана. 1.4 Фото, видео, аудио мэдээллийн агуулгыг техникийн арга хэрэгслээр гүйвүүлэхгүй. 1.5 Нөлөөллийн болон мэдээллийн бүтээлийг ялгаж, мэдээнд үзэл бодол оруулахаас татгалзана. 1.6 Баталгаагүй мэдээлэл, таамаглал, ам дамжсан яриаг таамаг хэмээн тодорхой дурьдана. 1.7 Хэвлэлийн мэдээг өөрчлөлтгүйгээр нийтэлж, нэвтрүүлбэл редакцын агуулгаас ялгаж тэмдэглэнэ. 1.8 Буруутгагдсан, шүүмжлэгдсэн этгээдэд тайлбар өгөх боломж олгоно. 1.9 Нийтэлж, нэвтрүүлсэн мэдээлэл нь ташаа болох нь тогтоогдсон мэдээллийг нэн даруй залруулна.
2. Мэдээллийг шударга бус аргаар олж авахгүй.	2.1 Сэтгүүлч өөрийгөө танилцуулж, ил тодоор ажиллах нь энэхүү мэргэжлийн үндсэн зарчим болно. Зөвхөн олон нийтийн эрх ашгийг хамгаалах зорилго бүхий, өөр аргаар олж авах боломжгүй мэдээллийг бусад аргаар авч болно. 2.2 Мэдээлэл олж авах бусад арга гэдэгт өөрийн болон байгууллагын нэрийг байх, дарамтлах, сэтгэл санааны онцгой байдлыг ашиглах, нууцаар бичлэг хийх болон дүрд хувирахыг хамаатуулна. 2.3 Хувийн гэрэл зураг, дүрс бичлэгийг ашиглах тохиолдолд тухайн хүний болон насанд хүрээгүй хүмүүсийн асран хамгаалагчийн зөвшөөрлийг авна.

	2.4 Өөрийгөө хамгаалах чадваргүй буюу бусдаас хамаарал бүхий хүнээс мэдээлэл, гэрэл зураг авахдаа мэдрэмжтэй хандана. Энэ нь юун түрүүнд оюун санааны болон бие махбодийн хувьд өөрийгөө захирах чадваргүй, сэтгэл санааны хүнд байдалд орсон хүнд хамаарна. 2.5 Насанд хүрээгүй хүнээс зөвхөн эцэг, эх асран хамгаалагчийнх нь зөвшөөрөлтэйгөөр мэдээлэл авч болно.
3. Хэнийг ч арьс өнгө, яс үндэс, гарал угсаа, хүйсийн байдал, нас, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэнд, бэлгийн чиг баримжаа, шашин шүтлэг, гэр бүлийн байдлаар нь ялгаварлан гадуурхалтын золиос болгохгүй.	3.1 Гэмт хэргийн талаар мэдээлэхдээ тухайн хүний харьяалал шашин, үндэс угсаа, бусад цөөнхийн төлөөлөл рүү зөвхөн тухайн хэргийг ойлгоход маш чухал тохиолдолд хэрэглэнэ. 3.2 Хэвлэл мэдээллийнхэн нийгэмд оршиж байгаа хэвшмэл ойлголтуудыг улам дэвэргэхээс зайлсхийнэ.
4. Аливаа мэдээллийг зохисгүй хэлбэрээр дуулиантайгаар түгээхээс татгалзана.	4.1 Гэмт хэрэг үйлдэгдсэн аргыг нарийвчлан харуулсан нийтлэл, нэвтрүүлэг хийхээс зайлсхийнэ. 4.2 Шүүх гэм буруутайг нь нотлоогүй бол хэнийг ч гэм буруутай гэж үзэхгүй. 4.3 Гэмт этгээдийн талаар үлгэрлэн дууриах, шүтэх өнгө аясаар нийтэлж, нэвтрүүлэхгүй. 4.4 Золгүй явдал, осол, хүчирхийллийн талаарх зураг, дүрсийг мэдээлэхдээ тухайн зураг, дүрс нь хүүхэд, өсвөр үеийнхэнд хэрхэн нөлөөлөх магадлалыг харгалзана. 4.5 Гамшиг, осол, гэмт хэргийн улмаас хохирогсдын цогцсыг нарийвчлан харуулахгүй. 4.6 Осол, гамшиг, гэмт хэргийн зураг, дүрсийг нийтэд хүргэхдээ тухайн хэргийн золиос, түүний ойр дотныхон болон хүүхэд, өсвөр үеийнхэнд уг дүрс хэрхэн нөлөөлж болохыг харгалзаж, онцгой няхуур бөгөөд мэдрэмжтэй хандана.
5. Мэдээллийг мушгин гуйвуулах, бусдыг гүтгэх, доромжлох, мэргэжлийн давуу байдлаа урвуулан мэдээллийг хувийн зорилгод ашиглахгүй. Мөн мэдээлэх, эс мэдээлэхийн тулд аливаа хэлбэрийн авлига авахаас татгалзана.	5.1 Гуравдагч талын санхүүжилтээр аялалд хамрагдсан бол аяллын тухай мэдээлэлд санхүүжилтийн талаар тодорхой дурьдана.

6. Хувийн нууцад хүндэтгэлтэй хандана.	6.1 Хэргийн сэжигтэн этгээдийн нэр, хувийн мэдээлэл болон зургийг бусдад танигдахуйц байдлаар нийтэлж, нэвтрүүлэхдээ хувь хүний эрхийг хамгаалах шаардлагыг харгалзана. 6.2 Зөвхөн олон нийтийн тусын тулд хүний нэр, зураг болон бусад хувийн мэдээллийг нийтэд ил болгоно. 6.3 Олон нийтийн тусын тулд гэдэг ойлголтыг “олон нийтэд сонирхолтой” мэдээлэлтэй эндүүрч болохгүй. 6.4 Гэмт хэрэгт холбогдсон насанд хүрээгүй хүний нэр, хувийн бусад мэдээллийг нийтэд дэлгэхгүй. 6.5 Гэмт хэрэг, ослын хохирогчид нэр, нас, албан тушаал болон бусад хувийн мэдээллээ хамгаалуулах эрхтэй. 6.6 Бие болон сэтгэл санааны эмгэг, эрүүл мэндийн тухай мэдээлэл нь хувийн нууцад хамаарах бөгөөд тухайн хүний болон асран хамгаалагчийнх нь зөвшөөрөлгүйгээр нийтэлж, нэвтрүүлэхийг цээрлэнэ. 6.7 Амиа егүүтгэх тохиолдлыг харуулах, нэн ялангуяа нэрийг нь дурдах, дүрс, нөхцөл байдлыг нь нарийвчлан харуулахаас зайлсхийнэ. 6.8 Тухайн мэдээлэлтэй шууд холбоотой биш л бол гэмт хэргийн сэжигтэн, золиос, хүчирхийлэл, осол гамшигт өртөгсдийн гэр бүл, ойр дотны хүмүүсийн овог нэр, ажил, албан тушаал, гэрэл зураг, дүрсийг тэдний зөвшөөрөлгүйгээр нийтэлж, нэвтрүүлэхгүй.
7. Бусдын үй гашуу, зовлон шаналалд хүндэтгэлтэй хандана.	
8. Мэдээллийн нууц эх сурвалжаа чандлан хамгаална.	
9. Төлбөрт нийтлэл, нэвтрүүлгийг тусгай тэмдэг, тэмдэглэгээгээр ялгана.	9.1 Далд зар сурталчилгааны аливаа хэлбэрээс татгалзана.
10. Хэвлэл мэдээлэл нь сонгуулийн санал хураалтаас өмнө буруутгагдсан этгээдийг тайлбар хийх боломжгүй хугацаанд нэр дэвшигчийн талаар мэдээлэл түгээхээс зайлсхийнэ.	

Хавсралт 2.

БИЗНЕС ДЭХ ХҮНИЙ ЭРХИЙН СЭДЭВТ ХАМААРАХ НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

Англи	Монгол	Тайлбар (Англи)	Тайлбар (Монгол)
Diary story	Сануулах түүхэн мэдээ	A story with a known date in the future, allowing planning ahead. Not usually the main headline.	Ирээдүйд тодорхой товлогдсон, урьдчилан төлөвлөх боломжтой сануулах түүхүүд. Ихэнхдээ гол мэдээний гарчиг биш байдаг.
News peg	Мэдээ холбох цэг	A current news event to which a new story is linked, providing relevance and context.	Шинэ түүхийг холбон нийтлэх боломжтой, одоогийн мэдээний үйл явдал.
Style guide	Хэл найруулгын гарын авлага	A set of editorial rules developed by media outlets for clarity and consistency in language and presentation.	Хэвлэл мэдээллийн байгууллагуудын боловсруулсан, хэл найруулгын нягт, нэгдмэл байдлыг хангах дүрэм, стандартын багц.
Features desk	Онцлох нийтлэлийн редакц	A media house department focusing on long-form journalism rather than daily news.	Өдөр тутмын мэдээнээс илүү урт хэлбэрийн нийтлэлд анхаардаг редакцын нэгж.
Desk editor	Редакцын эрхлэгч	Person responsible for editorial decisions in a section of a media house.	Редакцын тодорхой хэсгийг хариуцсан, редакцын шийдвэр гаргагч.
Audience segmentation	Үзэгчдийг сегментлэх	Dividing audiences by age, region, behavior, etc., to target messages effectively.	Зорилтот үзэгчдийг нас, газарзүйн байрлал, зан төлөвөөр нь ангилж, мэдээлэл үр дүнтэй хүргэх арга.
Agenda-setting theory	Аженда-сеттингийн онол	The concept that media shape public perception by choosing what issues to highlight.	Мэдээллийн хэрэгсэл олон нийтийн анхаарлыг юунд хандуулахыг шийдвэрлэж чаддаг гэх концепц.
Citizen journalism	Иргэний сэтгүүл зүй	Non-professional journalism through blogs, social media, or independent reporting.	Мэргэжлийн бус иргэдийн хийдэг сэтгүүл зүй — блог, сошиал мэдээллийн хэрэгсэл, бие даасан нийтлэл гэх мэт.
Mojo (Mobile Journalism)	Гар утасны сэтгүүл зүй	Journalistic content created using mobile phones.	Гар утас ашиглан сэтгүүлзүйн контент бэлтгэх арга.

Reach	Хүртээмж	The number of people who see or hear a particular media message.	Тодорхой мэдээлэл хичнээн хүнд хүрч, хүлээн авч байгааг илтгэх хэмжүүр.
Business and human rights	Бизнесийн үйл ажиллагаан дахь хүний эрх	Any commercial activity which has an impact - positive or negative - on human rights.	Хүний эрхэд эерэг эсвэл сөрөг нөлөө үзүүлдэг аливаа арилжааны үйл ажиллагаа.
The Guiding Principles	Бизнес ба Хүний эрхийн Удирдах зарчмууд	The UN-endorsed ‘protect, respect and remedy’ framework, sometimes called the Ruggie Principles (after Prof. John Ruggie), explaining the responsibilities of states and businesses in relation to human rights.	НҮБ-ын баталсан “хамгаалах, хүндэтгэх, сэргээх” хүрээний зарчим. Улс орнууд болон бизнесийн байгууллагуудын хүний эрхийн үүрэг хариуцлагыг тодорхойлдог.
State / state actor	Улс / улсын төлөөлөгч	A person or group acting on behalf of a government. The opposite is a ‘non-state actor’ (NSA).	Засгийн газрын өмнөөс үйл ажиллагаа явуулдаг этгээд. Эсрэг ойлголт нь ‘төрийн бус этгээд’ буюу NSA (ТБЭ).
Inalienable rights	Салшгүй эрхүүд	Rights that cannot be taken away. Mentioned in the preamble of the Universal Declaration of Human Rights; includes rights to life, legal protection, employment.	Салшгүй эрхүүд. Хүний эрхийн түгээмэл тунхаглалд дурдагддаг бөгөөд амьд явах, хууль зүйн хамгаалалт авах, хөдөлмөр эрхлэх зэрэг эрхүүд орно.
Human rights violations	Хүний эрхийн зөрчил	Occur when inalienable rights are breached in some way.	Салшгүй эрхүүдийг ямар нэг байдлаар зөрчсөн тохиолдлууд.
Non-binding resolution	Хуулийн хүчин төгөлдөр бус тогтоол	A UN agreement that is a recommendation, not law. A type of ‘soft law’ not backed by enforceable legislation.	НҮБ-ын хуулийн хүчин чадалтай бус зөвлөмжийн чанартай гэрээ. Олон улсын хэмжээнд мөрдөгдөх эрх зүйн заалтгүй ‘зөөлөн хууль’-ийн нэг хэлбэр.
SME (Small and Medium-sized Enterprises)	Жижиг, дунд бизнес (ЖДБ)	Businesses with relatively small size, representing about 90% of companies worldwide. ‘Small businesses’ is often used for general audiences.	Дэлхий даяарх бизнесийн 90 хувийг бүрдүүлдэг жижиг, дунд хэмжээний компаниуд. ‘Жижиг бизнес’ гэж нийтлэг нэрлэдэг.

Worker	Ажилтан	Any individual performing work for a company, regardless of the type of contract or formal relationship.	Гэрээний хэлбэр, албан ёсны харилцаанаас үл хамааран компанид ажил гүйцэтгэж буй хувь хүн.
Supply chain	Нийлүүлэлтийн сүлжээ	The sequence of processes involved in the production and delivery of goods, often complex and international.	Бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэгдэж, хэрэглэгчид хүрэх хүртэлх нарийн төвөгтэй процессуудын дараалал.
Modern slavery	Орчин үеийн боолчлол	Severe and illegal exploitation of people for commercial gain, including forced labor and human trafficking, often hidden yet widespread.	Маш ноцтой, хууль бус аргаар хүмүүсийг арилжааны ашиг олох зорилгоор мөлжих явдал — үүнд албадан хөдөлмөр, хүний наймаа зэрэг багтдаг — ихэвчлэн нууцлаг боловч өргөн хүрээтэй тархсан байдаг.
Top line	Гол санаа	A short, compelling description of a news story, typically with an active verb—used in editorial meetings.	Мэдээний товч, сонирхол татахуйц тайлбар бөгөөд ихэвчлэн үйл үгтэй. Редакцын хурлуудад ашиглагддаг.
NGO / CSO	Төрийн бус / Иргэний нийгмийн байгууллага	Organisations independent of government and business, although some may receive industry funding. Related terms include human rights defenders, non-profit, and non-state actor.	Засгийн газар болон бизнесийн байгууллагаас хараат бус байгууллагууд — зарим нь салбарын санхүүжилт авч болох ч үйл ажиллагааны хувьд бие даасан байдаг. Үүнтэй холбоотой нэр томъёонд хүний эрхийн хамгаалагчид, ашгийн бус байгууллага, төрийн бус оролцогч зэрэг багтана.
Beat	Сэдэв хариуцсан чиглэл	A journalist's area of coverage or expertise (e.g., crime, sports).	Сэтгүүлчийн дагнан сурвалжилдаг, мэргэшсэн сэдэв (жишээ нь гэмт хэрэг, спорт гэх мэт).
Investigative journalism	Эрэн сурвалжлах сэтгүүлзүй	Journalism that exposes hidden or complex issues using original research, sources, and documentation.	Гүн гүнзгий судалгаа, эх сурвалж, баримтад үндэслэн нууцлаг эсвэл нарийн асуудлуудыг ил гаргадаг сэтгүүл зүй.

Churnalism	Хэвлэлийн хуулбар сэтгүүл зүй	The practice of rewriting press releases or online material rather than conducting original reporting.	Хэвлэлийн мэдээ эсвэл интернэтээс мэдээлэл хуулбарлан нийтлэх, анхны сурвалжилга хийгээгүй сэтгүүл зүйн хэлбэр.
Forced labour	Албадан хөдөлмөр	Work imposed under threat or coercion, including through violence, intimidation, debt manipulation, and human trafficking.	Заналхийлэл, хүч хэрэглэх, өрийн дарамтад байлгаж, хүний наймаа зэрэг хэлбэрээр хүнийг хүчээр хөдөлмөр эрхлүүлдэг байдал.
Due diligence	Магадлан шинжилгээ	Steps a company must take to become aware of, prevent, and address risks, particularly human rights impacts.	Бизнесийн байгууллага хүний эрхийн эрсдлийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, шийдвэрлэхийн тулд авах ёстой алхмууд
Human rights defenders	Хүний эрхийн хамгаалагч	Individuals or organizations that promote or protect human rights, often in the context of holding businesses accountable.	Хүний эрхийг хамгаалах, дэмжих зорилготой хувь хүн эсвэл байгууллага.
Manipulated debt	Өрийн занганд оруулах	Debt used as a tool to trap individuals in exploitative work, particularly in supply chains.	Өрөөр барьцаалан ажиллуулж, хөдөлмөрийг нь мөлжиж, чөлөөтэй хөдөлмөр эрхлэх боломжийг хаах.
Debt bondage	Өрийн боолчлол	A form of unfree labour, which involves workers paying off a debt, sometimes for several years, or real or imagined services carried out by a broker.	Чөлөөт бус хөдөлмөр эрхлэлт. Өрөө төлөхийн тулд заримдаа хэдэн жилээр ч хамаагүй өр нэхэгчид бодит эсвэл төсөөллийн үйлчилгээг нь үзүүлж ажиллахыг хэлнэ.
Recruitment fees	Ажилд авах хураамж	Illegal upfront costs charged to jobseekers: one of the tools used to create a situation of forced labour. (Fees charged by agents to hirers are a completely legal part of the recruitment process.)	Ажил хайгчдаас авдаг хууль бус урьдчилгаа зардал: албадан хөдөлмөр эрхлэх нөхцлийг бүрдүүлэхэд ашигладаг арга хэрэгслийн нэг. (Агентууд хөлслөгчөөс авдаг хураамж нь ажилд авах үйл явцын хууль ёсны хэсэг юм.)
Zero-hours contracts	Тэг-цагийн гэрээ	Contract in which an employer is not obliged to provide a minimum number of hours, nor an employee to work them. Described as both 'flexible' and 'exploitative'.	Ажил олгогч нь ажиллах хамгийн бага цагийг тогтоож өгөөгүй, ажилтан ч ажиллах үүрэг заавал хүлээдэггүй төрлийн гэрээ. “Уян хатан”, “мөлжлөгт” хөдөлмөрийн аль алинаар нь тодорхойлогддог төрлийн гэрээ.

The informal sector	Албан бүс салбар	Work that is neither taxed nor monitored: known in some regions as ‘unorganised workers’. It is estimated that 1.3 billion people work informally in the Asia-Pacific region.	Татвар ногдуулдаггүй, хяналт тавьдаггүй ажил: зарим бүс нутагт “албан бүс хөдөлмөр эрхлэгчид” гэж нэрлэгддэг. Ази Номхон далайн бүс нутагт 1.3 тэрбум хүн албан бусаар ажилладаг гэсэн судалгаа бий.
Nativism	Уугуул хүн амыг дээдлэх үзэл	“The policy of protecting the interests of native-born or established inhabitants against those of immigrants.” (Oxford English Dictionary). Can lead to poor treatment of migrant workers.	“Уугуул оршин суугчдын эрх ашгийг цагаачдын эсрэг хамгаалах бодлого” (Оксфордын англи хэлний толь бичиг) Цагаач ажилчдад муугаар хандахад хүргэж болзошгүй.
Decent work	Зохистой ажил	...involves “opportunities for work that is productive and delivers a fair income, security in the workplace and social protection for families, better prospects for personal development and social integration, freedom for people to express their concerns, organise and participate in the decisions that affect their lives and equality of opportunity and treatment for all women and men”, according to the ILO	“Үр бүтээлтэй, шударга орлоготой ажиллах боломж, ажлын байран дахь аюулгүй байдал, гэр бүлийн нийгмийн хамгаалал, хувь хүний хөгжил, нийгэмд интеграцчлах илүү сайхан ирээдүй, хүмүүсийн өөрсдийнх нь амьдралд нөлөөлөх шийдвэр гаргалтыг зохион байгуулах, оролцох, өөрсдийн зовнилоо илэрхийлэх, бүх эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүдэд тэгш боломж, тэгш хандах” гэж ОУХБ тодорхойлсон.
Sustainable development goals	Тогтвортой хөгжлийн зорилгууд	Also ‘Global Goals’, adopted by all United Nations Member States in 2015. There are 17 of them, and they aim to “end poverty, protect the planet” and “ensure that all people enjoy peace and prosperity by 2030”. Goal 8 is to “promote sustained, inclusive and sustainable economic growth, full and productive employment and decent work for all”.	Мөн 2015 онд НҮБ-ын бүх гишүүн орнууд баталсан “Дэлхийн зорилгууд” гэгддэг. Эдгээр 17 нь “ядуурлыг устгаж, эх дэлхийгээ хамгаалах”, “2030 он гэхэд бүх ард түмэн амар амгалан хөгжин цэцэглэх” зорилтыг хангах зорилготой. 8-р зорилго нь “эдийн засгийн тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг дэмжих, бүх хүмүүсийн бүрэн бөгөөд үр бүтээлтэй, зохистой хөдөлмөрийг дэмжих” гэсэн байдаг.

Bonded labour	Барьцаалагдсан хөдөлмөр	A form of forced labour, in which 'debts' are paid off through services. Although global, it is most widespread in South Asian countries. Sometimes, the debt can be passed down the generations and children can be held in debt bondage because of a loan their parents had taken decades ago.	Албадан хөдөлмөрийн нэг хэлбэр нь “өр”-ийг үйлчилгээ үзүүлэх замаар төлөх явдал юм. Энэ нь дэлхий даяар тохиолддог ч Өмнөд Азийн орнуудад хамгийн өргөн тархсан байдаг. Зарим тохиолдолд өр үе дамжин өвлөгдөж, эцэг эх нь олон жилийн өмнө авсан зээлийн улмаас хүүхдүүд нь ч өрийн боолчлолд ордог.
Outsourcing	Аутсорсинг	When a company brings in a third party to carry out work on its behalf: often technical support, IT, or manufacturing is outsourced.	Компани өөрийн нэрийн өмнөөс ажил гүйцэтгүүлэхийн тулд гуравдагч этгээдийг оролцуулахыг хэлдэг. Ихэвчлэн техникийн дэмжлэг, мэдээллийн технологи эсвэл үйлдвэрлэлийг аутсорсинг хийдэг.
Fast fashion	Түргэн загвар	Cheap clothing, from as little as \$5 per item, often aimed at fashion-conscious youngsters, and made by workers in poor conditions. See also, 'disposable fashion'.	Маш хямд үнэтэй хувцас (зарим нь ердөө 5 ам.доллараас эхэлдэг) бөгөөд ихэвчлэн моод сонирхдог залууст чиглэгдсэн байдаг. Эдгээр хувцсыг ихэвчлэн хөдөлмөрийн тааруу нөхцөлд ажилладаг ажилчид үйлдвэрлэдэг. “Нэг удаагийн моод” (disposable fashion) гэх нэр томъёотой холбоотой.
Gender-based violence (GBV)	Жендэрт суурилсан хүчирхийлэл	Gender-based violence includes trafficking, rape, harassment, physical violence and stalking; it is usually directed at women and girls.	Жендэрт суурилсан хүчирхийлэл гэдэг нь хүн худалдаалах, хүчиндэх, дарамтлах, бие махбодийн хүчирхийлэл үйлдэх, мөшгөх зэргийг хэлнэ. Ихэвчлэн эмэгтэйчүүд, охид хохирогч болсон байдаг.

PR (Public Relations)	ПиАр/ Олон нийттэй харилцах	“The professional maintenance of a favourable public image by a company or other organization or a famous person,” according to the Oxford English Dictionary. Traditionally this has involved press releases and events, celebrity endorsements, and lobbying.	Оксфордын англи хэлний толь бичигт “компани эсвэл бусад байгууллага эсвэл нэр алдартай хүн олон нийтийн өмнө тааламжтай дүр төрхийг мэргэжлийн түвшинд бүрдүүлж, хадгалахыг хэлнэ.” гэсэн байна. Уламжлал ёсоор үүнд хэвлэлийн мэдээ, арга хэмжээ, алдартнуудын гарын үсэг зүрх арга хэмжээ, лобби зэрэг орно.
Paid, earned, shared, owned media	Төлбөртэй мэдээ түгээх ХМХ сайн дураар мэдээлэх, хэрэглэгч мөн өөрөө сайн дураар мэдээлэхээр шийдэх Сошиал мэдээлэл түгээх Сурталчилгааны сувгуудаар түгээх	Also shortened to PESO, this phrase is sometimes used by people who plan and commission campaigns. ‘Paid-for’ media is traditional advertising and sponsored advertorial content; ‘earned and shared’ media is user-generated content and social media about a brand; and ‘owned’ media might include a company blog, official YouTube channel, or website fully controlled by an organisation.	Мөн PESO гэж товчилдог тус хэллэгийг кампанит ажлыг төлөвлөж, зохион байгуулдаг хүмүүс ашигладаг. “Төлбөрт” хэвлэл мэдээлэл гэдэг нь уламжлалт сурталчилгаа, ивээн тэтгэсэн сурталчилгааны контент, “сонгогдсон” болон хуваалцсан” хэвлэл мэдээлэл нь хэрэглэгчийн бий болгосон брэндийн талаарх агуулга болон сошиал мэдээлэл, “эзэмшсэн” хэвлэл мэдээллийн хэрэгсэлд компанийн блог, албан ёсны Youtube суваг, эсвэл байгууллагын бүрэн хяналтад байдаг цахим хуудас багтаж болно.
‘Dark’ PR	“Хар” ПиАр	Traditionally, PR focuses on positive messaging, while “dark PR” is negative and aims to damage the reputation of individuals or organizations. Although it has always existed, it has become more sophisticated, using techniques like false content, unauthorized leaks, media briefings, and automated social media attacks against human rights defenders.	Уламжлал ёсоор PR нь эерэг мессежийг хүргэхэд чиглэдэг бол “хар PR” нь сөрөг бөгөөд хувь хүн, байгууллагын нэр хүндийг сэвтүүлэх зорилготой байдаг. Энэ нь үргэлж байсаар ирсэн ч сүүлийн үед хуурамч контент, зөвшөөрөлгүй мэдээлэл цацах, хэвлэлд мэдээлэл дамжуулах, хүний эрхийн хамгаалагчдын эсрэг автоматжуулсан сошиал медиа халдлагууд явуулах зэрэг илүү нарийн, боловсронгуй аргуудыг ашиглах болсон.

'Slow news day'	"Удаашралтай мэдээний өдөр"	Newsroom jargon for a day when there doesn't seem to be much happening in the world. Sometimes a slow news day coincides with a public holiday, or in some countries, a traditional 'silly season', when parliamentarians, celebrities, and newspaper editors alike are taking a holiday and story ideas that might normally get spiked make the front pages. This can be good news for campaigners and communicators, looking to promote their business and human rights stories!	Дэлхий нам жим байгаа мэт санагдах үед ашиглагддаг редакцын хэллэг. Заримдаа удаашралтай мэдээний өдөр бүх нийтийн амралтын өдөртэй давхцах, эсвэл зарим улс оронд парламентын гишүүд, олны танилууд, сонин сэтгүүлийн редакторууд амарч байдаг "тэнэг улирал" байдаг бөгөөд шуугиан тарьж болзошгүй нийтлэлийн санаанууд ихэвчлэн эхний нүүрэнд гардаг. Энэ нь бизнес болон хүний эрхийн түүхүүдээ сурталчлахыг хүссэн кампанит ажил эрхлэгчид ба харилцааны мэргэжилтнүүдэд сайн мэдээ байж болох юм.
To 'spike' a story	Мэдээг болиулах	To reject a story for editorial reasons: best at the earliest stage possible, before you spend time on it. Actual spikes (and paper) are no longer a big feature of most newsrooms.	Редакцын шалтгаанаар мэдээг аль болох эрт үед нь, цаг зарцуулаагүй үед нь болиулах. Энэ нь ихэнх мэдээний өрөөнүүдийн томоохон онцлог байхаа больсон.
Opinion piece	Үзэл бодлын хэсэг	A subjective opinion article, which includes opposite the editorial page in newspapers, as well as guest and regular columns. Opinion should be clearly separate from hard news.	Сонины редакцын хуудсын эсрэг талд, зочин болон байнгын булангуудыг багтаасан субъектив үзэл бодлын нийтлэл. Үзэл бодол нь хатуу мэдээнээс тусдаа байх ёстой.
Features journalism	Сэдэвчилсэн бүтээл туурвидаг сэтгүүл зүй	Longer-form journalism, typically going deeper into a particular story than would be possible in a short bulletin or news item. Often includes detailed background and creative storytelling.	Богино эмхэтгэл эсвэл мэдээний нийтлэлээс илүү урт, тухайн түүх рүү гүн орсон хэлбэрийн сэтгүүл зүй. Ихэнхдээ нарийвчилсан суурь, бүтээлч түүхүүдийг багтаасан байдаг.

Editorial team meetings	Редакцийн багийн хурал	Editorial team meetings are a vital part of the editorial process for all news organisations; the timing and format varies, but typically a morning editorial meeting might involve sharing ideas for newsgathering. Further production meetings might take place throughout the day	Редакцын багийн уулзалт нь бүх мэдээллийн байгууллагын үйл явцын амин чухал хэсэг юм; цаг хугацаа, хэлбэр нь харилцан адилгүй ч мэдээ цуглуулах, санаагаа солилцох талбар болдог. Өдрийн турш нэмэлт уулзалтууд болох магадлалтай.
Editorial values (also news values)	Редакцийн үнэ цэнэ (мөн мэдээний үнэ цэнэ)	What kind of stories should you cover? And how? These questions are guided by your organisation's editorial values. Accuracy, impartiality, and fairness may be relatively common, but others are more specific: some outlets are 'pro freetrade' or represent youth audiences, with news values that reflect this.	Ямар төрлийн түүх бичих вэ? Хэрхэн бичих вэ? Эдгээр асуултыг танай байгууллагын редакцийн үнэлэмж удирддаг. Үнэн зөв байдал, шударга байдал нь харьцангуй нийтлэг байж болох ч бусад нь илүү нарийн байдаг: зарим эх сурвалж чөлөөт худалдааг эсвэл залуу үзэгч сонсогчид руу чиглэсэн үнэ цэнэтэй, түүнийгээ бүтээлдээ тусгахыг чухалчилдаг байж болно.
Package	Тв мэдээ	A pre-recorded video or audio report, which mixes edited interviews and a presenter's scripted voice-over, usually with other elements such as vox pops, footage, and sound effects.	Хянан тохиолдуулсан ярилцлага болон хөтлөгчийн зохиолоор бичсэн дүү хоолойг бусад бүрэлдэхүүнүүд болох хүмүүсийн богино ярилцлага, засаж янзлаагүй дүрс бичлэг болон аудио эффект зэргийг хольж бэлтгэдэг урьдчилж бичсэн дүрст болон аудио тайланг хэлнэ.
tl;dr	Уншихад хэт урт	A 21st century Internet abbreviation for 'too long, didn't read'. Often used to reject over-long reports. Sometimes also used to describe a summary box in advance of a long Internet article.	"Too long, didn't read" буюу уншихад хэтэрхий урт гэсэн үгийн интернэт дэх товчлол. Ихэнхдээ хэт урт тайлангуудаас татгалзахад ашиглагддаг. Заримдаа интернэтийн урт нийтлэлийн өмнөх хураангуй хайрцгийг тайлбарлахад ашигладаг.

‘Bury the lede’	Лид (хадаас)-ийг булшлах	The lede (lead) is the most important part of a story, and it should usually come first. To bury it is to ignore this rule.	Лид/хадаас нь нийтлэлийн хамгийн чухал хэсэг бөгөөд ихэвчлэн хамгийн түрүүнд орох ёстой. Лидийг булшлах нь дүрмийг үл тоомсорлосон явдал юм.
Rainforest Alliance	Халуун орны ойн эвсэл	“The Rainforest Alliance is an international non-profit organization working at the intersection of business, agriculture, and forests to make responsible business the new normal,” according to its website.	“Халуун орны ойн эвсэл” нь хариуцлагатай бизнес эрхлэлтийг шинэ жишиг болгон тогтоохын тулд бизнес, хөдөө аж ахуй болон ойннуудын уулзвар дээр ажиллаж буй олон улсын ашгийн бус байгууллага юм гэж өөрсдийн цахим хуудастаа бичжээ.
Fairtrade	Шударга худалдаа	...has origins in the 1960s ‘Trade not Aid’ movement, and attempts to provide a decent income for producers in poorer countries via table prices paid to the communities (typically those who grow staples like coffee, tea, and cocoa). Fair Trade Certification can get complex (and there are several similar-sounding schemes which are separate from the Fairtrade Foundation) and such schemes are not without critics.	... 1960-аад оны “Тусламж биш Худалдаа” хэмээх хөдөлгөөнөөс гаралтай бөгөөд буурай орны үйлдвэрлэгчдэд (ихэвчлэн цай, кофе, какао гэх мэт гол нэрийн бүтээгдэхүүн үргүүлдэг) зах зээлийн үнээр дамжуулан шударга орлого олох боломжийг олгох зорилготой юм. Шударга худалдааны гэрчилгээ нарийн төвөгтэй болж болох. (Мөн үүнтэй адил сонсогддог ч Шударга Худалдааны сангаас тусдаа өөр бусад схемүүд байдгийг шүүмжилж болохгүй.)
Risk assessment	Эрсдлийн үнэлгээ	The process of recognizing potential hazards before beginning a task.	Ажил эхлэхийн өмнө болзошгүй аюулыг таних үйл явц.
Right to reputation	Нэр төртэй байх эрх	As well as the right to freedom of expression, and to hold opinions, everybody has the right to reputation.	Хүн бүрт үзэл бодлоо илэрхийлэх, өөрийн гэсэн сэтгэгдэлтэй байх эрх байдгийн адил нэр төртэй байх эрх ч байдаг.

Libel	Гүтгэлэг	A false, published statement which damages someone's reputation.	Хэн нэгний нэр төр, алдар хүндэд халдсан мэдэгдэл.
Cyberattack	Кибер халдлага	Malicious digital assault. Carried out by individuals, hacker groups, and even businesses. There has been a recent rise nation-state attacks.	Хор, хорлонтой дижитал дайралт. Хувь хүмүүс, бүлэг хакерууд төдийгүй бизнесүүд хүртэл хийдэг зүйл. Сүүлийн үед улс үндэстний халдлага ихсэж байна.
Zero-click attack	0 товшилтын халдлага	A kind of cyberattack that doesn't involve the target clicking on anything: phones are often targeted this way with spyware.	Зорилтот хүн юун дээр ч дарах шаардлагагүйгээр үйлдэгддэг төрлийн кибер халдлага. Ихэвчлэн гар утаснуудыг ийм маягаар тагнуулын программаар онилдог.
Spyware	Хортой программ	Malicious software (AKA malware) that accesses personal data, and tracks user behaviour.	Хувийн мэдээлэлд нэвтэрч, хэрэглэгчийн зан үйлийг хянадаг хортой программ хангамж (AKA хортой програм).
Doxing	Хувийн мэдээллийг задруулах	Sharing personal information (documents = dox) in order to reveal the identity of an Internet user.	Интернэт хэрэглэгчийн хэн болохыг илчлэхийн тулд хувийн мэдээллийг нь ил болгох (баримт бичиг = dox).
Burner phone	Шарагч утас	Cheap mobile phone, using prepaid minutes. As well as being secure, if you lose a cheap Nokia on an assignment, you've lost a \$30 phone, not a \$1,000 smartphone with all your contacts on it.	Урьдчилсан төлбөрт, хямд гар утас. Аюулгүйн зэрэгцээ та даалгавар гүйцэтгэж байхдаа хямдхан 30 ам. долларын Nokia алга болговол бүх хүмүүсийн дугаартай 1000 ам.долларын ухаалаг утсаа гээсэнтэй ижил гарзтай биш.
Source protection	Эх сурвалжаа хамгаалах	AKA source confidentiality and reporter's privilege, this means protecting the identity of your sources: journalists have gone to prison for refusing to reveal their sources.	Мөн эх сурвалжийн нууцлал, сурвалжлагчийн эрх гэж нэрлэгддэг. Энэ нь таны эх сурвалжийн хувийн мэдээллийг хамгаалах гэсэн үг юм: сэтгүүлчид эх сурвалжаа задруулахаас татгалзсаны улмаас шоронд ордог байсан.

Jigsaw identification	Хэн болохыг мэдэгдүүлэхгүй	“We should be careful not to reveal several pieces of information in words or images that, when pieced together, could lead to revealing the identity of the individual,” according to the BBC’s Editorial Guidelines. In other words, if you say “a pregnant 23-year-old mother of two, who has been working at a Tân Bình garment factory since July last year”, it would be fairly easy to piece together the information to confirm the identity of the worker. Better to say “a worker in Hồ Chí Minh City”.	Би-Би-Си-ийн Редакцын удирдамжийн дагуу “Бид нэгтгэсэн тохиолдолд тухайн хүний хувийн шинж чанарыг илчлэхэд хүргэж болзошгүй хэд хэдэн мэдээллийг үг, дүрс хэлбэрээр ил гаргахаас болгоомжлох хэрэгтэй.” Өөрөөр хэлбэл, хэрэв та “Тан Бин” оёдлын үйлдвэрт өнгөрсөн оны долдугаар сараас хойш ажиллаж байгаа 23 настай жирэмсэн, хоёр хүүхдийн ээж” гэвэл тухайн ажилтны хэн болохыг батлахад хялбар байх болно. “Хо Ши Мин хотод ажилладаг нэгэн” гэж хэлэх нь дээр.
Charismatic megafauna	Сэтгэл татам амьтад	Large and popular animals with a symbolic value to environmental campaigners: polar bears, pandas, rhinos, and lions capture the public’s imagination, and seem to draw attention to habitat loss more than worms, fungi, or insects. Orangutan and palm oil are linked in many environmental campaigns, for example.	Байгаль орчныг сурталчлагчдын хувьд бэлгэдлийн ач холбогдолтой том, алдартай амьтад болох цагаан баавгай, хулсны баавгай, хирс, арслан зэрэг нь олон нийтийн санаа бодлыг өт, мөөгөнцөр, шавьжнаас илүүтэйгээр амьтдын амьдрах орчин сүйдэж байгаа гэдэг сэдэв рүү хүмүүсийн анхаарлыг татдаг бололтой. Жишээлбэл, орангутан болон далдуу модны тос нь байгаль орчныг хамгаалах олон кампанит ажилд холбоотой байдаг.
Soft news	Зөөлөн мэдээ	Human interest stories, which blur the line between information and entertainment. Often described in contrast to ‘hard news’, which is seen as more serious developments. The distinction has become less relevant, as pop culture increasingly appears in ‘respectable’ news outlets.	Мэдээлэл, зугаа цэнгэлийн хоорондох заагийг бүдгэрүүлдэг, хүмүүсийн сонирхлыг татдаг түүхүүд илүү ноцтой сэдвүүдийг хамардаг “хатуу мэдээ”-тэй зөрчилддөг. Голлогч сувгуудаар поп соёлын тухай мэдээ мэдээл улам бүр зонхилж байгаа нь ач холбогдлыг бүр илүү бууруулж байна.

24/7 news cycle	24/7 мэдээний мөчлөг	Sometimes called the 'rolling' news cycle. Its origins are in TV, but these days it's more likely to be mobile: some users might check their phone for updates every few minutes as they consume social media updates.	Заримдаа мэдээний “эргэх” мөчлөг гэж нэрлэгддэг. Үүсэл нь ТВ-ээс гаралтай ч одоо илүү гар утас руу шилжээд байна. Сошиал мэдээллийн шинэчлэлтэй танилцахын тулд хэрэглэгчид утсаа хэдэн минут тутамд шалгадаг.
Twitter-storm	Твиттерийн шуурга	A surge in Twitter activity around a particular #subject. This can equally indicate a genuine emerging story, or a false rumour	Жиргээнүүд тодорхой #сэдвийн эргэн тойронд хөврөхийг хэлнэ. Энэ жинхэнээсээ гарч ирж буй мэдээлэл эсвэл худал цуу яриа ч байж болно.
The Wires, news agencies	Мэдээ дамжуулагчид, мэдээллийн агентлагууд	AKA 'newswires': the term originates from the Victorian era of telegraph wires, when agencies like Reuters and Associated Press would transmit 'objective' information to newspaper offices around the world. They still exist, albeit digitally, and are usually considered trustworthy sources of news. However, beware 'fake' wires services, sometimes tools of government propaganda.	“Мэдээ дамжуулагч” гэж бас нэрлэгддэг энэхүү нэр томъёо нь Reuters, Associated Press зэрэг агентлагууд дэлхийн өнцөг булан бүрт байгаа сонины редакцуудад “объектив” мэдээллийг цахилгаан холбоогоор дамжуулдаг байсан Викториаы телеграфын эрин үеэс гаралтай. Тэд тоон хэлбэрээр оршсоор байгаа бөгөөд ихэвчлэн мэдээллийн найдвартай эх сурвалж гэж тооцогддог. Гэсэн хэдий ч заримдаа засгийн газрын суртал ухуулгын хэрэгсэл болдог ч “хуурамч” дамжуулагчийн үйлчилгээнээс болгоомжлох хэрэгтэй.
Primary source	Анхдагч эх сурвалж	An original object, document, diary, recording, or any other source of information. Your own original interview is a primary source, a quote grabbed from elsewhere else, isn't.	Анхдагч эд зүйл, баримт бичиг, өдрийн тэмдэглэл, дуу бичлэг болон бусад бүх төрлийн мэдээллийн эх сурвалж. Таны өөрийн ярилцлага бол анхдагч эх сурвалж мөн, харин хаа нэгтээгээс эш татсан өгүүлбэр бол биш.
Verification	Баталгаажуулалт	The process of finding out whether something is true; arguably the most important task for all journalists.	Аливаа зүйл үнэн эсэхийг олж мэдэх үйл явц; бүх сэтгүүлчдийн хамгийн чухал ажил гэж хэлж болно.

'Paper trail'	"Бичгийн үл мөр"	Useful in the verification process. If you have documentary evidence, it is easier to prove your story is accurate. As well as receipts, certificates, and other documents, emails are seen as written evidence that can be used in court proceedings.	Баталгаажуулах үйл явцад хэрэгтэй. Хэрэв танд баримтат нотлох баримт байгаа бол таны нийтлэлийг үнэн зөв гэдгийг батлах нь илүү хялбар болно. Баримт, гэрчилгээ болон бусад баримт бичгүүдээс гадна цахим шууданг шүүх хуралдаанд ашиглаж болох бичгийн нотлох баримт гэж үздэг.
Deepfakes	Эвлүүлгийн мэхлэлт	Manipulated audio, image, and video content refers to media where the original material has been altered or edited to deceive or mislead. An example would be videos in which public figures are made to appear as if they are saying things they never actually said.	Манипуляц хийсэн дуу бичлэг, зураг, видео контент гэдэг нь эх материалыг өөрчлөх, төөрөгдүүлэх зорилгоор өөрчилсөн, засварласан мэдээллийг хэлнэ. Жишээ нь: олон нийтийн зүтгэлтнүүд хэзээ ч хэлж байгаагүй зүйлээ хэлж байгаа мэт харагдуулдаг видео бичлэгүүд байж болно.
Reverse image tools	Зургийн эх сурвалж тодруулах талбарууд	Online image search software, which makes it easier for users to find the original source of an image or video.	Хэрэглэгчдэд зураг эсвэл видеоны эх сурвалжийг олоход хялбар болгодог онлайн зураг хайх програм хангамж.
Freedom of information acts	Мэдээллийн эрх чөлөөны акт	Laws to grant public access to certain data held by national governments. More than 100 countries have 'FOI' laws, including Thailand, Indonesia, and Bangladesh. Investigative journalists should understand and use these.	Улс орнуудын засгийн газрын эзэмшиж буй тодорхой мэдээлэлд олон нийтэд хандах эрх олгох хуулиуд. Тайланд, Индонези, Бангладеш зэрэг дэлхийн 100 гаруй улс "FOI" хуультай. Эрэн сурвалжлах сэтгүүлчид эдгээрийг ойлгож, ашиглах ёстой.
Peer-reviewed science	Хөндлөнгийн хяналттай шинжлэх ухаан	Research which has been published in a journal and reviewed by scientists working in a similar field (peers). Whilst no science claims to be definitive, the process filters out 'junk science'	Сэтгүүлд хэвлэгдэн ижил төстэй чиглэлээр ажилладаг эрдэмтдээр (чиглэл нэгт) хянагдсан судалгаа. Ямар ч шинжлэх ухаан тодорхой гэж зарладаггүй ч энэ үйл явц нь "хог шинжлэх ухаан"-ыг шүүдэг.

Misinformation, disinformation, and malinformation	Буруу мэдээлэл, хуурамч мэдээлэл, ташаа мэдээлэл	Rather than the potentially vague term ‘fake news’, many data journalists tend to distinguish between misinformation (false, but shared ‘innocently’), disinformation (false and deliberately created to cause someone harm) and malinformation (based on reality, but taken out of context).	“Хуурамч мэдээ” гэсэн тодорхой бус нэр томъёо ашиглахаас илүүтэй буруу мэдээлэл (худал, гэхдээ “гэмгүй” хуваалцсан), хуурамч мэдээлэл (хуурамч, хэн нэгэнд хор хөнөөл учруулах зорилгоор санаатайгаар бий болгосон) болон ташаа мэдээлэл (бодит байдалд тулгуурласан боловч контекстээс хасагдсан) гурвыг олон дата сэтгүүлчид ялгах хандлагатай байдаг.
Further Resources	Нэмэлт нөөц	Fact-checking sites like Snopes, Full Fact, AFP Fact Check (English) can be a good first filter. And there are plenty of online verification tools for images and video, like TinEye and Google Images. Open source intelligence (Osint) tools for journalists are changing all the time: the Columbia Journalism Review has a useful guide to many of these.	Snopes, Full Fact, AFP Fact Check (англи хэл дээрх) гэх мэт баримт шалгах сайтууд нь эхний сайн шүүлтүүр байж болно. Мөн TinEye, Google Images зэрэг зураг, видеог шалгах олон онлайн хэрэгсэл байдаг. Сэтгүүлчдэд зориулсан нээлттэй эх сурвалжийн тагнуулын (Osint) хэрэгслүүд байнга өөрчлөгдөж байдаг: Колумбын сэтгүүлзүйн тойм нь эдгээрийн ихэнхийг ашиглах хэрэгтэй гарын авлагатай.
‘Trauma-informed reporting’	“Сэтгэл зүйн гэмтэлд мэдрэмжтэй хандаж мэдээлэх нь”	The phrase ‘trauma-informed’ comes from healthcare services, where an awareness that retraumatization is a real risk during sensitive interviews. The idea that ethical journalists should feel a duty of care to those they interact with, and adopt a ‘do-no-harm’ approach to treating interviewees, is hopefully gaining momentum.	“Сэтгэл зүйн гэмтэлд мэдрэмжтэй хандлага” (trauma-informed) гэх ойлголт нь эрүүл мэндийн үйлчилгээний салбараас үүсэлтэй бөгөөд мэдрэмтгий сэдвээр ярилцлага хийх үед дахин гэмтээх эрсдэл бодитоор оршдог гэдгийг ухамсарласантай холбоотой. Ёс зүйтэй сэтгүүлчид харилцаж буй хүмүүсээ анхаарч, “хор хөнөөл учруулахгүй байх” зарчмыг баримтлах ёстой гэсэн ойлголт аажмаар хүлээн зөвшөөрөгдөж, дэлгэрч эхэлж байна.

Duty of care	Анхаарч халамжлах үүрэг	The responsibility to do no to harm to the people you interact with: for reporters, this could be the people you interview, or who help you with a story in any way. More recently this discussion has included audiences: for example warning of graphic images of casualties. Note that there are slightly different legal meanings of this phrase in health and social care settings.	Харилцаж буй хүмүүстээ хор хөнөөл учруулахгүй байх үүрэг: сэтгүүлчдийн хувьд энэ нь танд ярилцлага өгөх, эсвэл танд ямар нэгэн байдлаар туслах хүмүүс байж болно. Сүүлийн үед энэ хэлэлцүүлэгт үзэгчдийг хамруулсан: жишээ нь хохирогчдын график дүрсийг анхааруулах. Эрүүл мэнд, нийгмийн халамжийн орчинд энэ хэллэгийн хууль эрх зүйн утга нь арай өөр байдгийг анхаарна уу.
Informed consent	Бүрэн мэдээлэл авсны үндсэн дээр зөвшөөрөх	When the person giving consent fully understands the consequences of a decision and consents freely and without any force: in the context of journalism, this might be explaining fully the repercussions of going 'on-the-record'	Тухайн хүн шийдвэрийнхээ үр дагаврыг ухамсарлаж, ямар нэг дарамтад авталгүйгээр, чөлөөтэйгөөр зөвшөөрөл өгөхийг хэлнэ. Сэтгүүлзүйн үүднээс авч үзвэл энэ нь “бичлэгт орох” үр дагаврыг бүрэн тайлбарлаж болох юм.
Greenwashing	Ногоон тархи угаалт	“Disinformation disseminated by an organisation so as to present an environmentally responsible public image,” according to the Oxford English Dictionary. (It’s a play on the term ‘whitewashing’, which means to paint over, and which has long been a metaphor for covering something up.) See also ‘sportswashing’.	Оксфордын англи хэлний толь бичигт “Байгаль орчинд ээлтэй олон нийтийн дүр төрхийг харуулахын тулд байгууллагаас тараасан ташаа мэдээлэл” гэж бичжээ. (Энэ бол будах гэсэн утгатай “цагаан тархиугаах” гэсэн нэр томъёоны жүжиг бөгөөд аль эрт ямар нэг зүйлийг халхлах зүйрлэл байсаар ирсэн.) Мөн “спорт тархи угаалт” хэсгийг үзнэ үү.
Circular economy	Тойрог эдийн засаг	The idea that we can eliminate waste and restore the Earth’s resources by ‘re-using, and recycling’ resources, not ‘taking, making, and disposing’ as we do now.	Бид одоогийнх шиг нөөц баялгийг “авах, үйлдвэрлэх, устгах” бус “дахин ашиглах, дахин боловсруулах” замаар хог хаягдлыг арилгаж, дэлхийн баялгийг сэргээж чадна гэсэн санаа.

'Waste pickers'	"Хог түүгчид"	Informal waste collection workers. It is estimated there are between 1.5 and 4 million in India alone; many are children and enjoy limited human rights.	Албан бус хог цуглуулагч ажилчид. Зөвхөн Энэтхэгт 1.5-4 сая хүн байдаг гэсэн тооцоо бий; олонхи нь хүүхэд бөгөөд хүний эрхийг хязгаарлагдмал эдэлдэг.
Spin	Мушгих	A form of propaganda: typically involves word-play to influence opinion. Politicians, businesses, and military use spin to cover up bad news, sorry, I mean, "mitigate limited positivity impact potential in key audiences via targeted verbal messaging".	Суртал ухуулгын нэг хэлбэр: үзэл бодолд нөлөөлөхийн тулд ихэвчлэн үг хэллэгээр тоглодог. Улс төрчид, бизнес эрхлэгчид, цэргийнхэн мүү мэдээг нуун дарагдуулахын тулд эргүүлгийг ашигладаг, уучлаарай, би "зорилтот аман мессежээр дамжуулан гол үзэгчдэд хязгаарлагдмал эерэг нөлөөллийг бууруулах" гэсэн үг гэх гэсэн юм.
Right to reply	Хариу тайлбар, мэдээлэл өгөх эрх	It is ethical and fair to give a right to reply. Sometimes those involved in a story won't provide a comment in order to kill a story.	Хариулах эрх өгөх нь ёс зүйтэй бөгөөд шударга юм. Заримдаа мэдээлэлд оролцсон хүмүүс мэдээллийг замхруулахын тулд тайлбар өгөхгүй байх тохиолдол байдаг.
Corrections policy	Залруулгын бодлого	Obviously you should aim for accuracy. But it is inevitable that at some point mistakes will be made. In general you should correct quickly, particularly minor points. But you should always take legal advice on big issues: for example, by issuing a correction you could potentially be admitting to a libel. Some prominent businesses and businesspeople use the libel law to silence media reporting of their actions.	Мэдээжийн хэрэг та нягт нарийн байдлыг эрэлхийлэх хэрэгтэй. Гэхдээ хэзээ нэгэн цагт алдаа гарах нь гарцаагүй. Ерөнхийдөө та хурдан засах хэрэгтэй, ялангуяа жижиг алдаануудыг. Гэхдээ та томоохон асуудлаар үргэлж хуулийн зөвлөгөө авах хэрэгтэй: жишээлбэл, залруулга хийснээр та гүтгэлгийг хүлээн зөвшөөрч болзошгүй. Зарим нэр хүндтэй бизнесүүд болон бизнес эрхлэгчид өөрсдийн үйлдлүүдийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээллүүлэхгүйн тулд гүтгэлгийн хуулийг ашигладаг.

'False balance' AKA 'bothside-sism'	“Хуурамч тэнцвэр” буюу “Хоёр талыг баримтлах”	The misleading presentation of a false theory (e.g. “the Earth is flat”) to ‘balance’ a fact (“the Earth is roughly spherical”).	Баримтыг “тэнцвэржүүлэх” худал онолын (жишээлбэл, “Дэлхий хавтгай” гэх мэт) төөрөгдүүлсэн танилцуулга (“Дэлхий бараг бөмбөрцөг хэлбэртэй”).
'Tobacco industry playbook'	“Тамхины үйлдвэрлэлийн тоглоомын ном”	A set of techniques used by PR teams to discredit the link between smoking and lung cancer. The idea was not to refute scientific studies, but to confuse and disorientate consumers. ‘Big Tobacco’ also funded several scientific studies in other areas, ensuring that for decades after the link was discovered, there were no successful legal actions against tobacco companies.	Тамхи татах болон уушгины хорт хавдар хоёрын хоорондын холбоог үгүйсгэхийн тулд PR-ийн багуудын ашигладаг цогц арга техник. Энэхүү санаа нь шинжлэх ухааны судалгааг үгүйсгэх биш, харин хэрэглэгчдийг төөрөгдүүлж, чиг баримжааг нь алдагдуулахад оршдог. “Big Tobacco” компани нь бусад чиглэлээр шинжлэх ухааны хэд хэдэн судалгааг санхүүжүүлсэн бөгөөд энэ холбоосыг илрүүлснээс хойш хэдэн арван жилийн турш тамхины компаниудын эсрэг амжилттай хууль эрх зүйн ажиллагаа явуулаагүй гэдгийг баталгаажуулсан.
Automated journalism	Автоматжуулсан сэтгүүлзүй	Sometimes known as algorithmic or ‘robot’ journalism, this involves using artificial intelligence and machine learning in order to trawl data, and produce simple ‘articles’. The idea is that AI performs basic, repetitive tasks, allowing journalists to focus on more creative endeavours, rather than replace humans.	Заримдаа алгоритмын эсвэл “робот” сэтгүүл зүй гэж нэрлэдэг бөгөөд энэ нь өгөгдлийг хянах, энгийн “нийтлэл” гаргахын тулд хиймэл оюун ухаан, машин сургалтыг ашигладаг. Энэхүү санаа нь хиймэл оюун ухаан нь үндсэн, дахин давтагдах даалгавруудыг гүйцэтгэдэг бөгөөд хүнийг орлохоос илүү сэтгүүлчдэд бүтээлч хүчин чармайлт гаргах боломжийг олгодог.

Big data journalism	Их өгөгдлийн сэтгүүлзүй	This involves examining masses of digital information and presenting it in a way that is meaningful to audiences. Because of the sheer volume of data, these stories can involve several journalists: WikiLeaks, the controversial international non-profit organisation, claims to have released 10 million documents which came from international sources.	Энэ нь олон тооны дижитал мэдээллийг судалж иргэдэд утга учиртай байдлаар мэдээлэх явдал юм. Мэдээллийн хэмжээ маш их тул эдгээр мэдээллүүд хэд хэдэн сэтгүүлчийг хамарч болно: маргаантай олон улсын ашгийн бус байгууллага болох WikiLeaks олон улсын эх сурвалжаас ирсэн 10 сая баримт бичгийг нийтэлсэн гэж мэдэгджээ.
		To crunch that data and turn it into meaningful stories, journalists from media outlets across the world have frequently collaborated.	Эдгээр өгөгдлийг задлан, утга учиртай түүх болгон хувиргахын тулд дэлхийн өнцөг булан бүрээс хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн сэтгүүлчид байнга хамтран ажилладаг.
Advertorial	Редакцийн сурталчилгаа	A combination of 'advertisement' and 'editorial'. Advertising features in newspapers, for example. Should be clearly marked as paid-for content.	“Зар сурталчилгаа” ба “редакцийн” хэмээх үгсийн хослол. Жишээлбэл, сонины сурталчилгааны нийтлэлүүдийг төлбөртэй контент гэж тодорхой тэмдэглэсэн байх ёстой.
Media elite (and elite media)	Хэвлэл мэдээллийн элит (ба элит хэвлэл мэдээлэл)	The elite media is newspapers, radio stations, TV channels, and other media that influence the political agenda of other mass media. According to Noam Chomsky, “The elite media set a framework within which others operate.” Conservatives and populists have used the term ‘media elite’ in a negative way, to describe the idea that media agendas are out of touch with ordinary people.	Элит хэвлэл мэдээллийн хэрэгсэл бол бусад хэвлэл мэдээллийн хэрэгслийн улс төрийн хөтөлбөрт нөлөөлдөг сонин, радио станц, телевиз ба бусад мэдээллийн хэрэгсэл юм. Ноам Чомскийн хэлснээр “Элитийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд бусдын үйл ажиллагаа явуулах тогтолцоог бий болгодог.” Консерватив үзэлтнүүд болон популистууд “хэвлэл мэдээллийн элит” гэсэн нэр томъёог сөрөг утгаар ашиглаж, хэвлэл мэдээллийн хөтөлбөрүүд жирийн хүмүүстэй харьцдаггүй гэсэн санаагаар тайлбарладаг.

Contacts book	Холбоо барих жагсаалт	Expression for the network of people whose contact details you have (even if they are stored digitally).	Танд холбоо барих мэдээлэл нь байгаа хүмүүсийн сүлжээний илэрхийлэл (тэдгээрийг тоон хэлбэрээр хадгалсан ч гэсэн тооцогдоно).
'Good talkers'	"Сайн яригчид"	Guests who are happy to be interviewed, including those who can explain complex topics well, and speak confidently. Useful for your contacts book.	Нарийн төвөгтэй сэдвүүдийг сайн тайлбарлаж чаддаг, итгэлтэйгээр ярьдаг ярилцлага өгөх сонирхолтой зочид.
Workplace discrimination	Ажлын байран дахь ялгаварлан гадуурхалт	"Treating people differently or less favourably because of characteristics that are not related to their merit or the inherent requirements of the job."	"Хүмүүст тэдний чадвар эсвэл ажлын шаардлагаас үл хамааран ялгаварлаж, таагүй харьцах."
LGBTQI	ЛГБТИ	Lesbian, gay, bisexual, trans and intersex: LGBTQI communities often suffer workplace discrimination. Business action to respect and support LGBTQI rights is an example of the Guiding Principles on Business and Human Rights and the UN Global Compact human rights principles in practice.	Лесби, гей, бисексуал, транс болон интерсекс: ЛГБКИ хүмүүс ажлын байран дахь ялгаварлан гадуурхалтад байнга өртдөг. ЛГБКИ эрхийг хүндэтгэх, дэмжих бизнесийн үйл ажиллагаа нь Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмууд, НҮБ-ын Даян дэлхийн гэрээн дэх хүний эрхийн зарчмуудын жишээ юм.

Хавсралт 3.

БИЗНЕС ДЭХ ХҮНИЙ ЭРХИЙН ХҮРЭЭНД НИЙТЛЭГДСЭН ЭРЭН СУРВАЛЖЛАХ СЭТГҮҮЛ ЗҮЙН БҮТЭЭЛИЙН ЖИШЭЭ



- 2014 оны 11-р сарын 22-ны Бямба гарагт авсан зурагт Индонезийн Бенжина дахь загас агнуурын талбайд Тайланд болон Бирмийн ажилчид торны цаана сууцгааж байна. Тэднийг зугтах магадлалтай боолууд хэмээн үзэж хорьжээ. Тэдний хэлснээр, өдөрт цөөн халбага карригтай будаа идэж, хэвтэхэд багтахааргүй жижигхэн зайд унтаж, загас агнуурын дараагийн хөлөгт хүчээр суулгаж далайд гаргах хүртэл ийнхүү түгжигдэн амьдарч байна. (AP Photo/Dita Alangkara)

Та боолуудын зовлонгоор хооллож байна

Орох хаалга байгаа ч, ГАРАХ ХААЛГА БАЙХГҮЙ

БЕНЖИНА, Индонез — Хэдэн мянган километрийн алсад халуун орны нэгэн жижиг арал дээр зэвэнд идэгдсэн төмөр сараалжин торны цаанаас шалаар нэг эгнэсэн бирм боолууд гэрийнхээ зүг гөлрөнө.

Хэдхэн алхмын цаана эдгээр боолын далайгаас барьсан хүнсийг бусад ажилтнууд хөлөг онгоцнуудад ачиж байв. Энэ бол АНУ-ын томоохон сүлжээ супермаркетууд, ресторанууд, тэр бүү хэл амьтны дэлгүүрүүдэд хүргэгдэн очдог хүнсний сүлжээний саарал хэсэг юм.

Торны цаана байгаа найман эрэгтэйг зугтаах эрсдэлтэй гээд хорьсон байв. Зугтааж мэдэх зориг зүрхтэй ажилчид. Тэд өдөрт хэдхэн халбага карригтай будаа идэж, хэвтэж багтахааргүй зайд хоригдож, дараагийн загас агнуурын онгоц ирж, далайд хүчээр гаргах хүртэл хоригдоно.

“Би тэсэхээ больж байна, нутаг буцмаар байна” гэж ахмаддаа хэлсний төлөө тэр намайг дараагийн зогсоолд хүрмэгц хорьсон” хэмээн хэлэхдээ Кяу Наинг хэмээх бирм эр AP агентлагийн нууцаар байрлуулсан камер руу харан уйлав.



Индонезийн Бенжина арал дээр 2014 оны 11-р сарын 27-нд камерын бичлэгээс авсан энэ зургаас харахад Кяу Наинг гурван жил Тайландын загас агнуурын хөлөг дээр боол мэт ажиллаж, үе үе хүнд зодуулдаг байв. Хөлгийн ахмадад «гэртээ харимаар байна» гэж хэлэхэд нь шууд хорьсон ажээ.

Энд, Индонезийн Бенжина арлын тосгон ба ойр орчмын усанд хоригдсон олон зуун хүн бол далайн хүнсний салбарт үйл ажиллагаа явуулдаг компаниуд ба улс орнуудын хооронд хэрэгдсэн нарийн сүлжээний нэг хэсэг юм. Энэхүү нийлүүлэлтийн сүлжээ нь бидний идэж буй загасыг хэн барьдаг вэ гэдгийг далдлан, аймшигт үнэнийг нуудаг: Таны идэж буй далайн хүнсийг боолууд барьсан байж болзошгүй.

Бенжина дахь боолуудын ихэнх нь дэлхийн хамгийн ядуу орнуудын тоонд ордог Мьянмар буюу Бирмээс ирсэн байв. Тэднийг Тайландаар дамжуулан Индонезид авчирч хүчээр загасчлуулдаг бөгөөд барьсан загасыг нь Тайланд руу тээвэрлэн, олон улсын зах зээлд нийлүүлдэг байна.

Бохир мөлжлөгөөр агнасан загаснууд АНУ-ын зарим томоохон хүнсний сүлжээ дэлгүүрүүдийн нэг болох Kroger, Albertsons, Safeway, мөн жижиглэн худалдааны хамгийн том сүлжээ дэлгүүр болох Wal-Mart болон хүнс түгээлтийн томоохон компани болох Sysco-ийн **нийлүүлэлтийн сүлжээнд нэвтэрдэг байна.**

Ийм хүнс Fancy Feast, Meow Mix, Iams зэрэг алдартай брэндүүдийн тэжээвэр амьтанд зориулсан лаазалсан бүтээгдэхүүнд ч орсон байх магадлалтай. Мөн тансаг ресторанд каламари нэрээр, эсвэл Калифорния сүши-д хиймэл хавчны мах нэрээр, цаашлаад дэлгүүрийн шошго наасан хөлдөөсөн далайн бүтээгдэхүүн хэлбэрээр ч бидний хоолны ширээн дээр ирдэг ч байж мэднэ.

Associated Press (AP) агентлагийн сэтгүүлчид нэг жилийн турш хийсэн эрэн сурвалжлагынхаа үеэр Бенжинад (Индонез) боолын хөдөлмөр эрхэлж байсан одоо ч эрхэлж буй 40 гаруй хүнтэй ярилцаж, нэгэн томоохон хэмжээний боолын сүлжээ бүхий далайн бүтээгдэхүүний нийлүүлтийг ачилтаас нь эхлэн замын турш баримтжуулжээ. Хиймэл дагуулын тусламжтайгаар Индонезийн тосгоноос ачин Тайландын боомт руу хөдөлж байхад нь мөрдөн тогтоожээ. Боомтод хүрмэгц AP-ийн сэтгүүлчид 4 шөнө дараалан уг ачилтыг

үйлдвэр, хүйтэн агуулах, загасны томоохон захууд руу тараан тээвэрлэж буйг дагаж, баримтжуулсан байна.

Боолын хөдөлмөрөөр энд ирсэн далайн бүтээгдэхүүн Тайландын хэд хэдэн газар (боловсруулах үйлдвэрүүд зэрэгт) бусад далайн бүтээгдэхүүнтэй нийлээд цааш олон тийшээ тардаг аж. АНУ-ын Гаалийн бүртгэлээс үзэхэд уг үйлдвэрүүдийн зарим нь АНУ руу экспорт хийдэг. Түүнчлэн Европ, Азийн зах зээлд ч нийлүүлдэг. Гэхдээ худалдааны нийлүүлэлтийн түүх нь олон нийтэд нээлттэй байдаг тул АР тусгайлан АНУ руу чиглэсэн нийлүүлэлтийг мөшгөсөн билээ.

Энэ явцад ямар загас боолын хөдөлмөрөөр баригдсан бэ гэдгийг ялгаж таних бараг л боломжгүй болсон байв. Гэсэн ч бүхэл бүтэн нийлүүлэлтийн сүлжээг ийнхүү харлуулж, боолын хөдөлмөр эрхэлсэн компаниудад ашиг орлого нь очсоор байна.

Эрэн сурвалжлагын явцад холбогдох томоохон корпорациуд албан ёсоор байр сууриа илэрхийлэхээс татгалзсан хэдий ч, хөдөлмөрийн мөлжлөгийг эрс эсэргүүцэж буй мэдэгдэл гаргасан. Тэд бүгд албадан хөдөлмөрөөс сэргийлэх арга хэмжээ авч байгаа, тухайлбал хүний эрхийн байгууллагуудтай хамтран гэрээт ханган нийлүүлэгчдийн хяналтаа сайжруулснаа мэдэгджээ.

Далайн хүнсний түгээлтийг бие даан эрхэлдэг хэд хэдэн компаниуд сэтгэгдлээ хуваалцахдаа өөрсдийн нийлүүлэлтийн сүлжээг цэвэр байлгахын тулд асар их зардал, хүч хөдөлмөр гарган ажиллаж байгаагаа тайлбарласан. Тэдний мэдэгдсэнээр боолын хөдөлмөр илэрсэн нь дэлхийн нөгөө захад юу болж байгааг хянах хэцүү гэдгийг харуулж байгаа аж.

Ресторан, зах, мөн өөрийн дэлгүүрээс шууд борлуулалт хийдэг Santa Monica Seafood гэх томоохон бие даасан импортлогч компани гэхэд олон улсын загасны аж ахуйн салбарыг сайжруулах чиглэлээр манлайлан ажиллаж, худалдан авагчдаа дэлхийн өнцөг булан бүрд илгээж ханган нийлүүлэгчдийг шалгадаг байна.

“Ялангуяа гаднын улсаас ирж буй бүтээгдэхүүний хувьд нийлүүлэлтийн сүлжээ маш бүрхэг байдаг,” гэж тогтвортой худалдан авалтын асуудал хариуцсан дэд ерөнхийлөгч Логан Кок дурдсан бөгөөд салбарынхан энэ асуудлыг хүлээн зөвшөөрч, шийдвэрлэхийн төлөө ажиллаж буйг ч онцолсон. “Энэ бүхнээс бага зэрэг нь сүлжээгээр шургаж орж ирэх боломжтой юу? Тийм, боломжтой. Бид бүгд энэ тухай мэдэж байгаа.” гэв

АР-тэй ярилцсан боолуудын хувьд барьсан загас нь хаашаа хүрч байгааг огт мэддэггүй аж. Тэд зөвхөн загас маш үнэ цэнтэй учраас идэх эрхгүйгээ л мэддэг байв.

Тэдний ярьснаар, завины ахмад тэднийг бохир ус ууж, 20–22 цаг тасралтгүй ажиллахыг шаардаж, амралтын өдөр ч өгдөггүй байжээ. Гомдол гаргах эсвэл амрахыг оролдсон тохиолдолд өшиглөж, хортой заарт загасны сүүлээр ороолгож, дарамталдаг байсан тухай ярих. Тэд наймаалж, хулд, сам хорхой, снэппер загас, группер зэрэг далайн амьтдыг хүнд тор шидэн гаргаж байсныхаа төлөө багахан эсвэл огт цалин авдаггүй байсан байна.

Тэд боомт дээр зогсож байгаа завин дээрээсээ сэтгүүлчдээс тусламж гуйн хашхирч тэмүүлэхэд, харанхуйд туссан бүдэгхэн гэрлийн дор царай нь үл ялиг тодрон харагдаж байсан юм.

“Бид бүгд гэртээ харимаар байна,” хэмээн нэг эрэгтэй бирмээр хашхирахад бусад нь түүнийг даган давтан хашхирцаав. “Манай аав ээж биднээс сураг сонсоогүй удсан. Лав биднийг үхсэн гэж бодож байгаа”. АР зарим хүмүүсийн нэрийг аюулгүй байдлын үүднээс нууцалсан болно.

Нэг эрэгтэй ахмадын өрөө рүү айдастайгаар ойр ойрхон хялам хийн харах зууртаа хаширав: “Энэ бол тамлал. Бид зодуулж байхдаа юу ч хийж чаддаггүй. ... Бидний амь нас эрлэгийн элчийн гарт байна” гэв.

Тэр бүү хэл маш олон эрчүүд завин дээр тахир дутуу болсон, бүр амь насаа алдсан тухай ярьсан билээ.

“Хэрвээ америкчууд болон европчууд энэ загасыг идэж байгаа бол биднийг санах хэрэгтэй,” гэж Бенжинагаас зугтаж чадсан 30 настай боол Хлайн Мин хэлэв. **“Далайн ёроолд ясан уул бий болсон байж таарна. ... Ясан арал үүсэхээр тийм олон хүн үхсэн.”**

Бирм гаралтай боолуудын хувьд Бенжина бол дэлхийн төгсгөл.

Бенжина хот нь завиар таван минут явах зайд байрласан хоёр жижиг арал бөгөөд нийтдээ 3,500 орчим хүн амьдардаг. Өмнө нь “Spice Islands - Амтлагчийн арлууд” гэж нэрлэгддэг байсан **Малукугийн бүлэг аралд** багтдаг. Австралиас хойш 400 миль зайд орших ба жижиг кенгуру, гялалзсан өдтэй ховор парадайз шувуудаараа алдартай.

Жилийн зарим сард **Арафура тэнгис** борооны улиралд догширч, Бенжина руу завиар хүрэх боломжгүй болдог байна. Түүнчлэн интернэтийн сүлжээ бараг байхгүйтэй адил тул улам тусгаарлагддаг ажээ. Гар утасны сүлжээний анхны цамхагийг дөнгөж өнгөрсөн сард босгохоос өмнө, тосгоны иргэд өдөр бүр ойролцоох толгод руу авирч, мессеж илгээх дохио хайдаг байв. Олон жил ашиглаагүй нисэх зурвас ч бий.

Тосгоны боомт нь **Pusaka Benjina Resources** гэх компанийн мэдэлд байдаг бөгөөд таван давхар оффисын цогцолбор нь тэндхийн хамгийн содон барилга юм. Энд боолуудыг хорьдог торны хэсэг ч бий. Тус компани Индонезийн нутаг дэвсгэр дээр албан ёсоор бүртгэлтэй цорын ганц загас агнуурын үйл ажиллагаа эрхлэгч бөгөөд загасны тор тавьдаг 90 гаруй завьны эзэд эзэмшигчээр нь бүртгэлтэй. Эдгээр завины ахмад нь Тай гаралтай хэдий ч Индонезийн засгийн газрын зүгээс Тайландын өмч мөн эсэхийг шалгаж байгаа аж. Pusaka Benjina компани сэтгүүлчдийн утасны дуудлага, захидалд хариу өгөөгүйн дээр Жакарта дахь оффист нь хоёр цаг хүлээсэн сэтгүүлчтэй ч уулзаагүй юм.

Бенжинагийн боомт дээр боолын хөдөлмөр эрхэлж байсан хүмүүс хоногийн хоол, маш бага хэмжээний мөнгөний төлөө завинаас ачаа буулгадаг. Зарим нь тав, 10, бүр 20 жилийн өмнө хөлгийн ахмаддаа хаягдсан эрчүүд бөгөөд одоог хүрэл хаашаа ч явж чадахгүй гацсан хэвээр.

Ойн гүнд дунд зугтсан шинэ боолууд үргэлж хүнс хайн, борооны ус цуглуулж, боолын ангуучдад баригдахаас айж амьдардаг байна.

Хурц өнцөгт шүрээр бүрхэгдсэн элстэй эргийн ойролцоо, ширэнгэн ойд халхлагдсан нэгэн оршуулгын газарт олон арван загасчныг булшилсан. Тэднийг хууран мэхлэх замаар хөлөг онгоцонд суулгахдаа эсвэл зарагдах үед нь өгсөн хуурамч Тай нэрээр оршуулсан байдаг бөгөөд энэ нь тэдний туулсан зовлон зүдгүүр, хүчирхийллийн ул мөрийг үүрд далдалж байдаг хэмээн найзууд нь ярих.

“Би үргэлж орох хаалга байвал гарах хаалга ч мөн бий гэж боддог байлаа,” хэмээн тэнд хаягдсан боол Тун Лин Маунг хэлэхэд бусад эрчүүд дуугүй толгой дохиж эсвэл газар ширтэж байлаа. **“Одоо бол энэ худлаа гэдгийг ойлгосон.”**

Арафура тэнгис нь дэлхийн хамгийн олон төрлийн загасны баялаг нөөцтэй бүс бөгөөд тэнд маккерель, хулд, туна, наймаалж зэрэг олон төрлийн далайн амьтад бий.

Хэдий Индонезийн нутаг дэвсгэр боловч энэ бүс нутагт Тайланд зэрэг орноос ирсэн хууль бус загас агнуурын хөлөг онгоц олноороо байрлан ажилладаг. Үүнээс бий болсон худалдааны сүлжээ нь АНУ болон бусад улсынхтай ч нийлдэг.

АНУ Тайландыг далайн бүтээгдэхүүний гол нийлүүлэгчдийн нэг гэж үздэг. Тайландын долоон **тэрбум ам.доллараар хэмжигдэх далайн бүтээгдэхүүний экспортын 20 хувийг** АНУ эзэлдэг байна. Өнгөрсөн онд АНУ-ын Төрийн департамент Тайланд нь хүний наймаатай тэмцэх доод босго, шалгуур хангаж чадаагүй хэмээн **Хойд Солонгос, Сири, Иран** зэрэг улстай адилтган хар жагсаалтад оруулсан. Гэсэн хэдий ч нэмэлт хориг арга хэмжээ аваагүй хэвээр.



- 2015 оны 4-р сарын 1-ний Лхагва гарагт авсан энэ гэрэл зурагт Тайландын нэгэн албан тушаалтан Индонезийн Аругийн арлууд дахь Бенжина тосгонд орших оршуулгын газарт гадаадын загасчдын булшны зургийг авч байгааг буулгав. Гурван улсын албаны хүмүүс энэ жижиг аралд ирж, хэдэн мянган гадаадын загасчид яагаад боолын хөдөлмөрт татагдан тэнд баригдсан, мөн тэдний барьсан далайн бүтээгдэхүүн хэрхэн АНУ болон бусад улс руу экспортлогдож байсныг судлан мөрдөх ажил хийж байна.

АНУ-ын Төрийн департаментын нийлүүлэлтийн сүлжээний асуудал хариуцсан шинжээч **Кендра Крейдэр “Тайландын далайн бүтээгдэхүүний салбар ихэнхдээ цагаач ажилчдын хүнд хөдөлмөр дээр тогтдог”** хэмээв. Зарим ажилтны нөхцөл байдал нь АНУ-ын хуульд заасан **боолчлолын тодорхойлолтод багтдаг**. Үүнд хүмүүс анх сайн дураараа ажилд орсон байсан ч албадан үргэлжлүүлэн хөдөлмөр эрхлүүлэх, эсвэл хүний наймаагаар мөлжлөгт оруулах зэргийг багтаадаг.

Крейдэр үргэлжлүүлэн **“Хамгийн ноцтой жишээ бол хүнийг хулгайлж эсвэл мэхлэж авч ирэн завин дээр ажиллуулж, зодож, гинжлэн хүчээр байлгаж байна. Энэ бол ямар ч шалгуураар орчин үеийн боолчлол юм”** гэлээ.

Тайландын засгийн газар уг асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж буйгаа мэдэгдсэн. Энэ сарын эхээр Бостонд болсон **Хойд Америкийн хамгийн том далайн бүтээгдэхүүний үзэсгэлэнд** Тайландын **Загасны аж ахуйн газрын нэгэн төлөөлөгч** хөдөлмөрийн мөлжлөгийн эсрэг төлөвлөгөө танилцуулсан. Тус төлөвлөгөөнд цалингийн доод хэмжээ, өвчтэй үед амралт авах эрх, 14 цагаас хэтрэхгүй ээлж солих зэрэг шинэ хууль журам багтаж байв. Гэвч **Камонпан Авайванонт** нь Бенжина дахь нөхцөл байдлын талаар дэлгэрэнгүй сонсоод цочирдон, **“Одоо ч ийм байгаа гэж үү?”** гэж гайхан асуугаад, түр дуугүй болж, азнасхийснээ **“Энэ асуудал үргэлжилсээр байгаа ч бид шийдэхээр хичээж байна.”** гэв.

Тайландын засгийн газар мөн **далайн бүтээгдэхүүний салбарт ажиллаж буй хууль бус 100,000 гаруй цагаачдыг** багтаах үндэсний бүртгэлийн систем нэвтрүүлнэ гэдгээ амласан. Гэвч хууль сахиулах ажил улам хүндэрсээр. Учир нь хэдэн арван жилийн хууль бус загас агнуур нь эх газрын ойролцоох загасны нөөцийг шавхаж, загасчдыг улам хол, гадаад далай дахь дэндүү алслагдмал хэсгээс загас агнахад хүргэх болжээ.

Харин Индонезийн засгийн газар **гадаадын хууль бус загасчдыг** (тэд жил бүр хэдэн тэрбум ам.долларын далайн баялгийг хулгайлдаг) хөөн зайлуулахын тулд **түр хугацаагаар загас агнуурыг хоригложээ**. Үүний дүнд **50 гаруй завь Бенжинад зогсож**, эх газарт гацсан **боолуудын тоо 1000-д хүрсэн** байна.

Индонезийн албаны хүмүүс **далайд байгаа загас агнуурын завинуудаас ачаа тээврийн усан онгоцоор загас шууд тээвэрлэхийг хориглох хууль** хэрэгжүүлэхээр оролдож байна. Энэ төрлийн үйл ажиллагаа нь загасчдыг хэдэн сараар төдийгүй **бүр жилээр ч далайд** орогнож, яг л **усан дээрх шоронд байгаа мэт** болход хүргэдэг байна.

Индонезийн загасны аж ахуй эрхэлсэн шинэ сайд **Суси Пужиастути** загасны аж ахуйн зарим компани хүмүүсийг торонд хорьдог тухай сонссон, мэдэж байгаагаа илэрхийлсэн. Мөн Бенжина дахь ачигч чиргүүлүүд бодит байдал дээр Тайландын эзэмшил ч байж болзошгүйг тэмдэглэжээ. Тусгай зөвшөөрлийг хуурамчаар эсвэл давхардуулан бүртгэх явдал түгээмэл тул энэ нь боломжтой юм.

Тэрбээр Бенжина болон бусад аралд болж буй боолчлолын талаар гүнээ зовниж буйгаа илэрхийлэн

“Би үнэхээр гутаж байна. Хоолны дуршилгүй бол нойр ч хүрэхээ больсон. Тэд далайн хүнс нэрийн доор боолчлол, хулгай хийж, загасны нөөцийг барагдуулж, байгаль орчныг асар их сүйрүүлэн эзэнт гүрэн босгосон байна” гэсэн юм.

Тайландын далайн хүнсний салбар дахь боолчлолын түүх хэдэн арван жилийн өмнөөс эхтэй. Тодруулбал, дэлхий даяар эдийн засгийн цагаачлалыг хэлбэржүүлсэн push-pull буюу ядуурлаас ангижирч илүү сайхан амьдрал хайх хүслээс улбаатай.

Сүүлийн жилүүдэд экспортын салбар өргөжихийн хэрээр Бирм залуучууд, Камбож цагаачид болон ядуу Тайчуудыг (эдгээр хүмүүс бүгд Бенжинад илэрсэн) аюултай ажил хийхийг ятгах улам хэцүү болсон. Ажил зуучлагчид **аргаа** улам **нарийсган, харгис болж**,

хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг элсүүлэх, худал цалин амлах, бүр мансууруулах, хулгайлах зэрэг үйлдэл гаргах болсон тухай нэгэн зуучлагч ярьсан. Тэрбээр өшөө авалтаас айж буй учир нэрээ нууцлахыг хүссэн юм.

Зуучлагч хэлэхдээ, тэдгээр **боолыг Тай хөлгийн ахмадуудад эсвэл завь эзэмшигч компанид зардаг** аж. **Нэг боолын үнэ дунджаар 1,000 ам.доллар орчим байдаг гэж Тайланд дахь Хөдөлмөрийн эрх хамгаалах байгууллагын менежер Патима Тунгпучаяакул хэлэв.** Эрчүүдийг дараа нь **"өртэй"** гэж хууран, цалин өгөхгүйгээр сар, жилээр хүнд хөдөлмөр эрхлүүлж, бүр зарим тохиолдолд огт цалин өгдөггүй байна.

"Ажил олгогчид ажилчдын амь наснаас илүү загасанд санаа тавьдаг байх" гэж тэрээр хэлэв. **"Тэд ийм төрлийн бизнесээс маш их мөнгө олдог."**

Тайландын хууль бус завинуудыг Индонезид загас агнах эрхтэй мэт **хуурамчаар бүртгэдэг** бөгөөд **үүнийг авлига**, зарим тохиолдолд **төрийн албан тушаалтнуудын дэмжлэгтэй** хийдэг байна. Тайландын парламентын гишүүн асан **Прапорн Экоуру** энэ талаар **АР агентлагт бүгдийг очин, дэлгэрэнгүй тайлбарлаж өгсөн билээ.** Индонезийн албан тушаалтнуудад авлига өгч байсан тухайгаа ч ярьсан. Тэрбээр Индонезийн засгийн газрын дарамт шахалтын улмаас бизнес нь унаж байгааг мөн хэлэв.

"Өмнө нь бид Тайландаас завьнуудыг Индонезийн усанд загасчлуулахаар илгээдэг байсан. Тэгэхдээ далбааг нь сольж илгээдэг байсан" гэж **өмнөд Тайландын Сонкла мужийн Загас агнуурын холбоог тэргүүлдэг** Прапорн хэлээд, "Бид жил бүр хэдэн сая баат (ойролцоогоор сард 200,000 баат буюу \$6,100) авлига өгдөг байсан. ... Одоо бол төрөөс ийм захирамж ирсэн тул албан тушаалтнууд авлига авч чадахгүй болсон" гэжээ.

Хууль бус ажилчдад хуурамч бичиг баримт өгдөг. Тайландын завинууд бичиг баримтгүй хүн хөлсөлж ажиллуулах эрхгүй учраас тэр. Бенжинад боолын хөдөлмөр эрхэлж байсан **Маунг Со** гэх хүн өөрт нь **Тайландын иргэний нэр дээр бүртгэлтэй хуурамч "далайчны үнэмлэх"** өгсөн гэж яриw. Энэхүү баримт бол Индонезид **түр зорчих зөвшөөрөл** гэж хэлж болно. Тэрбээр үүнийхээ үрчийсэн хуулбарыг олж гаргаж ирэх гээд завь руугаа яаравчлав.



2014 оны 11-р сарын 27-ны Пүрэв гарагт хийсэн бичлэгээс тасалж авсан энэхүү зурагт Мьянмарын иргэн Маунг Со Индонезийн Бенжинад байхдаа Тайландын загас агнуурын завинд суухаас өмнө түүнд өгсөн далайчны үнэмлэхийн хуулбарыг барьсан байгааг харуулав.

Хууль бус ажилчдад хуурамч бичиг баримт өгдөг. Учир нь Тайландын завинууд бичиг баримтгүй хүмүүсийг ажилд авах эрхгүй. **"Энэ нэр минийх биш, гарын үсэг ч минийх биш,"** гэж тэр хэлэв. **"Энд байгаа цорын ганц жинхэнэ зүйл бол миний зураг л байна."** (АР гэрэл зураг/APTN бичлэгийн дүрс)

“Энэ нэр минийх биш, энэ гарын үсэг ч биш,” хэмээн Маунг Со уурсаж, элэгдэж хуучирсан цаасыг чичлэв. “Энд байгаа цорын ганц жинхэнэ зүйл бол миний зураг.”

Со хэлэхдээ, тэрээр зөвхөн Тайландын усанд ажиллах болзлоор загасчны завинд ажиллахыг зөвшөөрсөн аж. Учир нь өмнө нь **Индонези руу очсон хүмүүс дахин хэзээ ч буцаж ирдэггүй** гэсэн яриаг сонсож байсан ажээ.

“Тэд намайг хуурсан” гэж хэлээд, “Тэд надад худлаа ярьсан. Хуурамч бичиг баримт зохиогоод надтай хамт олон хүнийг завинд суулгасан, тэгээд би одоо энд, Индонезид байна.”

Боолуудын хэлснээр, завин дээрх дарамт, хүчирхийллийн түвшин нь тухайн ахмад болон туслахуудаас хамаардаг байна. Мьянмарт эхнэр, хоёр хүүхдээ үлдээгээд хоёр жилийн өмнө гарсан боол **Аун Наинг Вины** хэлснээр зарим боолууд сэтгэл гутралд хэт автсанаас **өөрсдөө ус руу үсрэн амиа хорлодог** байсан аж.

40 настай Вины хэлж буйгаар, **хамгийн зовлонтой ажил** нь хүйтэн өрөөнд олигтой хувцасгүй ажиллах байжээ. Тэнд **температур -39°C** хүрдэг байв.

“Хэтэрхий хүйтэн байснаас гар маань шатаж байгаа юм шиг өвддөг байсан” гэж тэр өгүүллээ. **“Үхэж байсан ч хэн ч тоохгүй.”**

АР агентлагийн мөшгөсөн ачилт нь Бенжина боомтоос гарсан бөгөөд **олон жижиг чиргүүлээр загас тээвэрлэв**. Сэтгүүлчид 10 гаруй завин дээрх боолуудаас ярилцлага авсан.

Загасыг **Silver Sea Line** гэх нэртэй **ачаа тээврийн хөргүүртэй** хөлөг рүү кранаар ачсан бөгөөд тус хөлгийн агуулахад бараг **50 чиргүүлтэй дүйцэх хэмжээний том**. Яг энэ мөчөөс эхлэн, тус агуулах дахь **бүх загас НҮБ болон АНУ-ын стандартын дагуу боолын хөдөлмөртэй холбоотой** гэж тооцогдох болов.

Энэ хөлөг **Тайландад бүртгэлтэй Silver Sea Reefer Co.** компанийн өмч бөгөөд ийм **хөргүүртэй ачааны есөн онгоцтой**. Гэсэн ч компани загасчидтай холбоогүй хэмээн мэдэгдсэн билээ. **“Бид зөвхөн тээвэрлэлтийг хариуцдаг. Ерөнхийдөө үйлчлүүлэгчид биднийг хөлсөлдөг”** хэмээн эзэн **Паня Луангсомбун** хэлжээ. **“Бид загасны завинуудтай холбоогүй.”** гэв.

АР агентлаг тус хөлгийг **хиймэл дагуулын тусламжтайгаар 15 хоног хянаж, Тайландын Самут Сакон** хотод ирэхийг нь мөрдөв. Хөлөг боомтод ирмэгц ажилчид барааг **дөрвөн шөнийн турш 150 гаруй ачааны машинд** ачиж, хот даяар түгээжээ.

Дэлхий даяар хөлдөөсөн болон лаазалсан далайн бүтээгдэхүүн нийлүүлдэг **Kingfisher Holdings Ltd.** компанийн нэр, шувуун дүрст лого нь тэнд ирсэн нэгэн ачааны машин дээр байв. Өөр бас нэг машин нь **Mahachai Marine Foods Co.** хэмээх хүйтэн агуулах бүхий компанид очив. Энэхүү компани Kingfisher болон бусад экспортлогчдод нийлүүлдэг гэж Кавин Нгернанэк хэлжээ. Түүний гэр бүл уг компанийг удирддаг аж.

Кавин гэх энэ эрхэм **Тайландын Далайн Загас агнуурын экспортын холбооны төлөөлөгч** бөгөөд **“Тийм, тийм. Kingfisher олон төрлийн бүтээгдэхүүн авдаг”** гэж ярих.

Гэхдээ **боолын хөдөлмөрийн талаар тодруулахад Kingfisher хариу өгсөнгүй. Mahachai компанийн менежер Наронгдет Прасертсри “Надад энэ талаар ямар ч ойлголт байхгүй” хэмээн хариулав.**

АНУ-ын Гаалийн мэдүүлгээс харахад **Kingfisher болон түүний охин компани KF Foods Ltd.** нь сард **ойролцоогоор 100 тонн далайн бүтээгдэхүүн** Тайландаас АНУ руу экспортолдог. Ингэж тээвэрлэсэн бараанууд **Santa Monica Seafood, Stavis Seafoods** (Бостоны түүхэн Fish Pier дээр байрладаг) болон бусад түгээгч компаниудад очсон байна.

Өвөөгийнхөө 1929 онд байгуулсан Stavis Seafoods-ийг удирдаж буй **Ричард Ставис** тэдний компанид нийлүүлэгдсэн бүтээгдэхүүн боолын хөдөлмөрийн үр дүнд бий болсон байж болзошгүй талаар сонсоод толгой сэгсэрлээ. Тэрбээр **“Манай компани боловсруулагч үйлдвэрүүд болон загасны аж ахуйд өөрсдийн биеэр шалгалт хийдэг, хууль ёсны үйл ажиллагааг нь гэрчлэх нотариатын бичиг, гуравдагч талын аудитыг ашигладаг”** гэв.

“Үнэндээ ийм зүйлүүдээс болж шөнө нойр ч хүрдэггүй юм” хэмээн тэрээр үргэлжлүүлэв. “Энэ бол миний зогсоохыг хүсдэг зүйл. ... Бидэн шиг хичээж байгаа компаниуд ч бий.”

Ставис зэрэг **бөөний худалдаачид** загасыг **брэндтэй болон брэндгүй багц** хэлбэрээр нийлүүлдэг бөгөөд супермаркетын лангуун дээр **хувийн шошго** эсвэл **дэлгүүрийн нэрээр тавигддаг**. Стависийн үйлчлүүлэгчдийн дунд **АНУ-ын хамгийн том хүнсний түгээлтийн компани Sysco** ч багтдаг. Гэвч тухайн нэг загас яг аль компанид очсон гэдгийг тодорхойлох арга байхгүй.

Sysco компани ярилцлага өгөхөөс татгалзсан ч, тэдний ёс зүйн дүрэмд **“Бид албадан хөдөлмөр, өртэй боолчлол, гэрээнд хүлэгдсэн хөдөлмөр, боолын хөдөлмөр ашигладаг гэдэг нь илт буй ханган нийлүүлэгчидтэй хамтран ажиллахгүй”** хэмээн заасан байдаг.

АНУ-ын далайн бүтээгдэхүүний салбарын 75 хувийг төлөөлдөг National Fisheries Institute-ийн төлөөлөгч Гэвин Гиббонс **“Илэрсэн дарамт, хүчирхийллийн талаарх мэдээллүүд сэтгэл түгшээмээр, итгэл алдармаар аймшигтай байна”** хэмээн хэлээд “Гэвч иймэрхүү зүйлүүд харанхуй, хяналтгүй орчинд амархан цэцэглэдэг” гэлээ.

Самут Сахон боомт дахь нийлүүлэлтийн сүлжээ маш олон чиглэлд салаалдаг бөгөөд өөр тээвэрлэлт, компаниудад ч ийм жишээ бий. Энд боолын хөдөлмөрөөр баригдсан загасны мөр алдагдаж эхэлдэг.

AP-ийн багийн мөрдсөн өөр нэг машин **Niwat Co. компанид** хүрсэн. Энэхүү компаниас Thai Union Manufacturing Co. компанид нийлүүлэгддэг гэж хамтран эзэмшигч Прасерт Луангсомбун хэлэв. Түүнчлэн боолын хөдөлмөртэй холбоотой асуултад Niwat хариулахаас татгалзаж, бүх лавлах асуултыг Луангсомбун хэмээх хүн рүү чиглүүлэв. Гэвч түүнтэй холбогдож чадаагүй.

Thai Union Manufacturing бол Thai Union Frozen Products PCL групп (Тайландын хамгийн том далайн бүтээгдэхүүний компани, жилийн орлого нь 3.5 тэрбум доллар)-ийн охин компани. Thai Union нь Chicken of the Sea брэндийг эзэмшдэг ба Bumble Bee компанийг худалдан авах үйл явцад оролцож байгаа. AP энэ үед туна загасны аж ахуйг хөөж мөшгөөгүй. Гэхдээ 2024

оны есдүгээр сард Thai Union компани нь Dow Jones-ийн тогтвортой хөгжлийн шалгуур хангасан анхны Тайландын бизнес болон бүртгэгдсэн байдаг.

Thai Union хүний эрхийн зөрчлийг буруушааж буй ч олон талын төлөөлөгчид шийдвэр гаргах үйл явцад оролцох ёстой гэж мэдэгдсэн. **“Тайландын далайн бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сүлжээ 100 хувь цэвэр гэж батлах хэцүү гэдгийг бид бүгд хүлээн зөвшөөрөх хэрэгтэй”** хэмээн гүйцэтгэх захирал Тирафонг Чансири цахим шуудангаар мэдэгджээ.

Thai Union нь АНУ руу Fancy Feast, Meow Mix, Iams зэрэг муурны тэжээлийн түгээмэл олон брэндийн бүтээгдэхүүнийг экспортолдог. Эдгээр нь Kroger, Safeway, Albertsons зэрэг супермаркет болон амьтны дэлгүүрүүдийн лангуу дээр очино. Гэвч яг алинд нь боолчлолоор барьсан загас агуулсан эсэхийг мэдэх боломжгүй.

Thai Union-ийн шууд харилцагчдын нэг нь Wal-Mart бөгөөд тэд ярилцлага өгөхөөс татгалзсан ч имэйл-р илгээсэн мэдэгдэлдээ **“Бид нийлүүлэлтийн сүлжээний ажилчдыг үргэлж анхаардаг. Бид ёс зүйтэйгээр ажилд авах процесст анхаарч ажилладаг”** хэмээсэн байв.

Wal-Mart Тайландад боолчлолыг устгах чиглэлд Project Issara зэрэг ТББ-уудтай хамтран ажилладаг гэж мэдээлээд, Лиза Ренд Тейлорт хандахыг зөвлөсөн. Лизагийн хэлж буйгаар боолын хөдөлмөрөөр баригдсан далайн бүтээгдэхүүн нийлүүлэлтийн сүлжээнд олон шат дамжлагаар илрэхгүйгээр нэвтэрч болдог аж. Жишээлбэл, завь хооронд загас шилжүүлэх үед, эсвэл боловсруулах үйлдвэрүүдэд **“цэвэр”** загастай холилдох үед гэх мэт. Тэр мөн Talay Thai захад ирж буй загаснууд (AP хэд хэдэн машиныг дагаж энэ захад очсон) олон улсын нийлүүлэлтийн сүлжээнд орж болдог гэдгийг баталсан.

“Тайландын далайн хүнсний нийлүүлэлтийн сүлжээ дэх нийлүүлэлтүүд хангалттай бүртгэгдэж чаддаггүй тул дэлхий даяар супермаркетуудад нийлүүлэгдэж буй далайн бүтээгдэхүүний яг хэчнээн хувьд нь боолын хөдөлмөр оролцсон бэ гэдгийг үнэлэхэд маш хэцүү” гэж тэр нэмж хэллээ.

Thai Union, Kingfisher зэрэг компанийг багтаадаг аж үйлдвэрийн паркийн тэргүүн Пож Арамватанот **“Тайчууд ойн хүмүүс биш шүү дээ. Хүний наймаа гэмт хэрэг гэдгийг бид мэдэж байна”** гэв. Гэсэн ч тэрбээр Тайландын компаниуд загасны гарал үүслийг үргэлж тогтоож чаддаггүйг хүлээн зөвшөөрөв. **“Бид Индонезоос загас худалдаж авахдаа яг хаанаас ирсэн гэдгийг мэддэггүй. Бичиг баримт ч байхгүй. Тэр загас сайн уу, муу юу гэдгийг мэдэх аргагүй.”**

Бенжина дахь боолуудын барьсан загас дэлхий даяар түгэж байж болох ч тэдгээх хүмүүсийн нэг насны амьдрал энэ жижиг арал дээр төгсдөг.

Энд өндөр өвс, ширэнгийн ургамалд дарагдсан 60 гаруй булш бүхий бүдүүлэг оршуулгын газар байгаа бөгөөд жижиг модон тэмдэглэгээтэй. Зарим дээр нь боолуудын болон завинуудын хуурамч нэрийг бичсэн байна. Зөвхөн найзууд нь л аль булш хэнийх вэ гэдгийг санаж байдаг.

Өмнө нь боолчдогдож байгаад ангижирсан Хла Пье хэлэхдээ, ахмадууд хөлөг дээр нас барсан хүмүүсийн цогцсыг шууд далайд хаядаг байсан. Харин хожим компаниуд болон хяналтын байгууллагууд хүн бүрийн бүртгэлийг шаардах болсноор, цогцсыг загастай хамт хөлдөөгчид хадгалж, Бенжинад ирэх хүртэл тээвэрлэдэг болжээ.

Өтгөн өвсөн дундуур өвдөгөө өргөж алхсаар Хла Пье хамт оршуулсан хоёр найзынхаа булшийг хайж байлаа.

Тэрбээр өөрөө энэ арал дээр боолчлолоос зугтаж ирснээс хойш таван жил өнгөрчээ. Тэр орой бүр Мьянмарт суугаа ээжийгээ санадаг бөгөөд нас ахиж яваа ээждээ буцаж очихыг маш их хүсдэг. Гэвч нэр нь мэдэгдэхгүй олон булшны дунд зогсоход итгэл найдвар нь унтарч, гүн гунигт нөмрүүлэх аж.

“**Би Индонезид үүрд үлдэх юм шиг мэдрэмж төрж байна” гэж нулимсаа арчин хэлэв. “Би найзыгаа оршуулах гээд газар ухаж байхдаа эндээс явах цорын ганц арга бол үхэл юм байна гэж бодсон.**

*Энэхүү эрэн сурвалжлагад: **Эстер Хтусан** (Бенжина, Индонези) **Мэйсон** (Самут Сахон, Тайланд) **Мендоза** (Бостон, Массачусетс) гэсэн байршлуудаас сурвалжлагуудаа нийлүүлж, бэлдсэн билээ.*

Энэхүү гарын авлагыг дагалдуулан дэлгэрүүлэн судлах дараах сургалтын багц хэрэглэгдэхүүнийг нэмэлтээр бэлтгэсэн болно.

- Сургагч багшид зориулсан PPT хэлбэрийн 49 нүүр бүхий хоёр төрлийн слайд
- Сургагч багшийн хөтөч буюу слайдыг дэлгэрүүлэн тайлбарлах 20 нүүр бүхий хоёр төрлийн нэмэлт WORD файл
- Дасгал ажил – сургалтын явцад оролцогчдоор ажиллуулах 6 төрлийн дасгал ажлын зааварчилгаа, тайлбар болон хариулт
- Бизнес дэх Хүний эрх сэдвийн хүрээнд нийтлэгдсэн сэтгүүл зүйн бүтээлүүд /асуудал хөндөж, эрэн сурвалжилсан сэтгүүл зүйн 5 бүтээл/
- Бизнес дэх Хүний эрх сэдвийн хүрээнд оюутан залуучуудын 15 цуврал бичвэр



Хэрэв та дээрх сургалтын нэмэлт хэрэглэгдэхүүнээс авахыг хүсвэл Хэвлэл Мэдээллийн Зөвлөл ТББ-ын Ажлын албаны info@mediacouncil.mn хаягаар холбогдож хүсэлтээ илэрхийлнэ үү.



Сэтгүүл зүйн цуврал бүтээл, оюутнуудын бичвэрийг www.mediacouncil.mn; tentsuu.mn сайт болон Хэвлэл Мэдээллийн Зөвлөл ТББ Facebook - ээс танилцаарай.



Холбогдох утас: 7000-0160 /Хэвлэл Мэдээллийн Зөвлөл ТББ/

